



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

ХОС ХЭЛНИЙ БОЛОВСРОЛЫН БОДЛОГО, АРГА ЗҮЙГ САЙЖРУУЛАХ НЬ



ХОС ХЭЛНИЙ БОЛОВСРОЛЫН БОДЛОГО, АРГА ЗҮЙГ САЙЖРУУЛАХ НЬ

Б. ЖАДАМБА

*Академич, МУБИС-ийн
зөвлөх профессор*



Улаанбаатар хот
2023 он

ННА-60
ДАА-300
Ж-121



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

ХОС ХЭЛНИЙ БОЛОВСРОЛЫН БОДЛОГО, АРГА ЗҮЙГ САЙЖРУУЛАХ НЬ

© Нээлттэй Нийгэм Форум, 2023 оны 3 сар

Тус тайлангийн дүгнэлт, санал зөвлөмж нь Нээлттэй Нийгэм Форумын албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй бөгөөд зөвхөн судлаачийн хувийн байр суурь, дүгнэлт болно.

Хаяг:

Жамьян гүний гудамж
Сүхбаатар дүүрэг
Улаанбаатар 14240
Утас: 976-73113207
Веб: <http://www.forum.mn>
И-мэйл: osf@forum.mn

“Би Си Ай” ХХК-д эхийг бэлтгэж, хэвлэв.

ISBN: 978-9919-9990-2-5

АГУУЛГА

Товчилсон үгийн жагсаалт.	4
Зураг, хүснэгтийн жагсаалт	5
Удиртгал	7
Бүлэг 1. Хос хэлт нийгэм, хос хэлний боловсролын талаарх онол: олон улсын туршлага, сургамж.	13
Бүлэг 2. Монгол Улс дах хос хэлний боловсролын өнөөгийн байдал, хэрэгжилт	39
Бүлэг 3: Хос хэлний боловсролын үр дүн.	60
Бүлэг 4: Хос хэлний сургалтын арга зүйг шинэчлэн сайжруулах санаачилга	62
Бүлэг 5. Санал буюу Хос хэлний дэвшилтэт арга зүйд суурилсан хос хэлний боловсролын хөтөлбөрийн загварчлал	67
Бүлэг 6. Дүгнэлт буюу хос хэлний боловсролын тулгамдсан асуудлуудын тойм	74
Зөвлөмж	83
Ном зүй	86

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АХБ	Азийн Хөгжлийн Банк
АХИС	Английн Хүүхдийг Ивээх Сан
АХИС	Агуулга ба хэлийг интеграцчилан сурахуй
БСУТ	Боловсрол, соёл, урлагийн газар
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
БХ	Боловсролын хүрээлэн
ЕБС	ерөнхий боловсролын сургууль
МУБИС	Монгол Улсын Боловсролын Их Сургууль
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
СӨБ	сургуулийн өмнөх боловсрол
ТБВ	төрийн бус байгууллага
X1	эх хэл; хэлний олонхын хувьд монгол хэл, хэлний цөөнхийн хувьд казах, тува хэл
X2	эх хэлний дараа эзэмшсэн хоёрдох хэл; хэлний олонхын хувьд эхний гадаад хэл, хэлний цөөнхийн хувьд монгол хэл
УИХ	Улсын Их Хурал
ҮЦГМХБСС	Үндэсний цөөнх ба гадаадад байгаа монголчуудын хэлний боловсролын судалгааны сектор
ЭЕШ	Элсэлтийн ерөнхий шалгалт
ЮНЕСКО	НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага
ЮНИСЕФ	НҮБ-ын Хүүхдийн Сан

ЗУРАГ, ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.	Судалгааны дизайны бүдүүвч	11
Зураг 2.	Хос хэлний хасагдах загвар.	23
Зураг 3.	Хос хэлний нэмэгдэх загвар.	25
Зураг 4	Хос хэлний рекурсив загвар	28
Зураг 5.	Хос хэлний динамик загвар.	29
Зураг 7.	Хос хэлний боловсролын бодлогын орчил, оролцогчдын харилцааны зураглал.	72
Хүснэгт 1.	Монгол, казах, тува хэлний тархац	14
Хүснэгт 2.	Хэлний бодлогын гурван загвар	18
Хүснэгт 3.	Хэлний талаарх үзэл баримтлал, бодлогын бүтэцчилсэн хүрээ.	21
Хүснэгт 4.	Хос хэлний боловсролын бодлогын дөрвөн загвар . . .	22
Хүснэгт 5.	Эрт үеийн шилжилтийн аргазүй	23
Хүснэгт 6.	Шилжилтийн хос хэлний боловсролын аргазүй . . .	24
Хүснэгт 7.	Өвлөгдөх хос хэлний боловсролын арга зүй	26
Хүснэгт 8.	Хэлний орчин бүрдүүлсэн хос хэлний боловсролын арга зүй	26
Хүснэгт 9.	Хүлээн авагч ба бүтээгч хос хэлний харьцуулалт . .	32
Хүснэгт 10.	Хорнбергийн хос хэлний боловсролын загвар	34
Хүснэгт 11.	Хос хэлний боловсролын бодлого, хөтөлбөрийн хамаарал.	35
Хүснэгт 12.	Хос хэлний боловсролын амжилтад нөлөөлөгч бодлогын зургаан хүчин зүйлс	39
Хүснэгт 13.	Эх болон албан ёсны хэлний талаарх эрх зүйн орчин .	45
Хүснэгт 14.	2019-2020 оны Элсэлтийн ерөнхий шалгалтын дүн. .	61

- Хүснэгт 15. Цөөнхийн эх хэл (X1) ба монгол хэл (X2)-ний
хуваарилалтын харьцааг анги, судлагдахуун, хувиар
харуулсан жишиг загвар 64
- Хүснэгт 16. Хоёр хэлний харилцан хамаарал, хамтран оршихуйн 4
хувилбар. 68
- Хүснэгт 17. Хос хэлний сургалтын төлөвлөгөөнд хоёр хэлний
тэнцвэртэй хэрэглээг хангах цагийн хуваарилалт . . . 72
- Хүснэгт 18. Хасагдах хандлагад суурилсан шилжилтийн хос хэлний
боловсролын хөтөлбөрийн загвар: монгол, тува хос
хэлний боловсролын жишээ 79
- Хүснэгт 19: Нэмэгдэх хандлагад суурилсан, дэмжин хөгжүүлэх
зорилготой хос хэлний хөтөлбөрийн загвар: монгол,
казах хос хэлний хэлний хөтөлбөр 80

УДИРТГАЛ

ОРЧИН ЦАГИЙН МОНГОЛЫН ХЭЛ, СОЁЛЫН ЦӨӨНХИЙН ТУХАЙ

Монгол Улс нь хүмүүнлэг, ардчилсан, нийтэд хүртээмжтэй, тасралтгүй¹ боловсролыг үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, хөгжлийн онцлог, эрүүл мэнд, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлахгүй² бүх иргэнд хүргэх зарчимд суурилсан боловсролын үйлчилгээг тэргүүлэх салбар болгон хөгжүүлэхийг³ хуульдаа тунхагласан байдаг. Цаашилбал, Монгол Улсын иргэн суурь буюу 1-9 дүгээр ангийн боловсролыг заавал эзэмших үүрэгтэй.⁴ Боловсролын үйлчилгээг тэгш хүртээмж, ижил чанартай хүргэх ажлыг төлөвлөн зохион байгуулах, хэрэгжүүлэх зорилтын хүрээнд тулгамдаад буй нэг асуудал нь хэлний цөөнх хүүхдүүдэд хос хэлний чанартай боловсролыг хүргэж сурч боловсрох эрхийг нь бүрэн дүүрэн хангах асуудал юм.

Үндэстний цөөнх гэж тухайн улсын хүн ам дотор тооны хувьд олонх болохгүй, олонх хүн амаас угсаатан, хэл, соёл, шашин шүтлэг зэргээр ялгаатай хүмүүсийг ойлгож байна.⁵ Монгол Улсын нийт хүн амын 95 гаруй хувийг монгол эх хэлтэй иргэд бүрдүүлж байна. 2020 оны Хүн ам, орон сууцны улсын тооллогын нэгдсэн дүнгээр хэлний цөөнх болох казахууд нийт Монголын хүн амын 3,8 хувийг, тувачууд 0,1 хувийг, цаатан (духа) нар 0,02 хувийг тус тус бүрдүүлж байна. Нийт казах хүн амын 35,9 хувь нь 0-14 насныхан, 17,1 хувь нь 15-24 насныхан, тувачуудын 65 хувь нь 0-14 насныхан, 13,4 хувь нь 15-24 насныхан байна. Цаатнуудын 75 хувь нь 0-14 насныхан, 14,4 хувь нь

1 Боловсролын тухай хуулийн 5.1.2

2 Боловсролын тухай хуулийн 5.1.4

3 Боловсролын тухай хуулийн 5.1.1

4 Боловсролын тухай хуулийн 6.3

5 UNHCHR, Fact Sheet No18, Minority Rights. Эх сурвалж: Б.Хишигсайхан (он байхгүй). Үндэсний цөөнхийн эрхийн хэрэгжилт илтгэл, <http://www.globelinter.org.mn/images/upld/Xishigsaikhan%20iltgel.pdf>

15-24 насныхан байна.⁶ Үндэстний цөөнх хүн амын дийлэнх хувь нь хүүхэд залуучууд байгаа нь тэдний боловсролын асуудлыг улам их чухал болгож байна.

Үндэстний цөөнх төвлөрөн амьдардаг Баян-Өлгий аймгийн Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын дүнгээр тус аймгийн хүн амын 91,0 хувийг казахууд, 5,6 хувийг урианхай, 0,9 хувийг дөрвөд, 0,9 орчим хувийг халх, 0,8 хувийг тувачууд бүрдүүлж байна. Хөвсгөл аймгийн нийт хүн амын 0,1 хувийг цаатан (духа) эзэлж байна.⁷ Тархалтын хувьд казахуудын 70-80 хувь нь Баян-Өлгий аймагт, 5,1-9,9 хувь нь Ховд аймагт, 1-5 хүртэлх хувь нь Улаанбаатар хотод, мөн Орхон, Дархан-Уул, Сэлэнгэ аймагт 0,1-0,9 хувь нь амьдарч байна. Боловсролын үйлчилгээний хувьд хос хэлний боловсролын хөтөлбөр зөвхөн Баян-Өлгий аймагт хэрэгжиж байгаа бөгөөд казах, тува хүүхдүүдийн хос хэлний боловсролын хөтөлбөр ялгаатай боловсруулагджээ. Бусад аймаг, хот суурин газар амьдарч байгаа хэлний цөөнх хүүхдүүдэд зориулсан хос хэлний боловсролын үйлчилгээ байхгүй, мөн эх хэлээ сурах хичээлийн бус цагийн төлбөрт болон нэмэлт үйлчилгээ алга байна.

Олонхоос өөр эх хэлтэй хүүхдүүд эх хэлээрээ бичиг үсэг тайлагдаад, цааш үргэлжлүүлэн тухай улсын төрийн үйл хэргийг явуулдаг албан ёсны хэлийг эзэмших хос хэлний боловсрол нь олон талын ач холбогдолтой. Монгол Улсын иргэн казах, тува, цаатан-тува хүүхдүүд эх хэлээрээ боловсрол эзэмшихийн⁸ зэрэгцээ монгол хэл дээр боловсрол олох нь эх хэл, соёлоо өвлөн хадгалахын зэрэгцээ улс орныхоо улс төр, нийгэм, эдийн засгийн амьдралд идэвхтэй оролцоотой иргэн байх боломжийг бий болгоно. Харин ийм нөхцөлийг хангах, сургуулийн түвшинд хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх нь нэг талаас цөөнхийн хэл, соёлын эрх, хүүхдийн сурч боловсрох эрх, нөгөө талаас боловсролыг үл ялгаварлах зарчмаар зохион байгуулж хүргэх төрийн үүргийн огтлолцол дээр орших чухал асуудал бөгөөд

6 Эх сурвалж: https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Population_growth__age_group_2020.pdf&ln=Mn

7 Эх сурвалж: <https://1212.mn/BookLibrary.aspx?category=001>

8 Боловсролын тухай хуулийн 5.1.4

үүнийг чанартай сайн хос хэлний боловсролын бодлого, хөтөлбөрөөр дамжуулан шийднэ.

Сургалтын хөтөлбөрт багтсан хичээлүүдийг зааж, агуулгыг нь эзэмшүүлэхэд хоёр өөр хэл ашигласан сургалтын хоёр хэлтэй хөтөлбөрийг хос хэлний боловсролын хөтөлбөр гэж нэрлэдэг. Тодорхой хэлийг эзэмшүүлэхэд чиглэсэн бие даасан хичээл (жишээлбэл, монгол хэлний, англи хэлний хичээл) орж байгааг хос хэлний боловсрол гэхгүй. Бүх хичээлийг монгол хэл дээр зааж, англи хэлний бие даасан хичээл орж байгаа бол хос хэлний бус, харин англи хэл заадаг сургууль юм. Харин сургалтын хөтөлбөрт багтсан нийт хичээлийн зарим нь монгол хэл дээр, зарим нь англи хэл дээр заагддаг бол монгол, англи хос хэлний сургалттай сургууль байж болно.

Хэлний цөөнхийн тухайд монгол, англи хэлнээс арай өөр нөхцөлтэй байх нь ойлгомжтой. Хэлний цөөнх нь сонголтоор хэл нэмж судалж байгаа бус, харин өөрийн төрөлх хэл, соёлыг өвлөж авах үүднээс эх хэлээ эзэмшин, нийгмийн амьдралд оролцохын тулд төрийн албан ёсны хэлийг сурах зайшгүй шаардлагаар хос хэлтэн болж буй үндэстний цөөнх иргэд юм. Улмаар хэлний цөөнх хүүхдүүдийн боловсрол бол хос хэлний боловсрол байх зайлшгүй шаардлагатай. Мэдээж, хэлний цөөнх хүүхдүүдийн боловсролын боломж хувьд хоёр хэлээр хязгаарлагдахгүй бөгөөд эх болон албан ёсны хэл дээр нэмж гадаад хэлнүүд эзэмших боломж нээлттэй. Энэхүү судалгаа нь цөөнх хүүхдүүдэд эх болон төрийн албан ёсны хэл дээр боловсрол олгох хос хэлний боловсролын онол, практикийн асуудлаар хүрээгээ хязгаарлаж байгаа болно.

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Уг судалгааг Монгол Улсад хэлний цөөнх хүүхдүүдэд хос хэлний боловсролыг хүртээмжтэй, чанартай хүргэх бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг болох хос хэлний боловсролын онол, хөтөлбөрийн хувилбаруудыг хэтийн буюу нийгэмд гарах үр дүн, үр дагавартай нь холбон шинжлэх замаар хэлний болон боловсролын бодлого, хөтөлбөр, арга зүйн харилцан хамаарлыг харуулан, өнөөдөр Монголд хэрэгжүүлж байгаа хос хэлний сургалтын практик жишээнүүдтэй

харьцуулан дүгнэх замаар үр дүнтэй хэрэгжүүлж болох хос хэлний боловсролын бодлого, хөтөлбөр, арга зүйг зураглах зорилготой болно.

Дээрх зорилгын хүрээнд дараах тодорхой зорилтуудыг дэвшүүлсэн бөгөөд үүнд:

- ▶ Хэлний цөөнх хүүхдүүдийн хос хэлний боловсролын талаарх онолын хандлагуудыг судлан тоймлох;
- ▶ Хос хэлний боловсролын бодлогын загвар, тэдгээрийн үр нөлөө, хэрэглэж ирсэн туршлага, сургамж болон хүний эрхийн суурьтай өнөөгийн чиг хандлагыг тодорхойлох;
- ▶ Монгол Улсын хос хэлний боловсролын бодлого, эрхзүйн орчин, хэрэгжилт, үр дүнг олон улсын сайн туршлагатай харьцуулан шинжлэх замаар алдаа, оноо, гарсан амжилтаа тоймлож харах;
- ▶ Монгол Улсын хос хэлний боловсролын бодлого, аргазүйг сайжруулах, түүнийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд чиглэсэн бодлогын зөвлөмж боловсруулах зэрэг болно.


Улмаар энэхүү судалгаа нь мэдлэг шинээр үйлдвэрлэх зорилготой онолын судалгаа бус, харин хэрэгжиж буй бодлогыг сайжруулах зорилготой практик түвшний бодлогын судалгаа тул зөвлөмж агуулж байгаа болно.

Уг судалгааг дараах арга зүйгээр хэрэгжүүлсэн бөгөөд үүнд:

- ▶ Онолын судалгааг хоёрдогч эх сурвалж ашиглан, англи хэл дээрх онолын эх сурвалжуудад давамгайл түшиглэн баримтын шинжилгээний аргаар гүйцэтгэв.
- ▶ Эрх зүйн орчны судалгааг холбогдох хууль, журам, төрийн болон төрийн бус оролцогчдын судалгааны дүгнэлт зэрэгт түшиглэн баримтын шинжилгээний арга зүйгээр гүйцэтгэсэн бөгөөд зарим асуудлаар төрийн байгууллага, судлаач, мэргэжилтнээс авсан тодруулга, тайлбар нь анхдагч мэдээлэл цуглуулалтад тооцогдохгүй, нэмэлт, тайлбарын шинжтэй болно.
- ▶ Онолын болон эрх зүйн орчны судалгаатай зэрэгцүүлэн олон улсын туршлагыг баримтын шинжилгээний арга зүйгээс гүйцэтгэв.

- ▶ Баримтын шинжилгээгээр ерөнхий зураглал гаргасны дараа анхдагч мэдээлэл цуглуулан өнөөгийн нөхцөл байдлыг үнэлэх, шийдэх шаардлагатай асуудлуудыг тодорхойлох шинжилгээг хэрэгжүүлэв. Энэ үе шатанд уг асуудлаар ажилладаг судлаач, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл, идэвхтэн, орон нутгийн засаг захиргаа болон боловсролын нэгжийн албан тушаалтан, сонирхлын бүлгийн төлөөллөөс ганцаарчилсан ярилцлага, жижиг бүлгийн хэлэлцүүлэг, ярилцлага хийх боломжгүй үед бичгээр/ асуумжаар мэдээлэл цуглуулж, шинжилгээ хийсэн болно.
- ▶ Удаах шатанд цуглуулсан материал, нотолгоонд боловсруулалт хийж, тайлан бичив.
- ▶ Тайлангийн эхийг судалгаанд оролцогчидтой хэлэлцэх, сайжруулах санал авч, тайланд тусган эцэслэн бичих ажлыг гүйцэтгэв.

ЗУРАГ 1. Судалгааны дизайны бүдүүвч



СУДАЛГААНЫ АСУУЛТУУД

Судалгаа нь дараах гурван багц асуултын хүрээнд тус бүртээ судалгааны онцлог аргуудын цогцоос бүрдэж байгаа бөгөөд үүнд:

- ▶ Цөөнхийн хүүхдэд хос хэлний боловсрол эзэмшүүлэх чиглэлд олон улсад хүлээн зөвшөөрөгдөн, цөөнхийн хэл, соёлын эрхийг хүндэтгэсэн онолын ямар хандлага, хөтөлбөрийн загвар, хэрэгжилтийн сайн туршлага байна вэ?
- ▶ Олон улсын сайн туршлагад түшиглэн харах юм бол Монгол Улсад хэлний цөөнх хүүхдүүдийн хос хэлний боловсролын бодлого, практикийг хэрхэн үнэлэх вэ?
- ▶ “Хос хэлний боловсролын дэвшилтэт бодлого, үр нөлөөтэй хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэхэд бодлого боловсруулагч, хэрэгжүүлэгч, сонирхогч талууд юу анхаарах ёстой вэ?” гэсэн асуултын хүрээнд зөвлөмж боловсруулав.

Судалгааны үр дүнг нэгтгэн дараах бүтэц бүхий тайлан боловсруулсан бөгөөд үүнд:

- ▶ Хос хэлний боловсролын талаарх олон улсын туршлага, сургамж хэсэгт хос хэлт нийгэм, хос хэлний боловсролын талаарх онол, арга зүй, хөтөлбөрийн шийдлүүдээс бидэнд туршлага, мэдлэг болох агуулга;
- ▶ Монгол Улсын хос хэлний боловсролын өнөөгийн байдал, хэрэгжилт хэсэгт хос хэлний боловсролын эрх зүйн орчин, түүнийг хэрэгжилтэд үнэлгээ, дүгнэлт өгөхийн зэрэгцээ хос хэлний бодлогын хэрэгжилтийг дэмжих нөлөөтэй боловсролын дэд бүтэц, хэлний орчин, нийгмийн хандлагын хүчин зүйлсийн тойм;
- ▶ Хос хэлний боловсролын хөтөлбөрийн арга зүйг шинэчилж, үр дүнг сайжруулах санаачилга хэсэгт өнөө цагт үр нөлөөтэй нь олон улсын туршлагаар нотлогдсон, манай улсад амжилттай туршиж буй шинэлэг арга зүй;
- ▶ Дүгнэлт хэсэгт өмнөх бүлгүүдийн агуулгыг тоймлон, хос хэлний боловсролын тухайд тулгамдаад буй асуудлуудын тойм;
- ▶ Зөвлөмж хэмээх сүүлийн бүлэгт бодлого, шийдвэр гаргагч, хэрэгжүүлэгч нарт хандсан зөвлөмжөө зэрэг болно.

БҮЛЭГ 1. ХОС ХЭЛТ НИЙГЭМ, ХОС ХЭЛНИЙ БОЛОВСРОЛЫН ТАЛААРХ ОНОЛ: ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА, СУРГАМЖ

ХЭЛНИЙ БОДЛОГЫН ТУХАЙ

Нийгэм оршин тогтнох, нийгмийн бүлгүүд хоорондоо ойлголцох үндэс нь харилцаа бөгөөд харилцаанд давамгайл ашиглагддаг арга хэрэгсэл бол хэл юм. Зурган харилцаанаас бусад нийтлэг харилцааны арга хэрэгсэл бол хэл бөгөөд харин хэл нь дотроо олон янз бөгөөд тухайлбал, үндэстэн ястны хэл, аялгаас гадна аман болон бичгийн, дохионы хэл, программын хэл зэрэг хэлний системүүд бий.

Интернэтийн хайлтаар дэлхий дээр 6000 гаруй хэл байгааг мэдэж болох бөгөөд 200 хүрэхгүй улс орон 6,000 хэлээр ярьдаг гэхээр нэг улс нэг хэлээр ярьдаггүй нь тодорхой. Дэлхийн хүн амын 43 хувьд нь хос хэлтэн буюу хоёр хэлээр сайн ярьдаг хүмүүс байна. Индонез улсын 200,000 сая гаруй хүн албан ёсны индонез хэл, эх хэл, мөн англи хэл эзэмшсэн тул дэлхийн хамгийн олон хос хэлтэн иргэдтэй улс болж, харин улсынхаа хэмжээнд 37 хэлээр ярьдаг Бразил улс хамгийн олон үндэстний хэлтэй улс болж байна. Этнологи сэтгүүлд дэлхийн 55 орон албан ёсоор хос хэлтэй улс бөгөөд үүнээс 24 нь англи, 13 нь франц, 7 нь араб хэлийг өөр хэлтэй хавсран хэрэглэдэг байна.

Монгол Улс мөн л олон хэлт нийгэм бөгөөд монгол хэлний зэрэгцээ казах, тува, цаатан-тува хэлний цөөнхтэй. Монгол хэлтний дийлэнх нь Монгол Улс, Өвөр Монголд амьдарч байгаа бол тува хэлтнүүд Орос болон Монголд, казах хэлтнүүд Төв Азийн бүс нутаг, Монгол, Хятад улсад амьдарч байна.

ХҮСНЭГТ 1. Монгол, казах, тува хэлний тархац⁹

Хэл	Тухай хэлээр ярьдаг хүний тоо	Тархац
МОНГОЛ	5,200,000	Монгол Хятад
казах	11,000,000	Казахстан Киргизстан Хятад Монгол Орос
тува	280,000	Орос Монгол

Ихэнх тохиолдолд олонхын хэл нь төрийн албан ёсны хэл байдаг нийтлэг хандлагаар Монголд төрийн албан ёсны хэл бол олонхын хэл юм. Монгол Улс бол төрийн хэмээх тодотголтой албан ёсны нэг хэлтэй, олон хэлт нийгэм юм. Хос болон олон хэлт хүн амтай улс орнуудын нэгэн адилаар, Монгол Улс цөөнхийн болон олонхын хэл, эх болон албан ёсны хэл, сургалтын хэл, хос хэлний боловсрол, хос хэлний орчин гээд олон асуудлаар хүн амын түвшинд ойлголт мэдлэг бий болгож, төрийн түвшинд баримтлах бодлогоо тодорхойлон, хэрэгжүүлж ирсэн туршлагатай.

Хэлний бодлого нь өөрөө их сонин түүхтэй. Хэлний бодлого бол зөвхөн хэлний тухай асуудал биш юм. 20 дугаар зууны дунд үе хүртэл хүн төрөлхтөн нийгмийн хөгжил дэвшлийг нэг хэлтэй “үндэстэн-улс”-ын загвараар төсөөлж, нэг нийгэм нэг хэлтэй байх нь эв нэгдлийн илрэл гэж ойлгон, аль нэг хэлийг нийгэмд давамгайл байр суурьтай болгож, тэр хэл нь заримдаа ноёрхол, эрх мэдлийн арга хэрэгсэл болж байсан. Олон хэлтэй байх нь улс үндэсний эв нэгдэлд саад болох нөлөөтэй нийгмийн асуудал (проблем) хэмээн ойлгож, эрх мэдэлт бүлгийн хэлийг бусад бүлгүүдэд сургууль боловсролоор дамжуулан эзэмшүүлэн, эх хэл соёлоос нь холдуулах бодлого хэрэгжүүлж байсан колончлолын үеийн түүх ч бий.

Харин одоо энэ цаг үе нэгэнт ард хоцорчээ. 20 дугаар зууны сүүлийн хагас, 21 дүгээр зуунд дэлхийн улс орнууд, хувь хүмүүсийн харилцаа, хамаарал, хандлагыг өөрчилсөн гурван томоохон өөрчлөлт

9 Эх сурвалж: <https://www.languagecourse.net/languages-worldwide>

гарсан байна. Үүний нэг нь эдийн засгийн интеграцчилал эрчимтэй явагдаж, улмаар эдийн засгийн үйл ажиллагаа нэг улс орноор хязгаарлагдахаа байж, улс орон, бүс нутаг дамнасан эдийн засгийн эрчимтэй хамтын ажиллагааны үрээр нэг арга хэмжээн дээр, нэг албан байгууллагад олон хэл, соёл зэрэгцэн орших нь хэвийн үзэгдэл болж төлөвшсөн явдал юм. Удаах дэвшил нь хүний эрх, улс үндэстний эрх тэгш байдал нь нийгэм, олон улсын харилцааны хэм хэмжээ болж төлөвшсөний үрээр хэл нь эрх мэдлийн төлөөх тэмцлийн зэвсэг байхаа больж, хүний эрх, бүлгийн эрх, хувь хүний сонирхлын асуудал болжээ. Гуравдах нөлөөлөгч хүчин зүйл нь интернэт бөгөөд улс орны хил хязгаар, орон зайг даван туулах боломж олгосон интернэт нь бусдаас өөр, ялгаатай байхыг хэвийн үзэгдэл, хэм хэмжээ болгон төлөвшүүлж байна. Ийнхүү 21 дүгээр зуунд хос/ олон хэлт нийгмийн загвар, хэлний цөөнхийн эх хэл, соёлоо хадгалан хөгжүүлэх эрхийн тухай ойлголт бэхжиж, олон хэл нь хувь хүн, улс орны давуу тал, нэмэлт боломжийг олгодог ур чадвар, нийгмийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх нөөц гэсэн ойлголт хэвшиж байна.¹⁰

Дэлхийн улс орнууд хос болон олон хэлний хэрэглээг дэмжих хэрэгцээ, туршлагаа дэлгэн ярилцаж, тусгайлсан статистикийн тайлан, дэмжих хөтөлбөртэй болж байна. Тухайлбал, 2006 онд Европын Холбооны Комисс нь илтгэлдээ “Тус холбоонд хамрагддаг 25 улсын оршин суугчдын 56 хувь нь хоёр дахь хэлээр харилцах хангалттай чадвартай” гэж дурдсан нь хос хэлтний эзлэх хувь хэмжээ тийм ч бага бус, цаашид тэлэх хандлагатай байгааг харуулж байгаа бөгөөд 2004 онд Европын Холбоо нь хос болон олон хэлний бодлогыг дэмжин хэрэгжүүлэхээ зарласан юм. Европын Холбооны гишүүн орнуудад хос хэлний хэрэгцээ бодлого, хөтөлбөрийн хэрэгцээ улам нэмэгдэж байгаа нь хувь хүмүүсийг гадаад хэл сурах сонирхлоос гадна Европыг чиглэсэн цагаачдын урсгалтай холбоотой.

Хос хэлний бодлого нь хос хэлийг боловсрол, төрийн бусад үйлчилгээ, мэдээллийн орчинд дэмжих бодлого, хөтөлбөрөөр дамжин хэрэгжинэ. Хос хэлний боловсрол нь хоёр хэлээр албан боловсролын заавал судлах хичээлүүдийг үзэж, агуулгыг эзэмших үйл явц хэмээн

10 Baker C. (2006). Foundations of Bilingual Education and Bilingualism. Multilingual Matters цуврал, 3 дах хэвлэл

дээр дурдсан бөгөөд уламжлалт гадаад хэлний хичээлээс ялгаатай нь хоёр хэлийг хичээл болгож судлах бус, харин бусад хичээлийг заах сургалтын хэл болгож ашигладаг онцлогтой. Хос хэлний боловсролд тухайн улсын албан ёсны хэлтэй зэрэгцээ ашиглагдах үндэстэн, угсаатны эх хэл, цөөнхийн эх хэл, уугуул иргэдийн хэл, цагаач иргэдийн эх хэл зэрэг өвийн хэл, мөн бие даасан хэлний систем болох сонсголгүй хүмүүсийн дохионы хэл багтана.

Зарим тохиолдолд хос хэл нь эцэг эх, хүүхдийн сонирхол, сонголтын асуудал байдаг бөгөөд жишээлбэл, англи хэлний сургалттай буюу монгол, англи хос хэлний сургалттай сургуулиуд олон бий. Зарим тохиолдолд хос хэлний боловсрол нь зайлшгүй шаардлага болно. Жишээлбэл, хэлний цөөнх иргэд эх хэл болон төрийн албан ёсны хэлээр, сонсголын бэрхшээлтэй хүмүүс дохионы хэл (анхдагч хэл) болон бичгийн монгол хэл (хоёрдогч хэл)-ээр сурч боловсрох нь эдгээр бүлгийн хэрэгцээ бөгөөд төрөөс уг хэрэгцээг ханган, хос хэлний боловсролын хөтөлбөрөөр сургах үүрэг үүснэ.

Уг судалгаанд бид хос хэлээр боловсрол эзэмших хэрэгцээ шаардлагатай хэлний цөөнх хүүхдийн асуудлыг авч үзэж буй. Цөөнхийн хэлийг нийгмийн түвшинд, нийгмийн харилцаа (зөвхөн гэр бүлийн орчноор хязгаарлахгүй)-ны түвшинд хүлээн зөвшөөрөх нь цөөнхийн ялгаварлан гадуурхалтыг бууруулж, нийгмийн олон талт байдлаа хүлээн зөвшөөрөхөд тус болдог бөгөөд энэ нь цаашлаад нийгмийн болон хүний хөгжлийг дэмжиж байдаг бол цөөнхийн хувьд эх хэлээ хадгалан хамгаалах, өвөрмөц хэл, соёлынхоо ялгаатай байдлаа хүлээн зөвшөөрүүлэх, бахархах, нийгмийн эрх тэгш нэгэн гишүүний хувьд өргөн хүрээтэй нийгмийн үйл ажиллагаанд тэгш оролцох боломжийг хангаж өгдөг.

Хос болон олон хэлт нийгмийн загвар нь шийдэл шаардсан асуудлаас хүний, бүлгийн эрх болж өргөжин, цаашилбал, нийгмийн хөгжил, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх нэг нөөц, боломж гэж хардаг болтлоо хөгжиж яваа нэн сонирхолтой түүхтэй асуудал юм.

Олон хэлт нийгмийн загварын хөгжлийн тоймлох юм бол дэлхийн хөгжлийн түүх нь хэлний давамгайлал буюу цөөнхийн хэлний уусалд хүргэх нэг хэлт нийгэм, олон хэлийг хүлээн зөвшөөрсөн нийгэм, олон

хэлт нийгэм гэсэн гурван үе шатыг туулж байна. Үндэсний/ хэлний цөөнх эх хэлээрээ ярихаа больж олонхын хэл рүү орж бүхэлдээ өөр хэлний нэг хэсэг болох хэлний уусал (assimilation) нь өнөөдөр хүлээн зөвшөөрөгдөхгүй болжээ.

Хос хэлний бодлогын загварууд

Нийгэмд нэг хэл давамгайлж, хэлний цөөнх иргэд зөвхөн олонхын хэлээр нийгмийн харилцаанд орох орчинтой байх уу, эсвэл хоёр болон түүнээс олон хэл зэрэгцэн орших олон хэлт орчин байх уу гэдэг нь төрийн бодлогоос ихээхэн хамаарна. Судлаач Р.Каплан, Р.Балдауф нарын дүгнэснээр (1997)¹¹ хэлний бодлого бол хэлний төлөвлөсөн өөрчлөлтийг хийхэд чиглэсэн үзэл санаа (онол гэж ойлгож болно), хууль, практик юм. Судлаач М.Девид, С.Манан нар (2019) үүнтэй санал нийлж, хэлний бодлого бол хүн амын бодлого, хэлний хэрэглээ, иргэдийн итгэл үнэмшил, төрийн менежмент зэрэгтэй бүгдтэй нь холбоотой гэж дэлгэрүүлэн тайлбарласан байна.¹² Хэл, соёлын цөөнхийн хэлийг аажмаар албан ёсны хэлээр солих хасагдах хандлагад суурилсан бодлого хэрэгжүүлэх юм бол нэг хэл давамгайлсан нийгэм бий болж, харин хэд хэдэн хэлийг ижил түвшинд эзэмшүүлэн, нийгмийн харилцаанд зэрэгцүүлэн хэрэглэх үр дүнд чиглэсэн хэлний бодлого хэрэгжүүлэх юм бол хоёр/ олон хэлт нийгэм хөгжих боломжтой.

Судлаач Т.Вайли¹³ (2013) хэлний бодлогын хувьд аль нэг хэлний хэрэглээг нь хязгаарлах, бүр илт хумих баримжаатай, хязгаарлахгүй ч ямар нэг оролцоогүйгээр хөндлөнгөөс харах, эсвэл дэмжин хөгжүүлэх гэсэн гурван ерөнхий загвар байж болох юм гэж үзжээ (Хүснэгт 1-д тоймлов).

11 Robert B. Kaplan, Richard B. Baldauf (1997). Language Planning from Practice to Theory. Multilingual Matters цуврал, дугаар 108, хуудас 122

12 M.David, S.Manan (2019). Linguistic Diversity as a Problem vs Linguistic diversity as a Resource: A critique of language policies in Pakistan. "Research Mosaics of Language Studies in Asia. Differences and Diversity" номын бүлэг, х.9. https://www.researchgate.net/publication/338740147_

13 Жишээлбэл, Т. Wiley (2004). Historical Orientations to Language Policy in the United States, Хэлний бодлогын судалгааны сүлжээний бодлогын тойм. <https://www.cal.org>

ХҮСНЭГТ 2. Хэлний бодлогын гурван загвар

Загварын оноосон нэр	Англи эх сурвалж дах нэр	Тайлбар
Хязгаарлах / дарангуйлах баримжаатай хэлний бодлого	Restrictive- and repressive-oriented language policies	Цөөнхийн хэлийг асуудал гэж үзнэ. Хэлний хязгаарлах бодлого нь хэлийг устгахыг зорьдоггүй ч цөөнхийн хэлний хэрэглээг хориглох, хязгаарлах үр нөлөөтэй арга хэмжээ хэрэгжүүлэн
Хэлний хүлээцтэй бодлого	Tolerant language policies	Цөөнхийн хэлний хэрэглээг хязгаарлахгүй ч мөн дэмжихгүй, улмаар хэлний асуудалд оролцоо байхгүй
Хэлний дэмжин хөгжүүлэх баримжаатай бодлого	Promotion-oriented language policies	Онолын хувьд хэлийг нийгмийн баялаг гэж үзэж, цөөнх болон олонхын хэлийг хөгжүүлэхэд бодлого хэрэгжүүлэхийг зорьдог. Практикт энэ нь олонхын хэлийг дэмжих тал руу хэлбийх нь элбэг.

Т.Вайлигийн хэлний бодлогын чиг баримжааллууд нь нэг анги (сургуульд) өөр өөр хэл, соёлтой сурагчид хамтран суралцдаг АНУ-ын нөхцөлийг тусгасан судалгаа боловч улсын хэлний бодлого нь сургалтын хэлний сонголтод нөлөөлж, улмаар сургалтын хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэхэд шууд нөлөөлж байдгийг баримтжуулснаараа ач холбогдолтой юм. Монгол Улсад Үндсэн хуульдаа цөөнхийг хэлийг ялгаварлан гадуурхахгүй байхыг тунхаглаад, боловсролын орчинд хос хэлний бодлогоор дэмжих хөгжүүлэхээ эрх зүйн баримт бичгүүддээ тусгасан. Хос хэлний боловсролын хэрэгжилтийг нарийвчлан ажиглах юм бол казах хэлний талаар дэмжин хөгжүүлэх бодлого илүү тодорхой, харин тува, цаатан-тува хэлний хувьд хүлээцтэй бодлого руу хазайсан хэрэгжилтийн орчин бүрдсэн гэж дүгнэж болохоор байгааг дараагийн бүлэг дэх дүн шинжилгээнээс үзнэ үү. Гэхдээ энэ нь эцсийн дүгнэлт биш бөгөөд үндэстний цөөнх хүн амынхаа олонх болж байгаа орон нутгийн жишээн дээр хийсэн ажиглалт төдий болно. Монгол улсын хувьд хэлний хязгаарлан дарангуйлах чиглэлийн бодлого байхгүй гэж үзэх үндэслэл нь Үндсэн хуульд заасан хэл, соёлын үндсэн дээр

ялгаварлан гадуурхахгүй байх заалт, Боловсролын салбарын эрх зүйн орчин дах хос хэлний боловсролыг төлөвлөн хэрэгжүүлэхтэй холбоотой хуулийн заалт, үндэсний хөтөлбөр, бусад баримт бичиг, судалгааны хөгжүүлэлт хийгдэж байгаа зэргээс харж болно.

Хос хэлний талаарх үзэл баримтлал, загварчлал

Өнөөдөр дэлхий нийт хос хэлний боловсролыг моногlossик (ганц хэлт буюу monoglossic), гетерогlossик (олон хэлт буюу heteroglossic), хамтран оршихуй (co-presence) гэсэн гурван хандлагыг багтаасан онолоор¹⁴ авч үзэж байна. Хэлийг хэрэглэж байгаа орчин, нөхцөлөөс салангид, бие даасан ур чадвар гэж моногlossик үзэлтнүүд ойлгодог бөгөөд энэ хандлага нь хэл эзэмших, нийгэмд хэрэглэж байгаа хэлнүүдийг цөөнх болон олонх гэсэн ойлголтоос салгаж цэвэр харилцааны хэрэгсэл гэж харахыг хичээдэг сайн талтай. Харамсалтай нь, бодит байдал дээр хэл бол тодорхой нийгмийн бүлгийн ижилсэл, илэрхийллийн салшгүй нэг хэсэг болдог тул нийгмийн болон үндэсний бүлгүүдийн ялгарлын үзүүлэлт болж, улмаар илүү эрх мэдэлтэй нийгмийн бүлгийн хэл нь тухай нийгэмд давамгайл байр суурьтай, бусад хэл нь арай сул байр суурьтай гэж ойлгох хандлага хүчтэй байдаг. Моногlossик үзэлд суурилсан хос хэлний боловсролын бодлого нь хоёр хэлийг тодорхой хичээлүүд дээр ялгаж буюу аль хичээл дээр аль хэлийг ашиглахыг зааглах байдлаар тодорхой ялгасан байдаг. Нэг хичээлийн хүрээнд нэг л хэлийг ашигладаг тул моно хэлний орчин бий болдог гэж үзнэ. Моногlossик хос хэлний боловсролын бодлого хасагдах болон нэмэгдэх загваруудаар боловсруулагдаж байна.¹⁵

Гетерогlossик үзэл баримтлал нь нэг газар, нэг цаг үед буюу нэг орон зайд хэд хэдэн хэл (мөн нэг хэлний ялгаатай хэд хэдэн хувилбар) хамтран орших үзэгдлийг хэлдэг хэлний философийн үзэл баримтлал юм. Гетерогlossик үзэл баримтлал нь нэг хичээл дээр хоёр хэлийг ээлжлүүлэн ашиглах боломжтой гэж үздэг рекурсив загвар, мөн нэг хичээл дээр хоёр хэлийг холимог байдлаар, өөрт эвтэй байдлаар хоёр

14 Жишээлбэл, Garcia, O. (2008). Biligual Education in the 21st Century: Global Perspectives

15 Vučo, J. F. (редактор) (2017). Minority Languages in Education өгүүлэл. Learning Challenges and Perspectives эмхэтгэл, University of Belgrade

хэлний хооронд шилжиж ашиглахыг хүлээн зөвшөөрсөн динамик загвараар хэрэгждэг.

Моноглоссик, гетероглоссик үзэл баримтлал нь саяхны геополитикийн болон технологийн өөрчлөлт хүртэл тус тусдаа мөрдөгдөж, тэдгээрийн хүрээний хос хэлний дөрвөн загвар дэлхий нийтээр түгэн дэлгэрч байлаа. Олон улс оронд одоо ч хос хэлний боловсролын моноглоссик үзэл баримтлал мөрдөгдөж, түүний хүрээний хасагдах, нэмэгдэх загварын хөтөлбөрүүд хэрэглэгдсээр байгаагийн нэг нь Монгол Улс юм. Хэлний цөөнх хүүхдүүд эх хэл болон төрийн албан ёсны хэлийг эзэмшихдээ нэг цаг хичээл дээр хоёр хэлийг ээлжлэн болон “хольж” хэрэглэх гетероглоссик үзэл баримтлалд суурилсан сургалтын хөтөлбөрүүд дэлхийн олон улс оронд туршигдаж байгаа бөгөөд Монгол Улс мөн казах хүүхдийн хос хэлний боловсролын хүрээнд туршиж, хос хэлний боловсролын дэвшилтэт арга зүйтэй болохыг хичээж байгааг онцлох хэрэгтэй.

Хос хэлний боловсролын загвар

Хос хэлний боловсролын онолын талбарт өнөөдөр олон загварыг томъёолж гаргаад байгаа ч хос хэлний тухай онолоо дагаад ерөнхийдөө хасагдах (subtractive), нэмэгдэх (additive), мөн рекурсив (recursive буюу давтах), динамик (dynamic) гэсэн дөрвөн үндсэн загвар давамгайлж байна.

Хос хэлний боловсролын хоёр үзэл баримтлал, тус бүрт нь хамруулах хос хэлний боловсролын бодлогын дөрвөн загварыг доорх Хүснэгт 3-д хүрэхээр зорьж буй үр дүн, хүрээлэл буюу экологи, суурь хандлага, зорилтот бүлэг зэрэг үзүүлэлтээр зураглан харууллаа.

ХҮСНЭГТ 3. Хэлний талаарх үзэл баримтлал, бодлогын бүтэцчилсэн хүрээ

Хэлний талаарх үзэл Бодлогын чиглэл	Моногlossик үзэл	Гетерогlossик үзэл		
Хос хэлний боловсролын бодлого	Хасагдах загвар	Нэмэгдэх загвар	Рекурсив загвар	Динамик загвар
Зорьж буй үр дүн	Нэг хэлтэй болох	Хос хэлтэй болох	Хос хэлтэй болох	Олон хэлтэй болох
Хэлний экологи	Эх хэлнээс албан ёсны хэл рүү хийх шилжилт	Хэлний нэмэгдэл, цөөнхийн хэлний хөгжил	Хэл тогтмол хэрэглээнд байх	Олон хэлт
Хэлэнд хандах нийгмийн хандлага	Нэг нийгэмд олон хэл байх нь шийдэх ёстой асуудал	Нэг нийгэмд олон хэл байх нь нэмэлт боломж олгодог нөөц	Хос хэл бол эрх	Хос/ олон хэл бол нэмэлт боломж, нөөц
Зорилтот бүлэг	Зөвхөн цөөнх	Зөвхөн олонх, зөвхөн цөөнх гэсэн тусдаа бүлгүүд	Голдуу цөөнхийн бүлэг	Бүгд

Хос хэлний хасагдах болон нэмэгдэх загвар нь хос хэлийг хоорондоо шүргэлцэх төдий зэрэгцэн оршдог шугаман загвараар оршдог бие даасан тогтолцоо гэж үздэг нь цагийн хэлний сэтгэл судлал, хүний хөгжлийн холбогдолтой шинжлэх ухааны сүүлийн үеийн дүгнэлтүүдэд нийцэхгүй хуучирсан хандлага болжээ. Хэлийг бие даасан систем биш харин хэл, харилцааны нэгдмэл системийн хүрээнд төлөвшдөг хэрэглээний ур чадвар гэж үздэг рекурсив хос хэлний загвар, мөн хос хэл, соёлын нийллэг орчныг хүлээн зөвшөөрдөг олон хэлний динамик загвар нь орчин цагийн глобалчлагдсан, хүний эрхийг дээдэлдэг нийгэмд илүү тохиромжтой бөгөөд цаашид өргөн тархах хандлагатай загварууд юм.

Хос хэлний онолын дөрвөн загвар нь хос хэлний боловсролын орчинд хэрхэн бууж байгааг Хүснэгт 4-д харна уу?

ХҮСНЭГТ 4. Хос хэлний боловсролын бодлогын дөрвөн загвар

Хос хэлний боловсролын загвар	Хасагдах (Subtractive)	Нэмэгдэх (Additive)	Рекурсив (Recursive)	Динамик (Dynamic)
Бодлогын хүчин зүйлс				
Бодлогын үр нөлөө	Эцэстээ албан ёсны хэлд шилжих	Хоёр хэлний тэнцвэрийг хадгалах	Хоёр хэлний зэрэгцээ оршихуйг хүлээн зөвшөөрч, нэг орчинд хоёр хэлээр харилцах	Хоёр хэлний харилцан нөлөөг хүлээн зөвшөөрч, нэг орчинд зэрэг, динамикаар хэрэглэх
Мөн чанар	Цөөнхийн хэлээр боловсрол эзэмшиж эхлэх ч яваандаа албан ёсны хэл нь сургалтын хэл болж үлдэнэ. Энэ бодлого нь нийгэмд олон хэлтэй бүлгүүд байгааг нэг хэлтэй болгох замаар шийдэх ёстой асуудал гэх хандлагаас эхтэй.	Эх ба албан ёсны хэл дээр заах агуулгын хэмжээг тэнцвэртэй тогтооно. Нэг хүнийг бие даасан, моно хоёр хэлтэй болгох зорилготой гэж шүүмжилдэг ч хоёр хэлийг давуу тал гэж хардаг.	Нэг хэлээр өгсөн агуулгаа нөгөө хэлээр давтана. Хос хэлийг хүний эрх, хэл соёлоо өвлүүлэх арга хэрэгсэл гэж үзнэ. Хос хэлний суралцагчид нь хоёр дах бус хос хэлтэй болж төлөвших давуу талтай.	Олон хэл, соёл нь нэг орчинд холилдон, харилцан холбоотой орших боломжтой гэж үзэн, ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрсөн орчныг анги танхимд бий болгодог.

Хос хэлний боловсролын дээрх гурван загварыг тухайлан тайлбарлая.

Хасагдах баримжаатай хос хэлний боловсролын загвараар, хэлний цөөнх хүүхдүүд эх хэлээрээ (X1) боловсрол эзэмшиж эхлэх бөгөөд тун удалгүй бага ангид нь албан ёсны хэл (X2) нэмэгдэн, анги ахих тусам эх хэлний хэрэглээ хасагдан, албан ёсны хэлний эзлэх

хувь хэмжээ нэмэгдсээр, яваандаа сургалтад зөвхөн албан ёсны хэл үлдэнэ.

ЗУРАГ 2. Хос хэлний хасагдах загвар

$$X1 + X2 - X1 = X2$$

Эцсийн дүнд албан ёсны хэлийг эзэмшүүлэх зорилготой бөгөөд хүүхдийн эх хэл (X1) нь албан ёсны хэлээр боловсрол эзэмшихэд тус болох суурийн үүргийг гүйцэтгээд, ахисан түвшний боловсрол, сургалтад ашиглагдахгүй. Нэгэнт сурагчид эх хэлээрээ дамжуулан хэлний суурь ур чадвар болох унших, бичих чадвартай болохын зэрэгцээ албан ёсны хэлний тодорхой хэмжээний үгийн баялагтай болсон бол албан ёсны хэл рүү шилжих үйл явц эхэлж, бага ангийн сүүлийн жилүүдээс албан ёсны хэл нь сургалтын хэл бол нэмэгдэж орж ирнэ. Яваандаа албан ёсны хэлний эзлэх хувь хэмжээ нэмэгдэхийн хэрээр сургалтаас эх хэл(X1)-ийн хэрэглээ хасагдаж, албан ёсны хэл (X2)-ийг боловсрол, цаашдаа ажил, амьдралдаа давамгай ашиглах нөхцөл бүрдэнэ.

Хасагдах хандлагатай хос хэлний боловсролын загвар нь өнөөдөр эрт үеийн шилжилт, шилжилт гэсэн хоёр үндсэн арга зүйгээр хэрэгжиж байна. Бага ангид нь албан ёсны хэл рүү огцом шилжих нь эрт шилжилтийн аргазүй бөгөөд харин энгийн шилжилт нь тодорхой хугацаанд хоёр хэл зэрэгцэн хэрэглэгдэж байгаад албан ёсны хэл рүү шилжих арга зүй юм.

ХҮСНЭГТ 5. Эрт үеийн шилжилтийн аргазүй

Анги	Эх хэл /анхдагч хэл буюу X1	Хоёрдогч хэл / ихэнхдээ албан ёсны хэл буюу X2
СӨБ-ийн сүүлийн жил (5 нас) 1-2 дугаар анги	Сургалтын хэл	Сонсох, ярих ур чадвар хөгжүүлэлт
3-5 дугаар анги		Сургалтын хэл

Эрт үеийн шилжилт хийхдээ бага боловсролын эхний жилүүдэд сурагчид бичиг үсгийн ур чадвар эзэмшиж байх үед гэртээ хэрэглэдэг, тодорхой хэмжээний үгийн сангийн баялаг эзэмшсэн эх хэлээр нь сургалт явуулахын зэрэгцээ албан ёсны хэлээр үгийн сан, харилцааны

ур чадвар эзэмшүүлэх замаар албан ёсны хэлийг танилцуулна. 3 дугаар ангиас эх хэлний хэрэглээ нь нэг, хоёр хичээлийн хэмжээнд хадгалагдаж, харин албан ёсны хэл нь сургалтын үндсэн хэл болно.

Нөгөө арга зүй нь эх хэлээр сургалт явуулж байхдаа бага ангийн түвшинд албан ёсны хэлээр цөөн хичээл оруулж, яваандаа албан ёсны хэлээр орох хичээлийн тоог нэмэгдүүлэх замаар шилжилтийг аажуу, бэлтгэлтэй хийдэг байна. Гэхдээ л албан ёсны хэл нь мөн л 3 дугаар ангиас давамгайлж ирэх бөгөөд эх хэл нь нэг, хоёр хичээлийн хэмжээтэй болж эрс багасна.

ХҮСНЭГТ 6. Шилжилтийн хос хэлний боловсролын аргазүй

Анги	Эх хэл /анхдагч хэл буюу X1	Хоёрдогч хэл / ихэнхдээ албан ёсны хэл буюу X2
СӨБ	Сургалтын хэл	
1 дүгээр анги	Сургалтын хэл	Уншиж, бичиж сурах
Эхний хагас жил		
Сүүлийн хагас жил		
2 дугаар анги	Сургалтын хэл	Математик
Эхний хагас жил		
Сүүлийн хагас жил		
3-12 дугаар анги	Бие даасан хичээл	Сургалтын хэл

Хасагдах загварын аль ч арга зүйгээр суралцсан хүүхдүүд сургуульд сурч байхдаа эх хэл (X1)-ний ур чадварыг хангалттай хөгжүүлж чаддаггүй тул насанд хүрсэн хойноо хэрэглээ нь гэр бүлийн орчноор хязгаарлагдах, нийгмийн орчинд ашиглахгүй байх, үр хүүхдэдээ дамжуулах чадвар, эрмэлзэлгүй нь бага байдаг тул хэлний цөөнхийн хүүхэд эх хэлээ гээх нөлөө үүсэх эрсдэлтэй. Нийгмийн үр дагаврын зэрэгцээ хувь хүний түвшинд сөрөг нөлөө бий болно. Тухайлбал, бага ангид нэг хэл дээр сурч байгаад өөр хэл рүү огцом шилжсэнээс үүдэн сурлагаар хоцрох, сургууль завсардах, цаашилбал, эх болон албан ёсны хэлний аль алийг хангалттай сайн эзэмшиж чадахгүй болох нөхцөл бий болж магад. Улмаар энэ загварыг боловсролын бодлого, хөтөлбөрт ашиглахаас аль болох татгалзах хэрэгтэй.

Эх хэл дээрээ суралцахтай зэрэгцээд 2-3 жилийн туршид албан ёсны хэл дээр сонсох, ярих, унших, бичих ур чадвар хөгжүүлэх нь сурагчдад ирэх ачааллыг багасган, үгийн баялаг хөгжүүлж, дасан зохицох бэлтгэл болдог. Гэсэн ч 3 дугаар ангиас албан ёсны хэл руу эрс огцом шилжих нь сурагчдад нэлээд хүндрэл үүсгэж, сургалтын чанарт сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй. Монголд өнөөдөр шилжилтийн энэ арга зүйгээр тува хүүхдийн хос хэлний боловсролыг хэрэгжүүлж байна.

Нэмэгдэх хандлагатай хос хэлний боловсролын загвар нь хэлний цөөнх хүүхдэд эх хэл болон албан ёсны хэлийг ижил түвшинд эзэмшүүлэхийг зорьдог. Албан боловсролын эхний жилүүд хүүхдийн хөгжил, нийгэмшилд онцгой чухал тул СӨБ, бага сургуульд сургалт, хүмүүжил, нийгэмшлийн арга хэмжээг хүүхдийн эх хэл дээр явуулж, албан ёсны хэлийг бие даасан хичээлээр зэрэгцүүлэн, боломжтой бол хос хэлний багшаар заалгахыг судлаачид зөвлөж байна. Бага боловсролын сүүлийн ангиудад онолын бус агуулгатай хичээл, цаашдаа дунд боловсролын түвшинд хөтөлбөрийн багагүй хэсгийг албан ёсны хэл дээр заах нь энэ хандлагын хувьд нийтлэг байна.

ЗУРАГ 3. Хос хэлний нэмэгдэх загвар

$$X1 + X2 = X1 + X2$$

Хүүхдийн X2 (албан ёсны хэл)-ний ур чадварыг хөгжүүлэхийн зэрэгцээ X1 (эх хэл)-ний ур чадварыг хадгалах хос хэлний нэмэгдэх загвар нь эх хэлээ гэр бүл, нийгмийн болон албан ёсны харилцаанд ашиглах, эх хэлний үнэ цэнийг ойлгуулж үр хүүхдэдээ өвлүүлэх явдлыг нэмэгдүүлэх зэрэг эерэг нөлөөтэй. Бага ангид цөөнхийн хэлээр сургалт явуулж, албан ёсны хэлээр заагдах хичээлийн тоог аажмаар нэмэгдүүлэх замаар тэнцвэртэй хэрэглээ болгох зорилт дэвшүүлдэг хос хэлний нэмэгдэх загвар нь олон хэлийг нийгмийн баялаг гэж харах хандлагыг бий болгож, цөөнхийн хэл соёлын эрхийн хангах талаас илүү оновчтой бөгөөд сурагчдын хувьд илүү үр дүнтэй арга зүй болно. Нийтлэг шүүмжлэл нь хэлийг бодит амьдрал, хэрэглэх орчин, нөхцөлөөс нь салгаж, зөвхөн бие даасан систем гэж ойлгон, улмаар хоёр хэл эзэмшиж байгаа суралцагчдад хоёр моно хэлний

системийг эзэмшүүлэх гэж амьдралаас тасархай, хиймэл тусгаарлалт үүсгэдэг гэж үзэж байгаа явдал болно.

Нэмэгдэх хандлагад суурилсан хос хэлний боловсролын дараах арга зүйг дэлхийн улс орнууд хөгжүүлж байна. Үүнд:

- **Өвлөгдөх (өвийн) хос хэлний боловсрол** (Heritage Bilingual Education): Сургалтыг хүүхдийн эх хэл (X1) дээр явуулж, бага боловсролын сүүлийн ангиудаас албан ёсны хэлээр сонгогдсон тодорхой хичээлийг явуулна.

ХҮСНЭГТ 7. Өвлөгдөх хос хэлний боловсролын арга зүй

Анги	Эх хэл /анхдагч хэл буюу X1	Хоёрдогч хэл / ихэнхдээ албан ёсны хэл буюу X2
СӨБ	Сургалтын хэл	
1-3 дугаар анги	Сургалтын хэл	
4-12 дугаар анги	Тодорхой хичээлүүд	Тодорхой хичээлүүд

- **Хэлний орчин бүрдүүлсэн хос хэлний боловсрол.** Цөөнхийн болон албан ёсны эх хэлтэй хүүхэдтэй холимог бүлгээр хичээллэх бөгөөд 1 дүгээр ангид бүх хичээл цөөнхийн хэл дээр заагдаж, 2-3 дугаар ангиас албан ёсны хэлийг зааж эхлэх бөгөөд анги ахих тусам албан ёсны хэлээр заагдах хичээлийн тоо нэмэгдэх ч эх хэлээр заагдах хичээлийн тоо 50%-иас багагүй байна. Канадын англи хэлтэй орон нутгийн хүүхдүүдэд франц хэл эзэмшүүлэх зорилгоор анх гарсан энэ арга зүйг хос хэлтэй улс орнуудад түлхүү ашиглаж байна (Уэллс, Шотланд, Ирланд, Баск нутаг).

ХҮСНЭГТ 8. Хэлний орчин бүрдүүлсэн хос хэлний боловсролын арга зүй

Хялбарчлан тайлбарлах юм бол, энэ нь сургуулийн нэг ангид хоёр өөр хэлний орчныг бүрдүүлж, хос хэлтэй багшаар хангах явдал гэж ойлгож болно.

Анги	Эх хэл /анхдагч хэл буюу X1	Хоёрдогч хэл / ихэнхдээ албан ёсны хэл буюу X2
СӨБ	Сургалтын хэл	
1 дүгээр анги	Сургалтын хэл	
2-3 дугаар анги	Дийлэнх хичээлүүд	Зарим хичээл
4-12 дугаар анги	Нийт хичээлийн 50%	Нийт хичээлийн 50%

- ▶ **Давхар хэлт хос хэлний боловсрол** (Dual Language Bilingual Education, мөн Хоёр урсгалт хос хэлний боловсрол гэж нэрлэдэг): ойролцоогоор ижил тооны цөөнхийн болон албан ёсны эх хэлтэй хүүхэдтэй холимог бүлэгт хичээлүүдийг өөр өөр хэлээр явуулах ба нэг өдрийн сургалтын 50% нь цөөнхийн, 50% нь албан ёсны хэлээр явуулахаар зохицуулна. Нэг хичээл дээр хоёр хэлийн хольж хэрэглэхгүй, мөн тодорхой хичээлийг тодорхой хэл дээр заах зохицуулалт байхгүй. Энэ арга зүйн нь бүх хүүхдийн хоёр хэлний ур чадварыг тэнцвэртэй хөгжүүлэх зорилготой.
- ▶ **Агуулга болон хэлний интеграцчилсан сурахуйн загвар** (Content and Language Integrated Learning (CLIL)): Гадаад хэлний сургалтад ашиглагддаг энэ арга зүйг цөөнхийн хос хэлний боловсролд амжилттай ашиглаж байна. Хэлний орчин бий болгох буюу вакуумжуулах загвартай төстэй энэ арга нь тодорхой хичээлийг судлахдаа давхар хэлийг эзэмшүүлэх зорилтыг хангах арга зүй юм. Жишээлбэл, анхнаасаа тодорхой хэдэн хичээлийг сонгож хүүхдийн эх биш буюу албан ёсны (эсвэл гадаад) хэлээр заах бөгөөд тухайн судлагдахууныг эзэмших явцдаа хүүхэд хоёр хэлтэй болох юм. Бага ангид багш нэг хэлнээс нөгөө руу орчуулах, эх хэл дээр тайлбарласнаа албан ёсны хэлээр дахин тайлбарлах зэрэг нэгж хичээл дээр хоёр хэлийг ашигласан арга зүйгээр ажиллаж, анги ахих тусам нэг хэлээх дагнах боломжтой болно.

Нэмэгдэх загварын хос хэлний боловсролын эдгээр арга зүй нь хоорондоо хоёрдогч хэлийг хичээл болгож заах, хоёрдогч хэлийг сургалтад ашиглаж эхлэх нас, хэмжээ зэргээрээ нэлээд ялгаатай. Үүний хэрээр багш, сурах бичиг, сургалтын хөтөлбөр хөгжүүлэлтэд тавигдах шаардлага өөр байх юм. Монголд өнөөдөр казах хүүхдүүдийн хос хэлний боловсролын тухайд нэмэгдэх хос хэлний энэ аргазүйд ойр байгаа ч казах болон монгол хэл дээр заагдах хичээлийн харьцаа, шилжилтийн стратеги нь тодорхойгүй байна.

Хос хэлний рекурсив загвараар эх хэл дээр олонхын хэлийг нэмсний дараа дахин хос хэлээрээ тухайн агуулгыг давтан заах замаар хос хэлийг хөгжүүлэх, түүний үр дүн бол хос хэлтэй болгох

арга зүйг ашигладаг. Энэ нь дээр танилцуулсан Агуулга болон хэлний интеграцчилсан сурахуйн загвартай төстэй ч хичээлийн цаг, хөтөлбөрийг хоёр хувааж, эх хэлээр заагдсан өмнөх агуулга, сургалтын үйл ажиллагааг нөгөө хэлээр давтдаг онцлогтой.

ЗУРАГ 4 Хос хэлний рекурсив загвар




Нэн сонирхолтой нь, Шинэ Зеландын цөөнх моричууд энэ загварыг эсрэг чиглэлээр буюу эх хэлнийхээ хэрэглээ, практик чадварыг сэргээн сайжруулах зорилгоор албан ёсны/ хоёрдугаар хэлээр эзэмшсэн мэдлэгээ эх хэл дээрээ давтах арга зүйгээр ашиглаж байна. Тэд өвөг дээдсийнхээ хэлийг уламжлалт баяр ёслол, олон нийтийн арга хэмжээнд ашиглаж байгаа нь эх хэл дээрх агуулга, харилцаа нь албан ёсны хэл дээрх үйл явдлын давталт болж, улмаар зөвхөн нэмэлт хэлний хэрэглээ биш рекурсив хэрэглээ болдог байна. Хос хэлтэй цөөнхийн төлөөлөгч хувь хүн, бүлгүүд нь хос хэлээ алдахгүй, хадгалах үүднээс байнга хоёр хэлний хооронд шилжиж, бүх үйл явдлыг хоёр хэл дээр давтах замаар хоёр хэлний хэрэглээг бий болгож байна. Энэ аргын тусламжтайгаар тэд хэлний хэрэглээг бүхэлд нь биш хэсэг хэсгээр нэмэгдүүлэхийн зэрэгцээ өвөг дээдсээс уламжлагдан ирсэн үг хэллэгийг шинэ хэлнээс дамжуулан баяжуулж байдаг. Нийтлэгээр, рекурсив арга хандлага нь устаж үгүй болсон, мөн хүлээн зөвшөөрөгдөхгүй явсаар, эсвэл гадаадад амьдардаг тул хэрэглээ нь хязгаарлагдаж өвлөгдөхгүй байх эрсдэлд өртсөн цөөнхийн хэлний тухайд ашиглах нь их. Хос хэлний рекурсив загвар нь хязгаарлагдмал боломжтой тул хос хэлтний цогц чадамж, ялангуяа харилцааны ур чадвар бий болгож чадахгүй.

Олон хэл нь шугаман график шиг, параллель замууд шиг шүргэлцэх төдий оршиж байдаг гэдэг нь буруу ойлголт болж байна. Олон хэл нь янз бүрийн нөхцөлд хоорондоо сүлжилдэн, харилцан нөлөөлөх динамик харилцаатай гэж үзэх юм бол бидний $X_1 + X_2$ юмуу $X_1 + X_2 - X_1$ гэсэн ойлголтыг хэрэглэх боломжгүй болно. Дэлхийн даяаршил хүмүүсийг уламжлалт категориудаа эргэн харж, үүсэн бий болж байгаа тэс өөр орчин нөхцөлд харилцаа хамаарлаа өөрөөр

загварчлан ойлгохыг шаардаж байна. Цаашид дэлхий ертөнцийг хамарсан харилцаа, солилцоо, харилцан хамаарлын нийллэг нэг орчин бий болж нэг (Х1) ба хоёрдугаар (Х2) хэл, суурь ба зочны хэл, суурь ба зээлсэн хэл зэрэг ойлголт онц ач холбогдолгүй болж, тухайн цаг үед ойлголцоход тус болох, хүсэл сонирхолд нь нийцсэн олон хэлт, олон соёлыг агуулсан орчин бий болж байна. Хос хэлний зэрэгцэн хэрэглээг шаардсан, хоёр хэлийг нэгэн зэрэг эн тэнцүү хэрэглэх хос хэлний динамик загварыг хэрэгжүүлж байгаа Швейцар, Канадын загварууд дэлхий нийтэд үлгэр дуурайлал болж байна (Зураг 5).

ЗУРАГ 5. Хос хэлний динамик загвар



Уг зураг дахь сүлжилдсэн сумны зарим шугаман, зарим зууван, зарим сүүдэртэй хэсэг нь нэг хэлд харгалзаж байгаа бөгөөд хоосон хэсэг нь бусад хэлийг төлөөлсөн буюу нэгэн зэрэг ашиглагдаж буй олон хэлт орчин дах олон хэлт харилцааны олонлогийг агуулж байна. Хос хэлний динамик хэрэглээ нь харилцаандаа олон хэлийг зэрэг ашиглах, хэд хэдэн хэлний хооронд шилжих буюу “хольж” ашиглах, нэг хүн өөр өөр нөхцөлд өөр өөр хэл ашиглах замаар харилцаандаа олон хэлний тэгш, үр нөлөөтэй, үр ашигтай тэнцвэрийг хадгалсан хэрэглээг бий болгох боломжтой гэж үздэг. Мэдээлэл, харилцаа, холбооны технологи, өөрчлөгдөн өргөжиж, хувь хүн олон хэл дээр мэдээллийн эх сурвалж ашиглах, харилцаанд орох боломж нээлттэй болсон өнөөгийн нөхцөлд эх хэл болон албан ёсны хэлний хэлний хэрэглээ, орчин нь тусдаа байна гэсэн хос хэлний загвар хоцрогдон хуучирчээ. Гэвч Монгол болон олон улс оронд хос болон олон хэлний

динамик хэрэглээний загвар нь онол, загвар төдий байгаа ч цаашдын ирээдүй, төлөв ийш чиглэж байгаа бололтой.

Хос хэлний орчинд өсөж торниж, хос хэлээр харилцан суралцаж байгаа хүүхдүүдийг аль нэг хэлийг төгс сайн эзэмшээд, дараа нь нөгөө хэлээ төгс сайн эзэмшиж харилцаандаа бүрэн ашиглана гэхээс илүүтэй хос хэлний динамик хэрэглээний хандлагаар буюу хоёр хэлний хооронд шилжсэн хэрэглээг өдөр тутмын харилцаандаа бий болгохыг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй болж байх шиг. Өөрөөр хэлбэл, хоёр хэлний холимог хэрэглээг шийдэх ёстой асуудал биш харин хос хэл эзэмших үйл явцын эхэн үеийн харилцааны боломжит хувилбар гэж үзэх нь хэл сурч байгаа суралцагчдад илүү ээлтэй, ачаалал багатай хандлага болох юм. Энэ бол динамик хос хэлний хандлага юм. Гэхдээ сургуулийн анги танхимд хоёр хэлний хооронд шилжсэн харилцааг бий болгохын тулд хэл хольж ярихыг хүлээн зөвшөөрсөн хандлагын зэрэгцээ мөн хос хэлтэй багш, хоёр хэл дээрх сургалтын хэрэглэгдэхүүн зэргийг бэлдэх, мөн сургуулийн гадуур орчинд хэлний шилжилт хийхэд хүлээцтэй хандах замаар сурах боломжийг нэмэгдүүлсэн мэдээлэл, харилцааны орчин шаардлагатай.

Одоогийн байдлаар Монголд хэлний цөөнх хүүхдийн хос хэлний боловсролд рекурсив, динамик арга зүйн загварт түшиглэсэн хос хэлний хөтөлбөр хэрэгжүүлж эхлээгүй байна. Зарим гадаад хэлний сургалттай, хэлний орчин бүрдүүлсэн хувийн ЕБС-д эдгээр загвар хэрэгжиж байгаа тул туршлагыг нь судалж хэлний цөөнхийн хос хэлний боловсрол руу хуулбарлан зөөх боломж бий гэж үзэж байна.

Хос хэлний боловсролын бодлогын нийгмийн үр нөлөө

Бодлогын хүлээн авагч тал буюу энэ тохиолдолд хос хэлний боловсролын сурагчид уг хөтөлбөрөөр суралцсаны эцэст хос хэлний хүлээн авах ур чадвартай болох уу, эсвэл хоёр хэлээр бүтээх ур чадвартай болох уу гэдгээр бодлогыг мөн “хэмжиж” болно. Өөрөөр хэлбэл, манай хэлний бодлогын хүрээнд хос хэлний хөтөлбөрөөр сураад гарсан хэлний цөөнхийн иргэд ямар ур чадвартай болж төлөвшихөөр хос хэлний боловсролын хөтөлбөр маань зорьж байгааг харуулах зорилтот үр дүн гэж ойлгож болно.

Мэдээллийг ойлгох, сонсох, унших чадварын нэгсэл нь хос хэлний хүлээн авагч чадварыг бүрдүүлдэг (Хүснэгт 9) бол ярих, бичих, бүтээх чадварын нэгсэл нь хос хэлний бүтээгч чадварыг бүрдүүлдэг. Хос хэлний хөтөлбөрөөр суралцаад төгсөж байгаа залуучууд хүлээн авагч хос хэлтэн үү, бүтээгч хос хэлтэн үү? Бодлого, хөтөлбөрийг боловсруулж буй судлаачид, түүнийг батлан хэрэгжилтийг хянах үүрэгтэй бодлого, шийдвэр гаргагчид маань хос хэлний хөтөлбөрөөр сураад гарч байгаа залуучуудыг хүлээн авагч хос хэлтэн, эсвэл бүтээгч хос хэлтэн болж төлөвших хүлээлттэй байна уу уу?

Ялгаа нь маш энгийн. Хүлээн авагч хос хэлтэн нь хоёр хэлээр бусдын бүтээсэн мэдээллийг ойлгох, хариулах чадвартай байх бол бүтээгч хос хэлтэн нь хоёр хэлээр харилцааг бүтээх чадвартай байна. Нэгээс олон хэлээр ойлгох, сонсох, унших, тайлбар хийх, санаа бодлоо илэрхийлэх чадвартай атал нэгээс олон хэлээр ярих, бичих, бүтээх чадваргүй байж болно. Эсвэл хос хэлний бүтээх ур чадвартай буюу нэгээс дээш хэлээр мэдээлэл хүлээн авахын зэрэгцээ ярих, бичих, бүтээх чадвартай болж хөгжих боломжтой. Өнөөдөр манай хэлний цөөнх хүүхдүүд хүлээн авагч, эсвэл бүтээгч хос хэлтэн байх уу гэсэн бодлогын зорилт тодорхойгүй байна. Үүнийг судлан, хариулт олох нь цаашид хос хэлний боловсролын бодлого, үйл ажиллагааг хожим гарах үр дүнтэй уялдуулан төлөвлөн, хэрэгжүүлэх, тухайн үр дүндээ хүрэхэд шаардлагатай хос хэлний боловсролын дэд бүтцийг төлөвлөн нийлүүлэхэд чухал ач холбогдолтой зүйл болох юм.

Бүр нарийвчлах юм бол, бүхий л орчин нөхцөлд, ямар ч сэдвээр хос хэлээр харилцах чадвартай байх уу, эсвэл нэг хэлээр чөлөөтэй харилцаж, харин нөгөө хэлийг бусдын бүтээсэн мэдээллийг ойлгон хариу өгөх хэмжээд эзэмшсэн байх уу гэсэн асуултын хариуг хэлний бодлого, боловсролын бодлого тодорхойлогч, цөөнхийн төлөөлөл, хүний эрхийн мэргэжилтэн зэрэг хүмүүс зөвлөлдөн шийдэх хэрэгтэй. Нэг хэлээр харилцаж нөгөө хэлийг ойлгодог иргэдтэй сул хос хэлний ур чадвартай нийгэм нь өнөөдрийн Монголын нийгмийн загвар юм. Харин хоёр хэлээр харилцааны ур чадвартай, мэдээлэл хүлээж аваад зогсохгүй агуулга бүтээх ур чадвар бүхий хүчтэй хос хэлтэй нийгэм болохын тулд цөөнхийн хэлний бодлого, хос хэлний хөтөлбөрөөр хязгаарлахгүй, цөөнхийн хэлний орчин бий болгох, цөөнхийн хэлний

талаарх нийгмийн эерэг хандлагыг бэхжүүлэхэд анхаарахыг шаардах юм.

ХҮСНЭГТ 9. Хүлээн авагч ба бүтээгч хос хэлний харьцуулалт¹⁶

Хүлээн авагч хос хэлтэн	Бүтээгч хос хэлтэн
Дийлэнхдээ албан бус харилцаанд ашиглана	Албан ба албан бус харилцаанд ижил ашиглана
Зорилгод уялдсан харилцааны зориулалтаар сурна	Хэрэглээнд чиглэсэн
Нүүр тулсан харилцаанд ашиглах нь их	Тодорхой орчин шаардлагагүй
Гол зорилго нь харилцаа бий болгох явдал бөгөөд урьдчилан төлөвлөсөн, зохион байгуулж бэлдсэн зорилтот орчинд (ad-hoc) хэрэглэх нь их	Харилцагч, сэдэв, орчин нөхцөлд тохируулан үгийн сонголт, өнгө аясаа зохицуулан хэрэглэх боломжтой
Орчин нөхцөл, харилцагчаас маш их хамааралтай	Харилцагч, орчин нөхцөлөөс хамаарал багатай
Тухайн нөхцөл байдалд оновчтой оролцож, хариу үйлдэл үзүүлэх зэрэг прагматик зорилтууд чухал тул хэл, найруулгын дүрмийн алдаа чухал биш	Хэлний дүрэм, хэрэглээний хэм хэмжээ, хэл найруулгын хувьд оновчтой, алдаагүй

Хүлээн авагч хос хэлний ур чадварыг өөр өөр хэлтэй хүмүүс гэрээ хэлэлцээр, наймаа хийх зорилгоор нүүр тулсан уулзалт хийж байгаа нөхцөлөөр ашиглаж байгаагаар төсөөлөн ойлгож болно. Ийм нөхцөлд ямар сэдвээр яриа өрнөх нь тодорхой бөгөөд харилцагчид хоёр өөр хэлээр ярих ч нарийн ширийн зүйл дээр үл ойлголцол, алдаа гаргахгүй байх хэмжээнд нөгөө хэлийг сайн мэднэ. Ийм нөхцөлд хэлний дүрэм, өгүүлбэрийн зөв найруулга зэрэг хэлний хэм хэмжээ чухал биш харин ойлголцол чухал байх юм.¹⁷

Харин бүтээгч хос хэлтэн бол хоёр хэлээр ижил түвшинд сайн ярих, ойлгох, бичиж боловсруулах чадвартай байна. Бүтээгч хос хэлтэй болохын тулд хөтөлбөрийн хүрээнд болон амьдарч буй орчинд нь хоёр хэлний харилцаа, мэдээллийн орчин бий болж, хоёр хэлийг эн тэнцүү хүлээн зөвшөөрсөн нийгмийн хандлага бүрдэн, өдөр тутмын

16 Эх сурвалж: Браунмюллер (2007). Хүлээн авагч олон хэлний ур чадвар: хэлний ур чадвар, хэлний бодлого, дидактик хандлагын шинжилгээ. Гамбургын их сургуулийн олон хэлний ур чадварын судалгаа эмхэтгэл, хуудас 30

17 Эх сурвалж: Мөн тэнд, хуудас 27

харилцаанд хоёр хэлийг ашиглан дадлага туршлага суух боломж олгосон хэлний орчин, дэд бүтэц бий болсон байх нь чухал.

Сонирхолтой нь, хүлээн авагч хос хэлний ур чадвар нь бүтээгч хос хэлний ур чадвартай болох үйл явцын эхэн үе байх нь нийтлэг боловч хэлний орчин, дэд бүтэц бүрдсэн орчинд суралцагчид хүлээн авагч үе шатаар дамжихгүй шууд бүтээгч хос хэлтэн болдог. Гагцхүү хэлний цөөнх бүлгийн хүүхдүүд гэртээ эх хэлээрээ ярьж, нийгмийн орчинд албан ёсны хэлийг сонсож, мэдээлэл авч байдаг тул сургуульд элсэн орж ирэхдээ албан ёсны хэлээр хүлээн авагч болсон байх нь өндөр магадлалтай ч энэ талаар судалгаа хийгдээгүй байна.

Дээрх бүтээгч болон хүлээн авагч хос хэлний тухай онолын практик хэрэглээ нь хос хэлний боловсролын хөтөлбөрийн зорилтот үр дүнг тодорхойлох буюу тухай хөтөлбөрөөр суралцсан иргэд хос хэлний ямар ур чадвартай болсон байхыг төлөвлөн, тодорхой хэмжээнд үргэлжлүүлэн суралцах боломжийг нээх ЭЕШ зэрэг шалгалтын агуулгыг боловсруулахад хэрэг болно. Монголын нийгэм нь олонх болон цөөнхийн хэлнүүд хаа ч гэсэн сонсогдож байдаг, хэрэглээ нь цөөнхийн хүн ам төвлөрөн амьдардаг аймаг орон нутгаар хязгаарлагддаггүй хүчтэй хос хэлт нийгэм (strong bilingualism) байх уу, эсвэл нэг хэлээр харилцдаг ч тодорхой нөхцөлд, тодорхой орон нутагт хос хэлээр харилцах чадвартай иргэдтэй сул хос хэлт нийгэм (weak bilingualism) байх уу гэдгээс хамаарна. Хос хэл хүчтэй, эсвэл сул байх сонголтыг хийсний дараа тухай үр дүнд хүргэх хос хэлний хөтөлбөрийг сонгон хэрэгжүүлнэ. Эцсийн дүндээ хэлний цөөнх нь эх хэлээ тодорхой орчин нөхцөл, тодорхой орон нутагт хэрэглэдэг сул хос хэлт нийгэм байх нь хангалттай гэж үзэх юм бол хос хэлний боловсролын бодлого, хөтөлбөр нь энэ үр дүндээ чиглэсэн, цөөнхийн хүүхдүүдэд эх хэл, соёлыг нь өвлүүлэн хадгалахын зэрэгцээ монгол хэлээр нийгмийн харилцаагаа авч явах шилжилтийн загвартай байна. Харин хоёр хэлийг ижил хэмжээнд ашиглах нөхцөл боломжийг бүрдүүлсэн хүчтэй хос хэлт нийгэм болох хүсэл, зорилго байгаа бол төрийн үйлчилгээ, нийгмийн хандлага, мэдээллийн орчин нь хоёр хэлний алийг ч ашиглах боломжтой байхаар өөрчлөн шинэчлэх хэрэгтэй болно.

Хос хэлний боловсролын хөтөлбөрийн үндсэн загварууд

Хос хэлний боловсролын хөтөлбөрүүдийг хүрэх үр дүнтэй нь уялдуулан тоймлох юм бол хос хэлний шилжилтийн (transitional model), дэмжих (maintenance model), баяжуулан хөгжүүлэх (enrichment model) гэсэн гурван үндсэн загвар харагдаж байна.¹⁸

Цөөнхийн хүүхдүүд гэр бүлийнхээ буюу ахуйн хүрээнд хэрэглэдэг эх хэлнээс албан ёсны хэл рүү шилжин, олонхын нийгмийн харилцаа, соёлд дасан зохицох үр дүнг хүлээж байгаа бол хос хэлний боловсролын шилжилтийн загвар болно. Цөөнхийн соёл, хэлийг ахуйн хүрээний хэрэглээгээр хязгаарлахгүй нийгмийн түвшинд хүлээн зөвшөөрч, цөөнхийн хэл, соёлыг сурталчлан таниулах замаар хэл, соёлыг өвлүүлэх, хадгалах, мартуулахгүй байх, таниулах үр дүн хүлээж болох хос хэлний боловсролын загвар бол дэмжих загвар юм. Ихэнх талаараа дэмжих загвартай төстэй боловч тодорхой үе шатнаас эхлэн цаашид эх хэлийг хадгалаад зогсохгүй түүнийг хөгжүүлэн баяжуулах үр нөлөө хүлээж байгаа бол хос хэлний хөгжүүлэн баяжуулах загвар тохирно.

Хос хэлний боловсролын эдгээр загвар нь хоорондоо хэлний, соёлын, нийгмийн зорилгоор, мөн хэрхэн хэрэгжүүлэх бодлого, хөтөлбөр, бүтцээрээ ялгаатай бөгөөд үүнийг алдарт Хорнбергийн загварт дараах байдлаар тоймложээ (Хүснэгт 10).

ХҮСНЭГТ 10. Хорнбергийн хос хэлний боловсролын загвар

	Шилжилтийн загвар (Transitional model)	Хадгалах загвар (Maintenance model)	Баяжуулах загвар (Enrichment model)
Хэлний зорилго	Эх хэлнээс албан ёсны хэл рүү шилжих	Эх хэлийг өвлөн хадгалах	Эх хэлийг хөгжүүлэх
Соёлын зорилго	Соёлын уусал	Өвөрмөц соёлын хадгалалт	Соёлын олон талт үзэл
Нийгмийн зорилго	Нийгмийн нэгсэл	Иргэний эрхийн баталгаажуулалт	Нийгмийн бие даасан байдал

18 Huraajova, A. (2015). An overview of models of bilingual education өгүүлэл. Mediterranean Journal of Social Sciences сэтгүүл

Хос хэлний боловсролын эдгээр загвар нь гарах үр дүнгээрээ хос хэлний хасагдах, нэмэгдэх болон динамик хандлагатай ерөнхийдөө дүйцнэ. Өөрөөр хэлбэл, шилжилтийн загвар нь эх хэлнээс албан ёсны хэл рүү шилжих зорилготой тул хос хэлний боловсролын хасагдах загвараар хэрэгждэг бол өвлөн хадгалах загвар нь эх хэлийг нь мартуулахгүй байх зорилгын хүрээнд хос хэлний боловсролын нэмэгдэх загвараар хэрэгждэг. Хос хэлний баяжуулах загвар нь олон хэлний динамик хэрэглээг бий болгодог тул хос хэлний боловсролын динамик арга зүйд түшиглэдэг.

Хос хэлний боловсролын загваруудад хос хэлний бодлогын зорилтууд дараах байдлаар харгалздаг байна (Хүснэгт 11).

ХҮСНЭГТ 11. Хос хэлний боловсролын бодлого, хөтөлбөрийн хамаарал

Хос хэлний бодлого	Хос хэлний боловсролын хөтөлбөрийн хэлбэр
Хасагдах $X1 + X2 - X1 = X2$	Шилжилтийн хөтөлбөр (эх хэлээр эхлээд, албан ёсны хэл рүү шилжих)
Нэмэгдэх $X1 + X2 = X1 + X2$	Өвлүүлэн хадгалах (эх хэлийн мартуулахгүйн зэрэгцээ албан ёсны хэлийг эзэмшүүлэх)
Рекурсив 	Хөгжүүлэх (эх болон албан ёсны хэлийг ээлжлэн ашиглах замаар хэлний орчин бүрдүүлэх)
Динамик 	Хөгжүүлэх (нэг орчин нөхцөл, цаг хугацаанд олон хэлийг ашигласан хэлний орчин бий болгох замаар олон чиглэлт, хоёр урсгалт олон хэлний харилцааг бий болгоно)

Монгол Улсын Үндсэн Хуулийн 8 дугаар зүйлд “1. Монгол хэл бол төрийн албан ёсны хэл мөн. 2. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн заалт нь хүн амын өөр хэл бүхий үндэстний цөөнх эх хэлээрээ суралцах, харилцах, соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах эрхийг үл хөндөнө” гэж заасан байдаг. Мөн Үндсэн хуульд “хүнийг үндэс, хэл... боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно”, хүн бүр “сурч боловсрох эрхтэй” зэрэг заалтаар баримжаалан манай улс

хэлний шилжилт буюу хэл, соёлын цөөнхийг олонхын соёлд уусгах бодлого баримтлаагүй гэж дүгнэж байна. Цаашилбал, Монгол хэлний тухай хууль, Боловсролын тухай багц хуульд үндэсний цөөнхөд хос хэлний боловсролын үйлчилгээг хүргэх ажлыг зохион байгуулах үүргийг БШУЯ-д оноож өгсөн байна. Улмаар манай улсад хэл, соёлын цөөнхийн хэл, соёлыг хадгалах, цаашилбал, цөөнхийн хэл дээр соёл, урлагийн төдийгүй шинжлэх ухааны хөгжлийг дэмжих бодлогын зорилт дэвшүүлэгджээ.

Харин бодлогын энэхүү зорилтыг хангахуйн хөтөлбөр гаргаж чадаагүй бололтой. Өөрөөр хэлбэр, хос хэлний хүчтэй буюу бүтээгч ур чадварт чиглэсэн бодлогын зорилт дэвшүүлсэн боловч хэрэгжүүлж буй хөтөлбөр нь нийгмийн түвшинд ийм үр дүн гарах хэмжээнд хүрч чадаагүй байх магадлал харагдаж байна. Тува хүүхдүүдийн хос хэлний боловсрол нь шилжилтийн загвартай байгаа нь тува хэлийг зөвхөн гэр бүлийн орчинд ашиглах нөхцөл бий болгож байгаа нь яваандаа тува хэл мартагдах эрсдэлийг агуулж байх магадлалтай. Казах хүүхдүүдийн хос хэлний боловсрол нь нэмэгдэх загвараар боловсруулагдсан гэж ерөнхийд нь дүгнэж болох байна. Цаатан хүүхдүүдийн хос хэлний боловсролын бодлого, хөтөлбөрийн талаар сүүлийн үеийн судалгааны мэдээлэл ч байхгүй тул бодлого, хөтөлбөрийн загварыг тодорхойлох боломж олдоогүй болно. Цаашилбал, хос хэлний боловсролын хөтөлбөр нь зөвхөн үндэсний цөөнх хүн ам төвлөрөн амьдардаг орон нутгаар хамран хүрээ нь хязгаарлагдаж байгаагаас харахад манай хэлний бодлого цөөнхийн хэлд хүлээцтэй хандлах бодлого хэрэгжиж байна гэлтэй. Цөөнхийн хэл, соёлд хүлээцтэй хандах бодлого нь бүр орон нутгийн түвшинд илэрч байгааг дурдах шаардлагатай бөгөөд тухайлбал, хэл, соёлын цөөнх иргэд төвлөрөн амьдардаг Баян-Өлгий аймагт нийгмийн орчинд казах хэлний хэрэглээ давамгайлан, улмаар тува хэлний хувьд хүлээцтэй хандах “цөөнхийн дундах цөөнх”-ийн ойлголт хандлага бий болж байх магадлалтай. Гэтэл Үндсэн хуулиар манай улс хэл, соёлын цөөнхийн хэлийн идэвхтэй сургах, дэмжих, цаашилбал хэлний, боловсролын, соёлын хуулиудаараа цөөнхийн хэл, соёлыг сурталчлан өвлүүлэх, дэмжих хөгжүүлэх бодлого зарлан тунхаглаад байгаа билээ. Гэвч энэ асуудлаар судалгаа байхгүй тул энэ нь ажиглалт төдий дүгнэлт болохыг анхааруулж байна.

Энэ бүлэгт танилцуулсан онолын хандлагууд нь хос хэлний бодлого, хос хэлний боловсролын бодлогыг нийгэмд бүхэлд нь, мөн хэл соёлын цөөнх иргэдэд үзүүлэх үр нөлөөг тооцож ойлгоход дэм болох юм. Аль онолын хандлагаар бодлогоо боловсруулан хэрэгжүүлэх талаар үндэслэлтэй, тал талаас нь ярилцаж, гарах үр нөлөөтэй нь холбон хэлэлцэж, сонголт хийхэд энэхүү онолын суурь мэдээлэл нь бодлого боловсруулагч, хэрэгжүүлэгч боловсролын салбарын удирдлага, менежер, багш нарт, бодлогын нөлөөнд өртөж буй хүүхэд, тэдний эцэг эх, цөөнхийн бүлэг зэрэг сонирхогч тал, мөн нийгмийн бүх гишүүнд тус болно хэмээн найдаж байна.

Товч дүгнэх юм бол, хүчтэй хос хэлт нийгэм нь хүн амынхаа хэл, соёлын олон талт байдлыг хүлээн зөвшөөрөхөөр хязгаарлахгүй, нийгмийнхээ давуу тал, үнэт зүйл болгож хөгжүүлэх боломжийг хангасан цөөнхийн хэлийг хадгалах, өвлүүлэх, хөгжүүлэхийн зэрэгцээ монгол хэлийг эзэмших үр нөлөө бий болгохыг зорьж, энэ зорилтод хүрэх боломжийг олгосон хос хэлний боловсролын бодлого, хөтөлбөр хэрэгжүүлж байна. Харин нийгэм нь нэг хэл, соёлтоор ижилсэж, харин цөөнхийн хэл, соёлын эрхийг хүндэтгэсэн нийгэм бий болгохыг зорьж байгаа бол сул хос хэлний ур чадвартай нийгэм бий болгоход туслах хос хэлний бодлого хэрэгжүүлэх сонголтыг хийж болно. Гагцхүү нэг хэл, соёлоор нийгмийн ижилслийг бий болгох ойлголт, хандлага нь ерөнхийдөө хуучирч байгаа бөгөөд орчин үед хэл соёлын олон талт байдал нь тухайн нийгмийн баялаг, олон хэл нь цахим болон бизнес орчинд давуу тал, харилцааны нэмэлт хэрэгсэл, гадаад харилцаанд хүний олон эрхийг хүндэтгэн хөхиүлэн дэмжиж байгаагийн илрэл болж байна.

Гэхдээ Монгол Улс өнөөдөр хос хэлний бодлогоороо цөөнхийн иргэдийн эрхийг хангах хамгаалахын зэрэгцээ нийгмийн баялаг, эдийн засгийн нөөц болгож чадаж байна уу? Хос хэлний боловсролыг зөвхөн тодорхой орон нутгийн мөн чанартай нийгмийн асуудал гэсэн хязгаарлагдмал ойлголтыг халж, хаана, ямар нөхцөлд амьдарч, сурч байгаагаас үл хамааран цөөнхийн хүүхдүүд хос хэлний боловсрол эзэмших нөхцөл, боломжийг бүрдүүлэх замаар цөөнхийн хэл, соёлын хадгалагдан, уламжлагдах чанарыг өсгөн нэмэгдүүлэхэд анхаарах хэрэгтэй. Олон хэл, соёлын тухай мэдлэг, туршлага нь тухайн

нийгмийн баялаг, өрсөлдөх чадварын нэмэгдүүлэх давуу тал юм бол цөөнхийн хэл, соёлын тухай мэдлэгийг олонхын хүн амд хүргэх нь чухал болж байна. Хэлний цөөнх иргэдийг хоёр хэлний бүтээлч ур чадваруудтай болгож хөгжүүлэхийн зэрэгцээ мөн олонх хүн амыг хос хэл, соёлын талаар мэдлэгтэй, сонирхсон нэг нь сурах боломжтой болгох замаар Монголын нийгэмд байгаа хос хэл, соёлын давуу талыг нийгмийн нөөц баялаг, давуу тал болгох боломж бүрдэнэ. Өөрөөр хэлбэл, хос хэлний бодлогыг амжилттай хэрэгжүүлэхийн тулд хос хэл, соёлын бодлого, үйлчилгээг зөвхөн цөөнх төвлөрөн амьдарч байгаа нэг аймгаар хязгаарлахгүй үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх нь зүйтэй.

БҮЛЭГ 2. МОНГОЛ УЛС ДАХ ХОС ХЭЛНИЙ БОЛОВСРОЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ХЭРЭГЖИЛТ

Өмнөх бүлэгт танилцуулсан онолын тойм нь нь хос хэлний бодлого, хос хэлний боловсролын бодлого, хөтөлбөрийн хувилбаруудыг нийгэмд үзүүлэх үр нөлөөтэй нь холбож ойлгоход туслах бол энэ бүлэгт бид манай улсын хос хэлний боловсролын бодлого эрх зүйн орчин, түүний хэрэгжилтийн асуудлыг авч үзнэ. Энэ бүлэгт хос хэлний боловсролыг хэрэгжүүлж буй өөрийн орны туршлагыг Европын холбооноос гаргасан зөвлөмж дах¹⁹ хос хэлний боловсролын бодлогын үр өгөөжид нөлөө үзүүлэгч зургаан хүчин зүйлсийн дагуу үнэллээ (Хүснэгт 12).

ХҮСНЭГТ 12. Хос хэлний боловсролын амжилтад нөлөөлөгч бодлогын зургаан хүчин зүйлс

Хүчин зүйл		Тайлбар
1	Цөөнхийн хүүхдийн эх хэлний боловсролын тасралтгүй байдлыг хангах	СӨБ-ын түвшнээс авахуулаад 12 дугаар анги төгсөх хүртэлх нийт хугацаанд цөөнхийн хүүхдүүд эх хэлээрээ сурч боловсрох ёстой
2	Цөөнхийн хэлээр сурч боловсрох эрх зүйн орчныг бүрдүүлэх	Хэлний цөөнхийн эх хэлээрээ сурч боловсрох эрхийг хуульчилсан байх
3	Хос хэлний боловсролын бодлогод иргэдийн оролцоог хангах	Цөөнхийн хэлээр албан боловсрол олгох, ер нь хос хэлний боловсролын асуудлаар бодлого шийдвэр гаргах, хэрэгжилтийг хянахад хэлний цөөнх иргэдийг оролцуулах, зөвлөлдөх боломжийг хангасан байх
4	Хос хэлний боловсролын төлөвлөлт, түүний хэрэгжилтэд хяналт тавих	Цөөнхийн асуудал анхаарлын гадна үлдэхээс сэргийлж боловсролын болон бусад салбарын нийтлэг бодлого шийдвэр нь хос хэлний боловсролд хэрхэн нөлөөлөхийг тооцоолж, уялдаа холбоотой төлөвлөх

19 Эх сурвалж: Council of Europe (2020). Good practices of multilingual and minority language medium education

5	Цөөнхийн хэл дээрх сургалтыг дэмжих дэд бүтцийг хөгжүүлэх	Цөөнхийн хэл дээрх чанартай сайн сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангах, хүрэлцэхүйц тооны багш бэлдэж, арга зүйн дэмжлэгээр тогтмол хангах
6	Анги танхимаас гадуур орчинд цөөнхийн хэлийг харилцаанд ашиглах боломжийг хангах. Үүнд дараах гурван асуудлыг хамруулж үзнэ: - Хэлийг ашиглах чадамж - Хэлийг ашиглах боломж - Хэлийг ашиглах хүсэл	Аливаа хэлийг эзэмшихэд тухайн хэлийг анги танхимаас гадуурх өдөр тутмын харилцаанд ашиглах дадал чухал тул цөөнхийн хэлийг сургуулиас гадна мөн гэр бүл, нийгмийн харилцаанд ашиглах боломж, сонирхлыг дэмжих

Бодлогын хүчин зүйл 1: Цөөнхийн хүүхдүүд СӨБ-ын түвшнээс авахуулаад ЕБС-ыг дуустал эх хэлээрээ боловсрол тасралтгүй олох боломжоор хангагдсан байх

СӨБ-ын түвшнээс 12 дугаар анги дуусталх бүхий л хугацаанд цөөнхийн хүүхдүүд эх хэлээрээ сурч боловсрох боломжтой байх нь хос хэлний ур чадварыг бэхжүүлж, хос хэлний боловсролын бодлогыг үр нөлөөг нэмэгдүүлнэ. Анги дэвшихийн хэрээр албан ёсны хэлээр заах хичээлийн тоо нэмэгдсээр байх ч цөөнхийн хүүхдийн эх хэлээр заах хичээл нь сургалтын хөтөлбөрийн 50 хувиас буухгүй байх нь зохимжтой. Манайд хэлний цөөнх хүүхдүүдэд эх хэл болон монгол хэлийг ижил түвшинд зааж сургах зорилт бодлогын зорилт болж дэвшүүлэгдээд байгаа ч уг бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх хөтөлбөрүүд байхгүй байна.

Казах хүүхдүүдийн хос хэлний боловсрол нь СӨБ-ийн түвшнээс авахуулаад 12 дугаар анги дүүргэх хүртэл тасралтгүй байх шалгуурыг хангаж байна. Бодлогын хувьд тодорхойлж, онолын үндэслэлийг боловсруулаагүй ч казах хүүхдүүдийн хос хэлний боловсрол нь эх хэл X_1 (казах хэл) + X_2 (монгол хэл) = X_1+X_2 гэсэн загвартай эх хэл болон монгол хэлийг хослуулан эзэмшүүлэх загварыг хэрэгжүүлэх зорилтод чиглэж буй нь харагддаг. Харин энэхүү загварыг хэрэгжүүлэхдээ хоёр хэлний тэнцвэрийг хангасан

хөтөлбөрийг Боловсролын Хүрээлэн боловсруулж, БСШУ-ны Сайд батлах үүрэгтэй ч уг үүргийг орон нутагт шилжүүлсэн бөгөөд судалгаа шинжилгээ, арга зүйн дэмжлэггүй орон нутаг өөрөө хос хэлний боловсролын ярвигтай асуудлыг тэнцвэртэй шийдэх боломж хомс юм.

Одоогоор боловсролын үйлчилгээний дэд бүтцийн чухал хэсэг болох казах хэл дээрх СӨБ-ын хичээл сургалтын ном, материал хангагдаагүйн улмаас “сургуульд элсэн орох үед хэл яриа, үгийн баялгаар монгол хэлтэн хүүхдээс хоцрох”²⁰ хандлага илэрдэг ажээ. Хос хэлний хөтөлбөрийг батлахдаа орон нутгийн боловсролын удирдлагууд сурагчдын ачааллыг хэвийн болгох үүднээс монгол хэлний цагаас хасаж тэнцвэржүүлэх практикийг ашиглаж байна. Энэ нь монгол хэлний үр дүн сулрахад хүргэж байгаа ч энэ үр дүн нь ЕБС-д суралцаж байх хугацаанд бус харин хуримтлагдсаар ЭЕШ-ийн шалгалт өгөх, их дээд сургуульд элсэн суралцах үед илэрдэг бололтой.

Баян-Өлгий аймгаас бусад аймагт амьдарч буй цөөнхийн хүүхдүүд казах, тува хэлээр боловсрол эзэмших, эх хэлээ эзэмших сургалтад хамрагдах боломжгүй байна. 2021 онд “Бүх нийт боловсролын төлөө!” иргэний нийгмийн эвслээс хийсэн судалгаанд оролцогч үндэсний цөөнх залуучууд өөрсдийгөө хос хэлтэн гэж үздэг ч эх хэлээ хангалттай сайн мэдэхгүй байгаадаа санаа зовнидог, казах хэл сурахыг хүсдэг ч тухайн орон нутагт нь казах сургууль, казах хэлний сургалтын төв байхгүй тухай дурджээ.

Тува хүүхдүүдийн хос хэлний боловсрол нь бага ангиар хязгаарлагдаж, дунд ангиас эх хэлээ бие даасан хичээлээр судалж үндсэн сургалтыг хэл нь монгол хэл болж байна. Цөөнх хүн амын нийт хүн амд эзлэх хувь хэмжээ нэлээд бага байгаа бол зөвхөн бага ангид нь эх хэлээр хичээл зааж, дунд ангиас олон багш хичээл зааж эхлэх үед албан ёсны хэл рүү бүрэн шилжих туршлага дэлхий даяар ажиглагддаг ч ийм бодлогын нийгмийн үр нөлөө хамгийн сул, цөөнх хүүхдүүдийн эх хэлний ур чадвар хангалттай сайн хөгжихгүй

20 БСШУСЯ, Боловсролын хүрээлэн, ЮНЕСКО (2019). Монгол Улсын боловсролын суурь мэдээллийн тайлан

гэж судлаачид шүүмжилдэг. Нөгөө талаас 1990-ээд оны шилжилтийн хүнд цаг үед авч хэрэгжүүлсэн дотоодын бодлого ч нөлөөлсөн талтай. 1997 онд боловсролын салбарын бүтцийг оновчтой болгож, үр ашгийг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд багийн бага сургуулиудыг татан буулгаж, сумын ахлах сургуулиудыг шат бууруулах, нэгтгэх нийтлэг бодлогын хүрээнд хос хэлний боловсролын мөн чанарыг харгалзалгүй Баян-Өлгийн аймгийн тува хоёр бага сургуулийн нэгийг нь зэргэлдээ сумын казах сургуультай нэгтгэж, нөгөөг нь 5 жилийн бага сургууль болгож өөрчилсөн нь өнөөдөр тува хүүхдүүдийн эх хэлээрээ тасралтгүй боловсрол эзэмших эрхэд сөргөөр нөлөөлж байна. Зөвхөн бага ангиудад ашиглах тува хэлний гарын авлагатай (сурах бичиг байхгүй), дунд болон ахлах ангиудад тува хэлний сурах бичиг байхгүй, мөн дунд болон ахлах ангиудад цагийн ачаалал бага тул бүтэн цагаар ажиллах багш авах боломжгүй байдал нэгэнт бий болжээ.

Баян-Өлгийн аймгийн хэмжээнд ЕБС-ийн 22155 сурагчийн 19283 нь казах, монгол хос хэлний хөтөлбөрөөр, 178 сурагч тува, монгол хэлний²¹ хос хэлний хөтөлбөрөөр суралцаж байна. 300 хүрэхгүй тува хүүхдийн хүүхэд дунд болон ахлах ангидаа тува хэлийг бие даасан хичээлээр үзэж судлах сургалтын төлөвлөгөө хэрэгжиж байна. Эх хэлийг бие даасан хичээлээр заах нь хэлээ насан туршийн хэрэглээ болгох талаасаа үр дүн муутай арга бөгөөд хуваарьт долоо хоногийн нэг цагийн хичээлээр хэлээ судлах, үгийн сангаа баяжуулах, дадлага хийж хэрэглээ болгох хангалттай нөхцөл бүрддэггүй гэж судлаачид үздэг. Тува хэлийг дунд болох ахлах ангид бие даасан хичээлээр үзэж байгааг эргэж харах шаардлагатай гэж дүгнэж байгаа ч энд нэгэн ярвигтай онцлогийг анхаарах хэрэгтэй. Тувачууд “цөөнхийн дундах цөөнх” хэмээн нэрлэж болохуйц нөхцөлд Баян-Өлгий аймгийн казах хүн амын дунд цөөнх болж суурьшин амьдарч байгаа онцлогийн улмаас монгол хэл рүү эрт шилжих бодлогыг дэмжих хандлагатай байдаг. Гэхдээ монгол хэлт угсаатан гэсэн ижилслийн зэрэгцээ тува хэл, соёлоо хадгалж хөгжүүлэх хүсэл, хэрэгцээг бас давхар анхаарч, боловсролын орчинд монгол хэл рүү эрт шилжүүлэх

21 БСШУСЯ, Боловсролын хүрээлэн, ЮНЕСКО (2019). Монгол Улсын боловсролын суурь мэдээллийн тайлан

хос хэлний бодлогыг халж, урт хугацаандаа илүү үр нөлөөтэй хоёр хэлийг сургалтад идэвхтэй ашигласан хос хэлний нэмэгдэх загварын хөтөлбөр хэрэгжүүлэхэд анхаарах хэрэгтэй хэмээн дүгнэж байна.

2021-2030 оны Монгол Улсын Боловсролын салбарын Мастер төлөвлөгөө хэмээх баримт бичигт “Тува хүүхдүүд байгалийн ухаан, шинжлэх ухааны хичээлээр элсэлтийн ерөнхий шалгалт өгч чадахгүй байгаа, шинжлэх ухаан, технологи, инженер, математикийн салбарт элсэн суралцах боломжгүй байгаа нь тэдний боловсролын чанар хүртээмжид шийдвэрлэгдээгүй асуудлууд оршсоор байгааг харуулна”²² хэмээн тува хүүхдүүдийн боловсролын чанарт ахиц гарахгүй байгааг онцолжээ. Дөнгөж 2019 онд бүрэн боловсролын тува хэлний хөтөлбөр, суралцахуйн удирдамж боловсруулагдаж, хэвлэгдэн гарсан²³ нь Цэнгэл сумын тува бага сургуулийг өргөтгөж, 9 жилийн сургалттай тува дунд сургуульд болгох шийдвэрийг хэрэгжүүлэхэд томоохон дэмжлэг болох юм. Гэхдээ энэхүү шийдвэр нь 2022-2023 оны хичээлийн жилээс хэрэгжиж эхлэх төлөвлөгөөтэй байна.

Цаатнууд төвлөрөн амьдардаг Хөвсгөл аймагт тува хэл заахтай холбоотой зарим ажил хийгдэж байгаа боловч үйл ажиллагаа нь жигдрээгүй, үр дүн нь тодорхой гараагүй байна. Боловсролын хүрээлэнгийн ажлын хэсгийн цуглуулсан мэдээллээр Цагааннуур сумын сургуульд 454 сурагч суралцаж байгаагийн 160 нь цаатан (тува) хүүхдүүд байгаагаас баруун тайгад 30, зүүн тайгад 24 сурагч, бусад нь сумын төвийн хүүхдүүд байна.²⁴ 2013 оноос хэрэгжиж байсан цаатан хүүхдүүдэд эх хэлийг нь эзэмшүүлэх зорилготой үндэсний зорилтот хөтөлбөр тасалдаж, одоо зогсонги байдалд оржээ. Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын тува-цаатан иргэд, хүүхдүүд монгол хэлээр давамгай харилцаж, эх хэл нь хоёр дах хэл болоод зогсохгүй цаашид мартагдах эрсдэл бий болсон байна. Хөвсгөл аймгийн удирдлагууд цаатан түмний зөвхөн нийгмийн хамгаалал, хангамж, тэтгэмжид анхаараад хэл, соёлд нь бага анхаардаг гэж судлаачид шүүмжилж байна. Цагааннуур сумын сургуулийн удирдлагаар цаатан иргэнийг

22 Монгол Улсын боловсролын Мастер төлөвлөгөө 2021-2030

23 Ж.Зульмира, Б.Алтангул, Б.Ардак, Г.Чулуун-Эрдэнэ, Б.Бахатгул, Д.Тунгалаг (2021). Хос хэлний боловсролын өнөөгийн нөхцөл байдал. Улаанбаатар.

24 БСШУСЯ, Боловсролын хүрээлэн, ЮНЕСКО (2019). Монгол Улсын боловсролын суурь мэдээллийн тайлан

томилон ажиллуулж байгаа нь сайшаалтай ч одоогоор тодорхой өөрчлөлт харагдахгүй байна.

Дүгнээд харахад, Монгол Улсад хэлний цөөнх хүүхдийн эх хэлний боловсролын тасралтгүй хангах зорилт эрх зүйн орчны түвшинд тодорхойлогдсон ч боловсролын үйлчилгээний түвшинд бүрэн хангагдаагүй байна. Тува хүүхдүүд бага ангидаа тува хэл дээр боловсрол эзэмшээд, дунд ангидаа казах сургуулийн нэг бүлэг болж хичээллэхдээ тува хэлний мэргэжлийн багшаар тэр бүр хангагдаж чадахгүй байгаа бөгөөд дунд, ахлах ангид тува хэлийг тусдаа хичээлээр судалж байгаа нь хэлний хэрэглээ, ур чадвар болж төлөвшихөд хангалтгүй юм. Казах хүүхдүүд 1-12 ангид казах хэл дээр сурч, монгол хэлний бие даасан хичээл, мөн тодорхой хичээлүүдийг монгол хэл дээр судалж байгаа нь эх хэлний боловсролын тасралтгүй байдлыг хангахад хамгийн ойртсон хөтөлбөр мөн боловч эх болон монгол хэлний сургалтын чанарыг сайжруулах хэрэгцээ байгаа нь ажиглагддаг. Тува хүүхдүүдийн тува хэлний боловсрол дунд ангиасаа тасалдах, казах хүүхдүүдийн казах хэлний боловсрол тасралтгүй боловч чанарт анхаарах, цаатан хүүхдүүдийн эх хэлээрээ боловсрол эзэмших эрх албан боловсролд анхнаасаа зөрчигдөж байх магадлалтай байна.

Бодлогын хүчин зүйл 2: Цөөнхийн хэлээр сурч боловсрох эрхзүйн орчин бүрдсэн байх

Хэлний цөөнх хүүхдүүдийн сурч боловсрох эрхийг НҮБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглал (1948), Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт (1966), Хүүхдийн эрхийн тухай конвенц (1990), НҮБ-ын Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны байгууллагын Боловсрол дахь ялгаварлалын эсрэг конвенци (1960), Үндэс угсаа, арьс өнгөөр ялгаварлахын эсрэг тунхаглал (1970), Хүний эрх, ардчиллыг хамгаалахад чиглэгдсэн боловсролын хүрээг тодорхойлсон тунхаглал (1995), Соёлын ялгаатай байдлын талаарх түгээмэл тунхаглал (2002) зэрэг олон улсын баримт бичигт тусгасан байдаг. Монгол Улс эдгээр олон улсын гэрээ, конвенцид нэгдэн орсон улс орны хувьд өөрийн эрхзүйн орчныг эдгээрт нийцүүлэн, хэрэгжүүлж байна.

Монгол Улсын хос хэлний талаарх эрх зүйн орчныг 1992 оны Монгол Улсын Үндсэн хууль, 2015 оны Монгол хэлний тухай хууль, 2002 оны Бага, дунд боловсролын тухай хууль, 2021 оны Соёлын тухай хууль, тэдгээрт нийцүүлэх, хэрэгжилтийг нь хангах зорилгоор Засгийн газар, холбогдох Яамдын баталсан эрх зүйн баримт бичгүүд бүрдүүлж байна. Үүнд:

ХҮСНЭГТ 13. Эх болон албан ёсны хэлний талаарх эрх зүйн орчин

Эрх зүйн баримт бичиг	Заалт	Тайлбар
Монгол Улсын Үндсэн хууль	8.1. Монгол хэл бол төрийн албан ёсны хэл мөн. 8.2. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн заалт нь хүн амын өөр хэл бүхий үндэстний цөөнх эх хэлээрээ суралцах, харилцах, соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах эрхийг үл хөндөнө. 14. Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно.	Дэлхийн 156 орны жишгээр Монгол Улсын Үндсэн хуульд төрийн албан ёсны хэлээ зааж өгчээ. Зарим улс албан ёсны хэлээ Үндсэн хуульд биш, Албан ёсны хэлний тухай хуульд зааж өгдөг. Цөөн хэдэн улс албан ёсны хэлээ огт хуульчлаагүй байдаг (жишээлбэл, АНУ) бөгөөд албан ёсны хэл нь түүхэн хөгжлийн явцад төрийн үйл хэрэгт ашиглагдаж хэвшсэн хэл гэж ойлгодог. ²⁵

25 Эх сурвалж: Ардчилал, сонгуулийг дэмжих олон улсын хүрээлэн (2021). Үндсэн хуулийн цуврал 20. Албан ёсны хэлийг сонгох нь, хуудас 18

Монгол хэлний тухай хууль	13.1. БШУ-ны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах үүрэг хүлээнэ: 13.1.4. суралцагчдын дийлэнх олонх хүн амын өөр хэл бүхий үндэстний цөөнх байвал сургалтыг хос хэлний хөтөлбөрөөр явуулах бөгөөд хос хэлний хөтөлбөрийн агуулгыг батлах; 13.1.5. үндэстний цөөнх монгол хэл болон эх хэл дээр боловсрол эзэмших, соёл, зан заншлаа өвлөх, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах. 21.7. [Хэлний бодлогын Үндэсний] Зөвлөл дараах үүрэг хүлээнэ 21.7.2. үндэстний цөөнхийн хэл, монгол угсаатны аман аялгууг судлах, хамгаалах, хөгжүүлэх, гадаад оронд суугаа монгол үндэстнүүд, олон улсын хэмжээнд монгол хэл, бичиг үсгийн хэрэглээ, сургалт судалгааг өргөжүүлэх, дэмжих чиглэлээр бодлого боловсруулж, Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэх.	Цөөнхийн хүн ам төвлөрсөн орон нутагт л хос хэлний боловсролын хөтөлбөр хэрэгжих боломжтой гэж ойлгогдох эрсдэл 13.1.4 дүгээр заалтад агуулагдсан байна. Харин 13.1.5 дугаар заалт нь тодорхой хязгаарлалт агуулаагүй тул өмнөх заалтын хязгаарлалтыг даван туулах боломж олгож байна. Харамсалтай нь, казах, тува цөөнх төвлөрөн амьдардаг Баян-Өлгий аймгаас бусад орон нутагт хос хэлний боловсролын хөтөлбөр, хэлний цөөнхийн эх хэл, соёлыг эзэмшүүлэх үйлчилгээ алга байна. Цөөнхийн хэлийг хөгжүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэх ёстой Хэлний бодлогын үндэсний зөвлөл хэр эрх мэдэлтэй нь тодорхойгүй ч боловсрол, хос хэлний боловсролын нэг чухал оролцогч, дэвшилтэт бодлогын дэмжигч байх ёстой тул уг Зөвлөлийг бодлогын оролцогч болгож оруулж ирэх шаардлагатай.
Боловсролын тухай хууль (2002)	5.1.2. иргэнийг сурч боловсроход үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, хөгжлийн онцлог, эрүүл мэнд, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхахгүй байх, эх хэлээрээ сурч боловсрох тэгш боломж, нөхцөлөөр хангана 45.1.8. [Сурагч] уламжлалт соёл, зан заншлыг өвлөх, сургуулийн орчинд төрөлх хэлээрээ харилцах [эрхтэй]	Уг хоёр заалт нь үндэсний цөөнх хүүхдийн хэл, соёлын эрхийг бүрэн хангасан байна. “Сургуулийн орчинд” гэсэн нь нийгэм, гэр бүлийг орчинд эх хэлээрээ харилцахад хязгаарлалт болохгүй, харин сургуулийн орчинд нэмэлт дэмжлэг болсон заалт гэж ойлгож байна.

Бага, дунд боловсролын тухай хууль	4.1.1. [бага боловсролын агуулга нь] “эх хэлээрээ зөв ярьж, бодол санаагаа ойлгомжтой илэрхийлэх, уншиж, бичиж сургах”, 5.1.1 [суурь боловсролын агуулга нь] “эх хэл болон гадаад хэл, математик, мэдээлэл зүй, шинжлэх ухаан, эрх зүйн зохих шатны мэдлэг, өөрийн авьяас, чадварт тулгуурлан бие даан амьдрахад шаардлагатай чадвар, дадал эзэмшүүлэх”; 6.1.1. [бүрэн дунд боловсролын агуулга нь] “эх хэлээрээ утга төгөлдөр найруулж бичих, ярих чадвар, гадаад хэлний зохих мэдлэг эзэмшүүлэх” зорилгод чиглэх тухай заажээ.	Эх хэл, гадаад хэл гэсэн хоёр л хэлийг заасны улмаас эх хэл гэж монгол хэлийг гэж ойлгон, улмаар хэлний цөөнхийн эх хэл багтаагүй гэж ойлгох эрсдэлтэй. Албан ёсны/олонхын эх хэл болсон монгол хэл, цөөнхийн эх хэл хэмээх ойлголтыг зааглаж, нэмж тодруулах шаардлагатай гэж үзэж байна.
Соёлын тухай хууль	4.1.3. соёлын илэрхийллийн олон төрөлд хүндэтгэлтэй хандах, хамгаалах, дэмжих бодлого хэрэгжүүлэх 19.2. угсаатан ястны соёлыг ялгаварлан гадуурхах, хавчин хязгаарлахыг хориглоно	Монгол Улс нь олон соёлт нийгэм болохыг тунхаглажээ.
Хүүхдийн эрхийн тухай хууль	6.1.2 төрөлх хэл, бичиг үсэг, ёс заншил, түүх соёлын уламжлалыг өвлөн эзэмших эрхтэй	Төрөлх хэл хэмээх нэр томьёо бусад хуульд ашиглагдаагүй ч эх хэл хэмээх ойлголттой дүйж байна. Энэ нь олонхын хувьд монгол хэл, цөөнхийн хувьд эх хэл гэж ойлгож болох ч нэр томьёоны хувьд нэг мөр тодорхойлж цэгцлэх шаардлагатай.
“Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого	Орчин үеийн шинжлэх ухааны арга зүйгээр нарийвчлан судалж, хөдөлшгүй бодит баримтад үндэслэсэн “эх хэл, эх түүх, өв соёлыг” нийт хүн амд төлөвшүүлж, үндэсний ижилсэл-ондоошлын гүн ухамсар, дархлаатай үндэстэн-улс байгуулахад тулгуур болохуйц нэгдмэл үнэт зүйлсийг цогцлооно”, “Хүн бүрийн эх хэлний боловсролыг дээшлүүлж, бүх шатны сургалтын байгууллагад монгол хэл, бичгийн боловсролыг суралцагчдад чанартай эзэмшүүлнэ”,	Эх хэл гэж монгол хэл, эсвэл дээрхийн ижил төрөлх хэлийг хэлж байгаа нь тодорхойгүй ч дараагийн өгүүлбэрт эх хэл, монгол хэл хэмээн ялгаснаас харахад төрөлх хэл гэсэн утгаар, цөөнхийн хэлийг хүндэтгэсэн хандлагаар орсон гэж ойлгож болохуйц байна.

Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого	4.4. [Бүх шатны боловсролын байгууллагад] ...суралцагчдын дийлэнх олонх нь хүн амын өөр хэл бүхий үндэстний цөөнх байвал эх хэлээрээ бага боловсрол эзэмших нөхцөл, боломжоор хангаж, хос хэлний сургалтын бодлого, хөтөлбөр хэрэгжүүлнэ	Зөвхөн цөөнхийн хүн ам төвлөрч амьдардаг орон нутагт, зөвхөн бага боловсролын түвшнээр хос хэлний бодлогын хүртээмжийг давхар хумьсан сул тал ажиглагдаж байна.
Засгийн газрын 2010.03.17-ний өдрийн 66 тоот “Казах хүүхдийн боловсролын үйлчилгээний чанарыг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоол	- Боловсролын Хүрээлэнгийн бүтцэд казах хүүхдийн СӨБ, бага, дунд боловсролын эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхлэх сектор байгуулах - Казах хэл дээр сургалт явуулдаг ЕБС-ийн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг хянаж, казах болон монгол хэл судлах цагийг шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоох замаар сургалтын чанарыг сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх - Аймгийн боловсролын байгууллагын удирдлага, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлж, казах иргэдийн монгол хэлний мэдлэгийг дээшлүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх	БСШУ-ны сайдын 2007 оны 425 дугаар тушаалаар баталсан “Казах хүүхдийн боловсролыг дэмжих хөтөлбөр”-т өөрчлөлт оруулан, БСШУ-ны сайдын 2010 оны 106 дугаар тушаалаар “Баян-Өлгий аймгийн боловсролын үйлчилгээний чанарыг сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөө”-г батлан хэрэгжүүлж байна. Гэхдээ хос хэлний боловсролын хөтөлбөрийг Баян-Өлгий аймгийн удирдлагууд батлан хэрэгжүүлж байгаа өнөөгийн нөхцөлд Боловсролын Хүрээлэн, БШУЯ-ны мэргэжил арга зүйн болон бодлогын оролцоог бодитоор үнэлж тогтоох шаардлагатай.
БСШУ-ны Сайдын 2010.03.19-ний 106 тоот “Хөтөлбөрт өөрчлөлт оруулж, төлөвлөгөө батлах тухай” тушаал	БСШУ-ны Сайдын “Хөтөлбөр батлах тухай” 2007 оны 425 дугаар тушаалаар баталсан “Казах хүүхдийн боловсролыг дэмжих хөтөлбөр”-ийн 4.4-т казах хүүхдийн боловсролын агуулга, арга зүйн судалгаа, шинжилгээний нэгж байгуулах гэснийг өөрчлөн, СӨБ, бага, дунд боловсролын эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хариуцсан Казах хүүхдийн боловсролын тасаг байгуулах	Судалгаанд суурилан хос хэлний боловсролыг хөгжүүлэх болон казах хүүхдийн боловсролын чанарыг судалгааны үндсэн дээр сайжруулах зорилгын хүрээнд Боловсролын Хүрээлэнд шинэ нэгжийг байгуулсан.

Боловсролын Хүрээлэнгийн захирлын 2011.09.06-ны өдрийн 16 тоот тушаал	БСШУ-ны Сайдын “Хөтөлбөрт өөрчлөлт оруулж, төлөвлөгөө батлах тухай” 2010 оны 03 сарын 19 өдрийн 106 тоот тушаалаар батлагдсан “Баян-Өлгий аймгийн боловсролын үйлчилгээний чанарыг сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний дагуу Боловсролын Хүрээлэнгийн захирлын 2011 оны 9 дүгээр сарын 06-ны өдрийн 16 тоот тушаалаар Боловсролын Хүрээлэнгийн бүтцэд Казах хүүхдийн боловсролын судалгааны сектор байгуулагджээ. Сектор нь казах, тува хэлний сургалтын төлөвлөгөө, стандарт, хөтөлбөр, сурах бичиг боловсруулж, хэрэгжилтийг хангах, үр дүнд хяналт шинжилгээ хийх үүрэгтэй ажиллаж байна.	2013 онд бага ангийн эх хэлний (казах, тува) хөтөлбөр, суралцахуйн удирдамж гарсан нь өнөөг хүртэл ашиглагдаж байна. 2018 онд суурь боловсролын эх хэлний (казах, тува) хөтөлбөр, суралцахуйн удирдамж боловсруулагдаж, тува хэлний хөтөлбөр хэвлэгдсэн. Казах хэлний суурь боловсролын хөтөлбөрийг принтерээр хэвлэж, багш нарт хүргэсэн нь сүүлийн 30 жилд анх удаа эх хэлний хөтөлбөр боловсруулж, сургалтад нэвтрүүлсэн явдал болов. Бүрэн боловсролын тува хэлний хөтөлбөр, суралцахуйн удирдамж 2019 онд гарч, сургалтад нэвтэрч байна. Бүрэн боловсролын казах хэлний хөтөлбөр, суралцахуйн удирдамж боловсрогдож байна.
БСШУ-ны сайдын 2013 оны тушаал	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013.03.29-ний өдрийн “Цаатан хүүхдийн боловсролыг дээшлүүлэх тухай” 42 тоот зарлигийг хэрэгжүүлэх зорилгоор “Цаатан хүүхдийн боловсролын үйлчилгээний чанарыг сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөө” зэрэг баримт бичиг баталжээ.	Хөтөлбөрийн хэрэгжих хугацаа дууссан; цаатан хүүхдүүдийн боловсролтой холбоотой шинэ хөтөлбөр батлагдаагүй

Өнөөгийн байдлаар Монгол Улсын Үндсэн хууль, бусад 5 хууль, УИХ-ын тогтоолоор баталсан 3 хөтөлбөр, Засгийн газрын тогтоолоор баталсан 7 хөтөлбөрт тус тус үндэсний цөөнхөд хамааралтай зарим заалтыг оруулснаар үндэсний цөөнхийн эх хэлээрээ сурч боловсрох, соёл зан заншлаа өвлүүлэх эрхийг ерөнхийд нь баталгаажуулжээ. Гэхдээ зарим тохиолдолд эх хэл, төрөлх хэл, албан ёсны хэлний тухай ойлголтыг тодорхой зааж өгөөгүйн улмаас, жишээлбэл, “эх хэл” гэж олонхын хэл болох монгол хэлийг хэлж байна гэж ойлгогдох явдал ажиглагдаж байна.

Дээр дурьдсанчлан, Үндсэн хуульд хэлний цөөнхийн эх хэлээрээ суралцах, харилцах, соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах эрхийг хүлээн зөвшөөрч, Монгол хэлний тухай хуулийн 13.1.5 заалтаар “үндэстний цөөнх монгол хэл болон эх хэл дээр боловсрол эзэмших, соёл, зан заншлаа өвлөх, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэх” ажлыг эзэнтэй болгож, БШУЯ-д хариуцуулан хуульчилжээ. Уг заалтын хэрэгжилтийг хангах зорилгоор БСШУС-ын Сайдын 2015 онд батлан гаргасан А/220 тоот тушаал хэрэгжээгүй байна.²⁶

Үндсэн хуулийн 14 дүгээр заалтаар хүнийг үндэс угсаа, хэл зэргээр ялгаварлан гадуурхахыг хориглосон тул Үндсэн хууль болон Монгол хэлний тухай хуульд монгол хэл болон эх хэлээр боловсрол эзэмших, соёл, зан заншлаа өвлөх, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах нөхцөл нь үндэсний цөөнхийн бүх хүүхдэд хүрэх ёстой нийтлэг үйлчилгээ гэж ойлгогдож байна. Монгол хэлний тухай хуульд цөөнхийн хүн ам төвлөрсөн орон нутагт хос хэлний хөтөлбөр хэрэгжүүлэх, бусад орон нутагт хос хэлээр суралцах нөхцөл бүрдүүлэх гэж салгаж заасан нь нэг талаас төвлөрсөн цөөнх хүн амтай орон нутагт давуу тал болж болох ч бусад орон нутагт хос хэлний боловсрол орхигдох тодорхойгүй байдал үүсэж байна. Хэлний цөөнхийн хүүхдүүд гэсэн нийгмийн нэг бүлгийг төвлөрөн болон таруу амьдарч байгаагаар нь салгаж бодлого хэрэгжүүлэх нь хүний эрхийг хүндэтгэсэн хандлага болж чадахгүй, тухайн орон нутгийн боломж бололцооноос хамааруулан хэрэгжиж болох нэмэлт үйлчилгээ гэж ойлгогдох эрсдэлтэй. Олон улсын зөвлөмжүүдэд хос хэлний боловсролын үйлчилгээг “цөөнхийн хүн ам төвлөрсөн”, “нэг анги бүрдүүлэх тооны хүүхэд байгаа газар” зэрэг нөхцөл зааж хэрэгжүүлэх нь хүүхдийн эрх, цөөнхийн эрхийн зөрчил болно хэмээн анхааруулсан нь Монгол Улсад шууд хамааралтай сануулга юм. Тиймээс Баян-Өлгий аймгаас бусад аймаг, хот суурин газар амьдарч байгаа казах иргэд, Баян-Өлгий аймаг дотроо цөөнх болж байгаа 300 хүрэхгүй тооны тува сурагч, мөн Монгол улс даяар тархан амьдарч байгаа тува болон цаатан тува иргэдийн эх хэлээ эзэмших, эх

26 ЮНЕСКО. (2019). Монголын боловсролын бодлогын тойм шинжилгээ: Насан туршийн суралцахуйн тогтолцоог бүрдүүлэх нь. Улаанбаатар.

хэл дээрээ боловсрол эзэмших эрхийн асуудлыг хөндөн ярилцаж, үйлчилгээ бий болгох боломжийг эрэлхийлэх шаардлагатай.

Бодлогын хүчин зүйл 3: Хос хэлний боловсролын бодлогод иргэдийн оролцоог хангах

Цөөнх хүн амд чиглэсэн хос хэл, эх хэл, соёлын бодлого шийдвэрийг гаргах, хэрэгжилтийг хянахад иргэд, хүний эрх болон боловсролын мэргэжилтэн зэрэг төлөөллийг оролцуулах, зөвлөлдөх боломжийг хангах шаардлагатай.²⁷ Монгол Улсад бодлого шийдвэр гаргалт, тэдгээрийн хэрэгжилтэд олон нийтийн оролцуулах нэлээд хэдэн механизм хуульчлагдан хэрэгжиж байгаа ч тухайлан цөөнхийн хүүхдийн хос хэлний боловсролын бодлогын хүрээнд хэрэглэж байсан нь цөөн.

Хүний Эрхийн Үндэсний Комиссоос 2010 онд хэрэгжүүлсэн “Казах, тува хүүхдүүдийн сурч боловсрох эрх, хөдөлмөр эрхлэлтийн байдал” судалгааны тайланд БСШУ-ны Сайдын 2007 оны 425 тушаалаар батлагдсан “Казах хүүхдийн боловсролыг дэмжих хөтөлбөр”-ийн талаар судалгаанд хамрагдсан 140 эцэг, эхийн 34 хувь нь мэднэ гэж, харин 65 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. Уг нөхцөл байдал 2021 онд ч хэвээр байсан бөгөөд “Бүх нийт боловсролын төлөө!” иргэний нийгмийн үндэсний эвслээс хийсэн “Хос хэлний боловсролын бодлогын өнөөгийн нөхцөл байдал” судалгааны нэгдсэн тайланд “Үндэстний цөөнхийн өөрсдийн сурч боловсрох эрх болон хос хэлний боловсролтой холбоотой баримт бичиг, хууль тогтоомжийн талаарх мэдлэг сул байна” гээд, хос хэлний боловсролтой холбоотой шийдвэр гаргалт дахь олон нийтийн оролцоо хангалтгүй байна гэж дүгнэжээ.

Цөөнхийн эх хэлээрээ боловсрол олох, ер нь хос хэлний боловсролын асуудлаар бодлого шийдвэр гаргах, хэрэгжилтийг хянахад хэлний цөөнх иргэдийг оролцуулах, зөвлөлдөх боломжийг хангах шаардлагатай гэж олон улсын байгууллагууд зөвлөдөг²⁸ бөгөөд олон нийтийн оролцоог мэдээлэх, шийдвэр гаргахдаа оролцуулж зөвлөлдөх, хамтарч шийдвэр гаргах, иргэд өөрсдөө идэвх санаачилга

27 UNICEF (2011). The Right of Roma Children to Education. Position Paper.

28 Тухайлбал, UNICEF, дээрх эх сурвалж

гаргаж шийдвэрт нөлөөлөх гэсэн иргэний оролцооны дөрвөн түвшинд авч үзэх хэрэгцээ байгаа нь судалгааны дүнгээс харагдаж байна.

Бодлогын хүчин зүй 4. Хос хэлний боловсролын төлөвлөлт, түүний хэрэгжилтэд хяналт тавих

Хос хэлний боловсролын бодлого, хөтөлбөрийг боловсруулан, төлөвлөхдөө боловсролын болон бусад салбарын бодлоготой харилцан уялдаатай авч үзэх шаардлагатай. Хүн ам сийрэг, хүүхэд цөөн, төсөв өндөр зэрэг шалтгаанаар сургууль хаах, ойролцоох сургуультай нийлүүлэх зэрэг арга хэмжээ нь үндэсний түвшинд үр ашигтай, боломжийн шийдэл байж болох ч хэлний цөөнх хүн амын хувьд боловсролын хүртээмж, чанарыг доройтуулах, цөөнхийн хүүхдүүд сургууль завсардах шалтгаан болох эрсдэлтэй. Үүний нэг жишээ нь дэр дурдсан 1997 онд боловсролын салбарын зардлыг хэмнэх, багшийн дутагдлыг арилгах замаар чанарыг сайжруулах зорилгоор багийн бага сургуулиудыг хааж, цөөн хэдийг үлдээн сумын сургуулиудын харьяанд өгч системийн өөрчлөлт хийхдээ Баян-Өлгийн аймгийн тува хоёр бага сургуулийн нэгийг нь зэргэлдээ сумын казах сургуультай нэгтгэж, нөгөөг нь 5 жилийн бага сургууль болгож шатлал бууруулсан нь тува хүүхдүүдийн эх хэлээрээ тасралтгүй боловсрол эзэмших эрхэд сөргөөр нөлөөлсөн нь одоо ч арилаагүй байгаа явдал юм. Энэ шийдвэр нь тува хүүхдүүдэд тува хэл заах багшгүй болох, сургуулийн орчинд тува хэлээр харилцах боломжийг хумих зэрэг эрсдэл дагуулсан байна. Хэлний цөөнх бүлгүүдээс тува, цаатан хүн амын тоо цөөн учраас бага боловсролын түвшинд эх хэл дээрээ ашиглах сурах бичиг байхгүй, багш бэлтгэх болон багшийн мэргэжил дээшлүүлэх хөтөлбөр байхгүй, улмаар бодлогын анхаарлын гадна үлдэх эрсдэл өндөр байна.

Хос хэлний бодлогын хэрэгжилтийг төлөвлөхдөө бусад салбарын бодлоготой сайтар уялдуулан, онцлогийг нь төлөвлөлтийн шатанд тооцох, хэрэгжилтэд тогтмол мониторинг хийх нь чанар, хүртээмжийн доголдлоос сэргийлэх, шаардлагатай өөрчлөлтийг цаг алдалгүй тодорхойлж шуурхай арга хэмжээ авах боломжийг олгоно. 2010 онд Хүний Эрхийн Үндэсний Комисс нь “Казах, тува хүүхдүүдийн сурч

боловсрох эрх, хөдөлмөр эрхлэлтийн байдал” судалгааны хүрээнд ЕБС-ийн багш, сургалтын менежер, захирал 138 хүнээс судалгаа авахад БСШУЯ-ны сайдын 2007 оны 11 сарын 19-ны 425 тушаалаар батлагдсан “Казах хүүхдийн боловсролыг дэмжих хөтөлбөр”-ийн хэрэгжилт, үр дүнгийн талаар 25 хувь нь сайн мэднэ, танилцсан гэсэн бол 41 хувь нь дуулснаас цаашгүй, 34 хувь мэдэхгүй буюу сонсож байгаагүй гэж хариулжээ.

Цаашилбал, хуулийн зохистой, нийцтэй хэрэгжилтийг зохион байгуулахад төв болон орон нутгийн удирдлагууд анхаарах шаардлагатай байна. Тухайлбал, 2021 онд “Бүх нийтийн боловсролын төлөө!” иргэний нийгмийн үндэсний эвслээс хийсэн “Хос хэлний боловсролын бодлогын өнөөгийн нөхцөл байдал” судалгаанд Баян-Өлгийн аймагт Бага, дунд боловсролын тухай хуулийг зөрчин, ЕБС-ийн жилийн төлөвлөгөөг аймгийн Засаг дарга баталж байгааг тогтоожээ. Зүй нь, Бага, дунд боловсролын тухай хуулийн 7.3-д заасан “Ерөнхий боловсролын сургуульд мөрдөх сургалтын төлөвлөгөөг боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага боловсруулж, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хянаж, батална” гэж заасан байдаг бөгөөд энэ нь батдагдсан төлөвлөгөөний чанар, шинжлэх ухааны үндэслэл, бодлогын нийцтэй байдлын баталгааг салбарын Яам хариуцах зохицуулалт юм.

Баян-Өлгий аймгийн Цэнгэл суманд төвлөрөн амьдардаг тува хүүхдүүд 1-5 дугаар ангид тува сургуульд сураад, дунд ангиасаа сумынхаа казах сургуульд тусдаа бүлэг болж хичээллэж байна. Тува багш дутагдалтайн улмаас казах багш нар хичээл ордог бөгөөд хичээл заах үед зааварчилгааг казах хэлээр өгөх, сургалтын хөтөлбөр, хичээлийн агуулгаа суралцагчийн хэрэгцээтэй уялдуулахад анхаардаггүй, багшийн зүгээс өөрт амар хялбар арга замыг сонгодог тохиолдол гардаг хэмээн сурагчид дүгнэж байна. Энэ нь казах багшийн арга зүйн асуудал гэхээс илүүтэй тува багш, сурах бичиг, сургалтын материал дутагдалтай, тува-монгол хэлний хос хэлний хөтөлбөр байхгүй, арга зүй байхгүйн үр дагавар юм.

Уг судалгааны хүрээнд хос хэлний боловсролын төлөвлөлт, түүний хэрэгжилтийг хянахтай холбоотой албан ёсны статистик

мэдээ олдоц муутай, дийлэнхдээ судалгааны байгууллагуудаас гаргасан нэг удаагийн, голдуу аман мэдээлэл байгааг онцлох хэрэгтэй гэж үзлээ. Хос хэлний боловсролтой холбоотой нарийвчлал сайтай өгөгдөл байхгүй байгаа нөхцөлд хяналт мониторинг хийх, багш болон сурах бичгийг хүртээмж зэрэг нарийвчлан асуудлаар төлөвлөлт, хэрэгжилтийг эцэг эх, иргэний нийгмийн зүгээс хянаж оролцох (өмнөх хэсгийг үзнэ үү) боломж нэн хязгаарлагдмал байна гэж дүгнэлээ.

Бодлогын хүчин зүй 5. Цөөнхийн хэл дээрх сургалтыг дэмжих дэд бүтцийг хөгжүүлэх

Хос хэлний боловсрол жигдэрсэн газар ч хамгийн их хүч, тогтмол ажиллагаа шаарддаг асуудал бол цөөнхийн хэл дээр чанартай сайн сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүний хангамжийг зохион байгуулах, хүрэлцээтэй тооны багш бэлдэж, арга зүйн дэмжлэгээр тогтмол хангах асуудал байдаг. Улс орнуудын сайн туршлагаас хуваалцахад, судалгаа хийх, бодлогын уялдааг хангах, сургалтын хөтөлбөр болон хэрэглэгдэхүүн боловсруулах, багшийн арга зүйн хөгжлийг дэмжих дагнасан нэгж/ байгууллага ажиллаж байна.

Энэ туршлагаар БШУЯ нь Боловсролын хүрээлэн дээр Үндэсний цөөнх болон гадаад дахь монгол хүүхдийн боловсролын судалгааны сектор ажиллуулж, хос хэлний боловсролын хөтөлбөр боловсруулах, арга зүйг хөгжүүлэх, нөхцөл байдлыг судлах ажлыг гүйцэтгүүлж байна. Уг сектороос 2013-2017 онд цуглуулсан мэдээллээс үзэхэд хэлний цөөнх хүүхдийн боловсролын чанарт дорвитой ахиц гараагүй байна. 2016-2017 оны хичээлийн жилд сурагчдын казах хэлний сорилын гүйцэтгэл 59 хувь, тува хэлний сорилын гүйцэтгэл 58.2 хувь, монгол хэлний сорил 38,7 хувь тус бүр үнэлэгджээ. Энэ дотор монгол хэлний сорилын гүйцэтгэлийн оноо 2013 онд 43.3 хувьтай байснаа 2017 онд 38.7 хувьтай болж буурсан бол казах, тува хэлний сорилын гүйцэтгэлийн оноо өссөн байна. Багшийн хувьд ч мөн монгол хэлний гүйцэтгэлийн оноо 2013 онтой харьцуулахад 2017 онд буурсан үзүүлэлттэй байна.²⁹

29 БСШУСЯ, Боловсролын хүрээлэн, ЮНЕСКО (2019). Монгол Улсын боловсролын суурь мэдээллийн тайлан. Улаанбаатар: Гоо дизайн ХХК

Боловсролын хүрээлэнгээс Баян-Өлгий аймгийн боловсролын дэд бүтцийг сайжруулахад онцгой анхаарах шаардлагатай байгааг сануулсаар байна. Боловсролын Хүрээлэн нь уг аймагт сүүлийн 10-аад жилд боловсролын бодлого зохицуулалт алдагдаж, хуулиар боловсролын судалгааны байгууллага боловсруулж, боловсролын асуудал хариуцсан Сайд батлах ёстой сургалтын хөтөлбөрийг аймгийн Засаг дарга батлан хэрэгжүүлж байгаа нь “тодорхойгүй сургалтын төлөвлөгөө” хэрэгжүүлэхэд хүргэж байна гэж дүгнээд, орон нутгаас боловсруулсан сургалтын төлөвлөгөөнд монгол хэлний цагаас танах замаар эх хэлний цагийг гаргаж байгаа нь оновчтой шийдэл биш гэж үзэж байна. ХЭҮК казах сургуулийн сурах бичгийн хангамж, хүрэлцээ туйлын хангалтгүй байгаагийн зэрэгцээ сурах бичиг цагаасаа ихээхэн хоцорч нийлүүлэгдэж байгааг шүүмжилсэн байна.³⁰

Монголд тува хэлний сурах бичиг боловсруулж, хэвлэж байсан туршлага үгүй. 1980-аад онд Оросын Тувагаас нөөцөд хадгалагдаж байсан сурах бичгүүдийг цөөн тоогоор авч ашиглаж байгаад, 2010-аад онд ЮНИСЕФ-ээс хэрэгжүүлсэн төслийн хүрээнд 5 төрлийн сургалтын гарын авлагыг тува хэл дээр хэвлэснийг одоо сургалтад ашиглаж байна. Эдгээр нь боловсролын стандарт, сургалтын хөтөлбөрийн дагуу боловсруулсан албан ёсны сурах бичиг биш, гарын авлага төдий бөгөөд анх 2013 онд хэвлэгдсэнээс хойш шинэчлэгдээгүй тул хуучирсан байдалтай байна. ХЭҮК мөн Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын тува хүүхдүүдийн сургалтад ашиглах сурах бичгийн хангамж, хүртээмж муу байгааг анхааруулж байжээ.³¹

Өнөөдөр бага боловсролын түвшинд хэлний цөөнх хүүхдүүдийн ашиглах монгол хэлний сургалтын хөтөлбөр байхгүй, тува хэлтэн хүүхдийн 4, 5 дугаар ангийн монгол хэлний сурах бичиг байхгүй, 2, 3 дугаар ангийн монгол хэлний гарын авлага хүрэлцээ муутай байна. Дунд ангийн тува хэл, уран зохиолын сургалтын хөтөлбөр 2019 онд боловсруулагдсан боловч сурах бичиг байхгүй, казах хэлний

30 ХЭҮК (2010). Казах, тува хүүхдүүдийн сурч боловсрох эрх, хөдөлмөр эрхлэлтийн байдал. Улаанбаатар

31 Мөн тэнд

дунд ангийн сурах бичиг хэвлэгдэж гарсан хэдий ч хөтөлбөртэйгөө уялдаагүй гэж багш нар дүгнэж байна.

Түүнчлэн, өнөөдөр хос хэлээр мэргэжил эзэмшсэн багш, цаашилбал, хос хэлний багш бэлтгэх, багшийн мэргэжил дээшлүүлэх тогтолцоо алга байна (МУБИС дээр хос хэлний багшийн анги нээх төлөвлөгөө бий). Тува, казах хэлний мэргэжлийн багш нар Монгол Улсад мэргэжил дээшлүүлэх боломж бүрдээгүй бөгөөд Боловсролын хүрээлэнгийн Үндэсний цөөнх, гадаад дахь монгол хүүхдийн боловсролын судалгааны секторын хүчин чармайлтаар казах, тува хэлний мэргэжлийн багш нар монгол хэлний мэргэжлийн багш нарын хамт 5, 10, 15 дахь жилдээ ажиллаж байгаа багш нарын үндэсний сургалтад хамрагдаж байна. Боловсролын хүрээлэнгийн уг сектороос жилд нэг удаа зохион байгуулдаг казах, тува хэлний багш нарт зориулсан сургалтаас өөр сургалт, семинар, зөвлөгөөн хос хэлний болон цөөнхийн хэлний багш нарт байхгүй байна.³² Оросын Тува, Казахстан улсад мэргэжил дээшлүүлэх боломжийг судалж байгаа ч эрх бүхий байгууллагуудын хамтын ажиллагаа, гэрээ, хэлэлцээрээр баталгаажуулсан албан ёсны дэмжлэг шаардлагатай байна.³³

Хос хэлний боловсролын хэрэгжилтийг дэмжих дэд бүтцийг нөхцөл байдлыг дүгнэх юм бол сурах бичгийн хангамж, хүртээмж маш муу, багшийн мэргэжлийн бэлтгэл, ур чадварын хөгжил нь орхигдсон байдалтай байна. Тухайлбал, бага ангийн түвшний монгол хэлний сурах бичиг, багшид зориулсан аргазүйн зөвлөмж байхгүй, ахлах ангийн сурагчдын 30-35 хувь нь л сурах бичигтэй байгаа гэсэн аман тооцооноос³⁴ өөр сурах бичгийн холбогдолтой судалгаа алга. Тува сурагчид 2010-аад онд ЮНИСЕФ-ийн төслийн хүрээнд хэвлэсэн тува хэл дээрх 5 төрлийн сургалтын гарын авлагыг ашигласан хэвээр байгаа бол казах хэлний сурах бичгүүдийг сүүлийн үед шинэчилж хэвлээгүй, Казахстан улсаас албан бусаар сурах бичиг авч ашиглаж байгаа ажээ. Тува хэлний бэлтгэгдсэн мэргэжлийн багш байхгүй,³⁵

32 Ж.Зульмира, Б.Алтангул, Б.Ардак, Г.Чулуун-Эрдэнэ, Б.Бахатгул, Д.Тунгалаг (2021). Хос хэлний боловсролын өнөөгийн нөхцөл байдал. Улаанбаата

33 Мөн тэнд

34 Мөн тэнд

35 Мөн тэнд

аймгийн БСУГ-т тува хэлний арга зүйч байхгүй,³⁶ мөн Боловсролын хүрээлэнгээс жилд нэг удаа хэрэгжүүлдэг тува, казах хэлний багшийн сургалт семинараас өөр мэргэжил дээшлүүлэх хөтөлбөр алга байна.

Энэхүү судалгааны хүрээнд бид хэлний цөөнх хүүхдүүдийн эх хэлний сургалтыг дэмжих дэд бүтэц бүрэн бус, үйл ажиллагаа нь жигдрээгүй байна гэж дүгнэлээ. Энэ нь хэлний цөөнх хүүхдүүдийн боловсролын ялгаатай хэрэгцээг үнэлсний үндсэн дээр системтэйгээр дэд бүтцийг бий болгох бодлого хэрэгжээгүй, цаг үеийн буюу нэг удаагийн хангамж маягаар хандаж ирсэнтэй холбоотой.

Бодлогын хүчин зүй 6. Анги танхимаас гадуур орчинд цөөнхийн хэлийг харилцаанд ашиглах боломжийг хангах

Аливаа хэлийг эзэмшихэд тухайн хэлийг анги танхимаас гадуурх нийгмийнх харилцаа, өдөр тутмын нөхцөлд ашиглах боломж чухал байдаг. Үүнийг хэлний орчин гэж нэрлэдэг. Хэлний цөөнхөд хамааралтай хэлний орчны гурван нөхцөлийг судлаачид тодорхойлжээ. Үүнд:

- ▶ Хэлийг ашиглах чадамж: хувь хүний хэл эзэмшилттэй холбоотой энэ асуудал нь сургууль, гэр бүл, нийгмийн орчны, эсвэл эдгээрийн хавсарсан нөлөөллийн үр дүнд төлөвшдөг хэлний ур чадвар юм.
- ▶ Хэлийг ашиглах боломж: зөвхөн хичээл дээр, эсвэл гэртээ хэрэглэж байгаа хэл нь яваандаа мартагдах, дараа дараагийн үедээ өвлөгдөн үлдэхгүй байх эрсдэлтэй. Зарим улсад цөөнхийн хэлийг зарим нийгмийн үйлчилгээ, мөн мэдээлэл, хэвлэн нийтлэлийн салбарт ашиглан сурталчлах замаар тухайн хэлний нэр хүндийг өсгөх, цөөнхийн бус хүмүүс сурах сонирхлыг өдөөж, тухайн хэлний орчныг өргөжүүлэн, хэрэглэгчийн тоог өсгөх бодлого хэрэгжүүлж буй туршлага бий.
- ▶ Хэлийг ашиглах хүсэл: тодорхой хэлний талаарх тухайн хэлийг эзэмшигч, мөн бусад хүмүүсийн ойлголт хандлагаас хамааран хэлийг ашиглах хүсэл нэмэгдэх, эсвэл буурах зүй тогтол бий. Цөөнхийн хэлний талаар нийт хүн ам эерэг ойлголт хандлагатай

36 Х.Гансүх (2021). "Багшийн хөгжил" ярилцлагын дүн. Улаанбаатар

байвал хэлний цөөнх бүлгийн хүүхэд, насанд хүрэгчид эх хэлээ гэртээ болон нийгмийн орчин ашиглах, агуулга бүтээж хэвлэл мэдээлэл, хэвлэн нийтлэл, цахим сувгуудаар тараан түгээх, цөөнхийн бус хүмүүс сонирхон судлах нь нэмэгдэнэ.

Хос хэлний бодлогын судалж буй судлаач Г.Чулуун-Эрдэнэ эрдэм шинжилгээний бүтээлдээ³⁷ “казах үндэстэн газар зүйн байршлын хувьд нэг дор нягтралтайгаар төвлөрсөн нь нэг хэл, соёлын хязгаарлагдмал орчныг бий болгож байна” хэмээн дүгнээд, тухайн бүс нутагт олонх болж буй бүлгийн хэл тухайн бүсийн голлох хэл болсноор хэлний хэрэглээний хүрээ өөрчлөгддөг тухай онолыг ишлэн, тухайн бүс нутагт цөөнх бүлгүүдийн дунд олон хэл, соёлыг үл зөвшөөрөх, хэлний цөөнхийн эрх зөрчигдөх зэрэг асуудал бий болдог тухай анхааруулжээ. Судлаач нь хэлний хэрэглээний найман хүрээний долоод казах хэл зонхилж байгааг тогтоогоод, энэ байдал нь боловсролын салбарт казах хүүхдийн дараагийн шатанд сурах, мэргэжил эзэмших, нийгэмшилд сөргөөр нөлөөлөхийн зэрэгцээ тус аймагт оршин суудаг хэл, соёлын ялгаатай өөр бүлгийн (14.5%) хүүхдийн хэлний эрх давхар зөрчигдөхөд хүргэж байна гэж дүгнэжээ. Өөр нэг судалгаагаар казах гэр бүлүүдийн ахуйн хүрээнд казах болон казах, монгол хэлний холимог хэрэглээ өндөр, шашны арга хэмжээ зөвхөн казах хэл дээр явагдаж байгаа бол нийгмийн харилцаанд монгол хэл түлхүү ашиглагдаж, чөлөөт цагийн үеэр (хөгжим сонсох, кино үзэх гэх мэт) гадаад хэл ашиглах нь их байна гэж дүгнэжээ.³⁸ Баян-Өлгийн аймгаас бусад орон нутаг, хот суурин газар амьдарч буй казахууд эх хэлний асуудалд маш их санаа зовж байгаа бөгөөд казах сургууль, казах хэлний сургалтын төв байвал хүүхдүүдээ явуулах хүсэлтэй байна.³⁹

Хос хэлний боловсролыг Баян-Өлгий аймгаар хязгаарлахгүй бусад аймаг, хот суурин газарт хэрэгжүүлэх боломжийг тодорхойлж, казах, тува хэлийг таниулан сурталчлах, хүлээн зөвшөөрүүлэх, олон хэлт нийгмийн загварыг хүний хөгжлийн хүчин зүйл болгож

37 Г.Чулуун-Эрдэнэ (2021). Монгол Улс дах хос хэлний нөхцөл байдлыг нийгэм хэл шинжлэлийн үүднээс судлах нь

38 Ж.Зульмира, Б.Алтангул, Б.Ардак, Г.Чулуун-Эрдэнэ, Б.Бахатгул, Д.Тунгалаг (2021). Хос хэлний боловсролын өнөөгийн нөхцөл байда

39 Мөн тэнд

хөгжүүлэх замаар цөөнхийн хэлийг хэрэглэх боломж, хүслийг цөөнхийн бүлгийн дотор болон нийгмийн түвшинд тэлж нэмэгдүүлэх шаардлагатай байна гэж бид дүгнэж байна. Бүх шатны байгууллага, ялангуяа үйл ажиллагааны хүчин зүйлтэй холбоотой боловсролын байгууллагад оновчтой бодлого, шийдвэр, үйл ажиллагаа явуулах, хос хэлний боловсролыг тэнцвэртэй хөгжүүлэх, зохистой хөтөлбөр, сурах бичиг, багшлах боловсон хүчний арга барилыг хөгжүүлэх, сурагчдыг хос хэл сурах сэдэл тэмүүлэл болон сургалтын бус замаар дэмжих үйл ажиллагаанд анхаарах хэрэгтэй гэж судлаач Г.Чулуун-Эрдэнэ зөвлөж⁴⁰ байгаатай санал нэг байна.

Баян-Өлгий аймгийн хувьд тува хэлтэн хүүхдүүдийн хэлний эрх, казах болон тува хэлийг нийгмийн харилцаа, төлөөллийн байгууллага болон шүүхийн тодорхой үйл ажиллагаа, мэдээлэл болон хэвлэн нийтлэлийн салбарт ашиглах боломж бий болгох зэрэг асуудалд анхаарах хэрэгцээ байгаа нь анзаарагдав.

Цаатан хүүхдүүдийн эх хэлний хэрэглээг дэмжих орчны тухай судалгаа алга байна.

Монголд 2011 оноос ЮНЕСКО-ийн санхүүжилтээр MN-25 суваг казах, тува хэл, буриад аялгаар тус бүр 10 минут буюу цөөнхийн хэлээр өдөрт 30 минутын мэдээ, радиогийн 30 минутын мэдээллийн хөтөлбөр хүргэж байгаагаас өөрөөр цөөнхийн хэлийг ашиглаж байгаа мэдээллийн хэрэгсэл, төрийн үйлчилгээ, хэвлэн нийтлэл, соёлын бодлогын бүтээгдэхүүн алга байна. Нийгмийн сүлжээнд казах, тува хэлний хэрэглээ бараг байхгүй.

40 Г.Чулуун-Эрдэнэ (2021). Монгол Улс дах хос хэлний нөхцөл байдлыг нийгэм хэл шинжлэлийн үүднээс судлах нь

БҮЛЭГ 3: ХОС ХЭЛНИЙ БОЛОВСРОЛЫН ҮР ДҮН

Хэдийгээр хэлний цөөнхийн хүүхдүүдэд эх болон төрийн албан ёсны хэлийг эн тэнцүү эзэмшүүлэхэд чиглэсэн эрх зүйн орчин бүрсэн ч хос хэлний хөтөлбөрийн хэрэгжилтийг хянаж дэмжих, хөтөлбөрийн дэд бүтэц, хэлний орчныг бүрдүүлэх тал дээр нэлээд бэрхшээл тулгарч байна.

Үр дүн төдийлөн сайн биш, бүр цаашилбал хуучирч байгаа гэж хэлж болох нэмэгдэх, хасагдах загвараар боловсруулсан хос хэлний сургалтын хөтөлбөр маань хэлний цөөнхийн залуучуудыг эх хэлээ өвлөн, хөгжүүлэхийн зэрэгцээ нийгмийн амьдралд идэвхтэй оролцоход хэлний бэрхшээл үүсэхээргүй хос хэлтэн болгож чадаж байна уу?

Эх хэлний түвшнийг үнэлсэн албан ёсны мэдээ статистик байхгүй ч хэлний цөөнх сурагчдын сурлагын амжилтыг үндэсний хэмжээний харьцуулах боломж олгодог ЭЕШ-ийн дүн бий. 2019 онд Баян-Өлгий аймаг ЭЕШ-ын ерөнхий дүнгээр аймгуудаас 21 дүгээр байрт орж, өнгөрсөн оныхоос гурван байраар хойшилсон бөгөөд тус аймгийн сурагчдын дундаж оноо 478 байгаа нь улсын дунджаас 21 оноогоор доогуур үзүүлэлт юм. Аймгийн сурагчид математик, орос хэл, физикийн хичээлээр улсын дунджаас дээгүүр, харин монгол хэл, нийгэм судлал, газар зүй, биологи, хими, Монгол Улсын түүхийн хичээлээр 19-21 дүгээр байрт жагсжээ. Сурагчид монгол хэл, газар зүйн хичээлээр улсын дунджаас 78-104 оноогоор доогуур үнэлгээ авсан нь ЭЕШ-ын ерөнхий дүн буурахад нөлөөлсөн байна. Баян-Өлгий аймаг ЭЕШ-ын дүнгээр сүүлийн 20 гаруй жил улсын хэмжээнд 18-21 дүгээр байрт явж байгаа.⁴¹

Энэ байдал 2022 онд ч өөрчлөгдөөгүй бөгөөд “2022 оны элсэлтийн ерөнхий шалгалтын оноог харвал Баян-Өлгий аймгийн сурагчид бүх хичээл дээр сүүл мушгисан байна”.⁴²

41 2019 оны Монцамэ агентлагийн мэдээнд үндэслэв <https://montsame.mn/mn/read/198143>

42 2022 оны 2022-06-29-ний өдрийн мэдээнд үндэслэв. <https://mpress.mn/p/9413>

ХҮСНЭГТ 14. 2019-2020 оны Элсэлтийн ерөнхий шалгалтын дүн

Аймаг, дүүрэг, хот	Сайн хичээл										Мүү хичээл										Байгууллын нийлбэр	Ерөнхий дүн 2022 он	Ерөнхий дүн 2021 он	Өмнөх оноос өөрчлөгдсөн	
	Орос хэл		Гагар зүй		Монгол хэл		Нийгэм судлал		Түүх		Биологи		Физик		Англи хэл		Математик		Хими						
	Median	Байр	Median	Байр	Median	Байр	Median	Байр	Median	Байр	Median	Байр	Median	Байр	Median	Байр	Median	Байр	Median	Байр					
1 Дархан	87	5	59	10	55	5	53	6	53	7	44	3	30	3	32	1	25	3	25	1	44	1	6	5	
2 Өвөрхангай	72	10	66	3	56.5	2	57	1	60.5	2	42	7	30	3	27	6	25	3	23	8	45	2	1	-1	
3 Дорнод	92	2	62	9	53	11	54	4	53.5	6	44	3	30	3	28	4	24	6	24	4	52	3	2	-1	
4 Увс	76	7	41	21	53	11	48	18	41.5	16	42	7	33.5	1	29	2	27	1	24	4	88	4	8	4	
5 Орхон	95	1	64	5	52	18	49	15	44	12	41	14	28	9	27	6	23	8	25	1	89	5	15	10	
6 Сүхбаатар	91	3	64	5	55	5	51	7	30	22	40	15	26	15	27	6	24	6	23	8	92	6	12	6	
7 Банкнгор	72.5	9	64	5	54.5	8	51	7	32	21	42	7	26	15	25	12	23	8	24	4	96	7	5	-2	
8 Баянхүүр	37	23	63.5	8	52	18	51	7	37.5	18	47	1	31	2	27	6	26	2	22	13	98	8	4	-4	
9 Сэлэнгэ	63	16	73	1	53	11	51	7	53	7	40	15	26	15	26.5	10	23	8	22	13	103	9	16	7	
10 Говьсүмбэр	86	6	46	19	53.5	10	55	2	43.5	14	46	2	21	23	26	11	22	18	25	1	106	10	3	-7	
11 Хэнтий	70	12	68	2	56	3	55	5	55.5	5	38	19	27	12	24	16	22	18	21	18	107	11	10	-1	
12 Говь-Алтай	56	18	55	13	55	5	51	7	65.5	1	38	19	26	15	24	16	23	8	22	13	115	12	22	10	
13 Ховд	54	19	47	18	53	11	50	12	57.5	4	40	15	27	12	28	4	23	8	22	13	116	13	17	4	
14 Дорноговь	47	20	41	21	58	1	54	4	37.5	18	42.5	6	28	9	25	12	22	18	23	8	117	14	7	-7	
15 Завхан	59	17	66	3	51	20	47	20	45	10	40	15	29	6	24	16	23	8	24	4	119	15	21	6	
16 Төв	64.5	14	54.5	14	53	11	50	12	43	15	41	11	27	12	25	12	23	8	22	13	122	17	13	-4	
17 Хөвсгөл	70.5	11	58	11	53	11	48	18	44	12	41	11	29	6	24	16	23	8	21	18	122	17	9	-8	
18 Дундговь	39	22	52.5	15	56	3	49	15	58	3	37	22	29	6	24	16	25	3	20	22	127	18	11	-7	
19 Өмнөговь	75	8	56	12	53	11	47	20	45	10	44	3	23	22	24	16	21	21	23	8	131	19	14	-5	
20 Улаанбаатар	90	4	42	20	49	22	49	15	37	20	38	19	26	15	29	2	23	8	23	8	133	20	20	0	
21 Архангай	41.5	21	49	17	54	9	50	12	38	17	41	11	28	9	24	16	23	8	21	18	138	21	18	-3	
22 Булган	64	15	51	16	51	20	47	20	51	9	42	7	26	15	23	23	21	21	21	18	164	22	20	-2	
23 Баян-Өлгий	65	13	24.5	23	33	23	41.5	23	29	23	31	23	24	21	25	12	21	21	20	22	204	23	23	0	
Median дундаж		68.1		55.1		52.7		50.4		45.8		40.9		27.4		26.0		23.3		22.6					
Шалгуулсанхүүдийн тоо		920		10776		19473		1932		6531		8258		20365		11811		6532		Ашигryn бүс, үнс төрийн бүс зорилгор элдэс тамга дарахгүйгээр ашиглан болно.					
Богоо 400 оноо		43	85%	26	84%	38	83%	34	85%	24	83%	26	84%	18	82%	18	85%	15	84%	16	83%				
Богоо 480 оноо		55	74%	41	58%	49	58%	47	57%	31	59%	36	59%	25	54%	26	57%	22	56%	21	59%				

Баян-Өлгийн залуучууд Улаанбаатарт оюутан болж ирээд эхний жилдээ хэлний бэрхшээл гардаг тухай нийтлэгээр ярьдаг. Улмаар хоёр хэлийг амжилттай эзэмшүүлэхийн зэрэгцээ хоёр хэл дээр ерөнхий боловсролын агуулгыг амжилттай эзэмшүүлэх бодлогын зорилтыг хэрхэн амжилттай хэрэгжүүлэх асуудлыг ул суурьтай судалж, шаардлагатай бодлого, хөтөлбөрийн болон арга зүйн өөрчлөлтийг хийх хэрэгтэй байна.

БҮЛЭГ 4: ХОС ХЭЛНИЙ СУРГАЛТЫН АРГА ЗҮЙГ ШИНЭЧЛЭН САЙЖРУУЛАХ САНААЧИЛГА

Хос хэлний хөтөлбөрөөр хичээллэхэд сурагчдын ачаалал нэмэгдэн, сурах сонирхол буурах явдал гаргахгүй байх үүднээс Баян-Өлгий аймгийн хэмжээнд хөтөлбөрийн цагийн хуваарилалтад зохицуулалт хийж, монгол хэлний цагийг монгол, казах хэлний хоёр хичээлд хуваан, сурагчдын ачааллыг тэнцвэржүүлэх арга хэмжээ хэрэгжүүлж ирсэн. Энэ бол хэлийг бие даасан систем гэж харж, бие даасан хичээлээр зааж эзэмшүүлэх хандлагаар хос хэлний хасагдах, нэмэгдэх арга зүйгээр боловсруулсан хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тулгардаг хамгийн нийтлэг бэрхшээл байдаг. Хос хэлний нэмэгдэх арга зүйд суурилсан монгол, казах хос хэлний хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ цагийн зохицуулалт хийснээр сурагчдын монгол, казах хэл үзэж судлах, багштай идэвхтэй харилцах цаг (контакт цаг гэж нэрлэдэг) буурчээ.

Тувачууд монгол угсаа ижилслээ хадгалах сонирхлын улмаас тува хэлнээс монгол хэл рүү эрт шилжих чиглэлтэй хасагдах арга зүйд түшиглэсэн хос хэлний боловсролыг дэмждэг. Гэтэл эрт шилжилтийн арга зүй нь эх хэлний бичгийн хэлний ур чадварыг хөгжүүлж амжихгүй тул тува хүүхэд, залуучууд эх хэлээ зөвхөн ярианы хэлний түвшинд гэр бүлийн орчинд ашиглах хэмжээнд эзэмшиж байгаа нь яваандаа эх хэлээ мартагдах, өөрийн үр хүүхдэдээ зааж сурахгүй орхих эрсдэл бий болгох магадлалтай.

Хос хэлний хөтөлбөр хэрэгжүүлэхдээ хоёр хэлийг бие даасан хоёр хичээлээр бус, харин нэг хичээл дээр интеграцчилж ашиглах хоёр хэлний зэрэгцээ болон холимог хэрэглээнд суурилсан сургалтын арга зүй олон улс оронд амжилттай ашиглагдаж байна. Эдгээрийн нэг нь судлагдахуун, хэлийг интеграцчилсан сурахуй (СХИС буюу англиар content and language integrated learning) гэж нэрлэж буй арга зүй бөгөөд үүнийг Боловсролын Хүрээлэн судлан хөгжүүлж, Баян-Өлгий аймгийн сургуулиудад туршиж байна. СХИС нь зорилтот хэлийг тусад нь хичээл болгож судлахгүй, харин шинэ судлагдахууныг заахдаа эх хэл дээр түшиглэн зорилтот хэлийг өсөн

нэмэгдэх хувь хэмжээгээр ашиглах замаар агуулга болох зорилтот хэлний үгийн сан, хэрэглээг бий болгодог арга зүй юм. Өөрөөр хэлбэл, зорилтот хэл нь судлагдахууны агуулгыг эзэмших үйлийн нэг бүрэлдэхүүн хэсэг болох ба судлагдахууны агуулга нь хэл сурах нөхцөл болно. СХИС нь үндэсний сургалтын хөтөлбөрийн зорилго, зорилт, агуулгыг хөндөхгүй, зөвхөн түүнийг хэрэгжүүлэхэд хэлний цөөнхийн хүүхдүүдийн эх хэл болон эзэмшихийг зорьж буй төрийн албан ёсны хэлийг нэгж хичээл дээр харилцааны хэрэгсэл болгож ашигладаг тул цөөнхийн сурагчдад агуулга, зорилтот хэлийг нэгэн зэрэг эзэмшихэд дэмжлэг болдог байна. Энэ аргыг Европын Холбооны улсууд, мөн Төв Азийн зарим улс СХИС, даалгаварт суурилсан хэлний сурахуй (Task-based Language Learning), агуулгад суурилсан сургалт (Content-based Instructions), агуулгад суурилсан сургахуй (Content-based Teaching) зэрэг нэрээр амжилттай хэрэглэж байна.⁴³

СХИС нь арга зүйн хувьд 1950-1960-аад онд Канад, АНУ, Их Британид ашиглаж байсан хоёрдогч хэлийг богино хугацаанд эзэмшүүлэх алдарт “вакуумжуулах” арга зүйгээс үүсэлтэй ажээ. Англиар immersion буюу “булхуулах”, “умбуулах” гэж нэрлэгддэг энэ арга зүй нь сурахаар зорьж буй хэл дээрээ мэргэжлийн агуулгад суралцах, ингэхдээ зорилтот хэлээр ярьдаг ч суралцагчийн эх хэлийг сайн мэдэхгүй багшаар заалгах замаар сурагчдыг зорилтот хэлээр харилцахад түлхэх сэдэлтэй арга зүй юм. Монголд монгол хэл сайн мэдэхгүй гадаад багштай гадаад хэлний “вакуумжуулсан” сургалт байдагтай төстэй тул уг нэр томъёог ашиглав.

Уг арга зүй нь зорилтот хэл дээр агуулга, мэдээлэл, харилцааны орчныг бий болгох замаар тухайн хичээлийн туршид зорилтот хэлийг ашиглахаар бүрдүүлсэн орчин дээр түшиглэдэг. Багш, сурагчид зорилтот хэл дээр судлагдахууны тухай ярилцахдаа харилцаагаа залах, өөрийгөө бүрэн дүүрэн ойлгуулахад эх хэлээ ашиглах боломжтой байна. Ийнхүү хичээл дээр зорилтот хэл ашиглах нь судлагдахуун, жишээлбэл, математик, газар зүй, нийгмийн ухааны агуулга эзэмшилтэд сөрөг нөлөөгүй, цаашилбал, хүүхдүүдийн сонирхол, танин мэдэхүйг өдөөж дэмжих нөлөөтэй ажээ. ЕБС-д хэлний

43 Huraajovb A.(2015).Content and language integrated learning as a bilingual educational approach in the European context. <https://www.researchgate.net/publication/298810070>

цөөнх сурагчдад төрийн албан ёсны хэл (Х2)-ийг судлагдахуунтай интеграцчилсан арга зүйгээр заах нь бие даасан хичээлээр заахтай ижил, ихэнхдээ илүү үр дүнтэй гэсэн судалгааны дүгнэлтүүд нэлээд бий.⁴⁴

Боловсролын хүрээлэн нь дээрх орнуудын туршлага, арга зүйг судлан, тодорхой хичээлүүдийг СХИС-ын аргазүйгээр заах арга зүйн боловсруулалт хийж, Баян-Өлгий аймгийн хоёр сургууль дээр туршин, үр дүнг нэгтгэх ажлыг гүйцэтгэж байна. Уг туршилтын загварт эхэндээ нэг хэлний мэдлэг нь нөгөө хэлээ сурах, судлагдахууны агуулгыг эзэмшихэд дэмжлэг болж байсан бол дараагийн үедээ хоёр хэлийг тухай хичээл дээр зэрэг хэрэглэх арга зүй руу шилжиж байгаа бөгөөд аль ч тохиолдолд хоёр хэлийг нэг хичээл дээр тодорхой хувь хэмжээгээр зэрэгцүүлэн ашиглаж байгаа болно. Энэ загварын дүрслэлийг Хүснэгт 17-д тодорхой харууллаа.

ХҮСНЭГТ 15. Цөөнхийн эх хэл (Х1) ба монгол хэл (Х2)-ний хуваарилалтын харьцааг анги, судлагдахуун, хувиар харуулсан жишиг загвар

№	Судлагдахуун	эхлэх анги: 4				эхлэх анги: 5				эхлэх анги: 6				эхлэх анги: 6			
		эхэнд		дараа		эхэнд		дараа		эхэнд		дараа		эхэнд		дараа	
		X1	X2	X1	X2	X1	X2	X1	X2	X1	X2	X1	X2	X1	X2	X1	X2
1	Математик	90	10	85	15	90	10	85	15	75	25	65	35	70	30	60	40
2	Хүн ба байгаль	90	10	85	15	90	10	80	20								
3	Зураг/технологи	85	15	75	25	80	20	70	30	75	25	70	30	70	30	60	40
4	Газар зүй													75	25	65	35
5	Биологи									80	20	70	30	75	25	65	35
6	Нийгэм судлал													80	20	70	30
7	Биеийн тамир	80	20	70	30	80	20	70	30	60	40	50	50	50	50	40	60

1-3 дугаар ангид сургалт эх хэл дээр явагдаж, 4 дүгээр ангиас эхлэн хоёр хэлийг нэгж хичээл дээр зэрэг ашиглах энэхүү жишиг загварыг Боловсролын хүрээлэнгийн ҮЦГМХБСС-ын эрдэм шинжилгээний

44 Жишээлбэл, Badertscher and Bieri (2009) нар, Dalton-Puffer.C (2011) Content-and-Language Integrated Learning: From Practice to Principles өгүүлэлд ишилснээр, Annual Review of Applied Linguistics сэтгүүл, Cambridge University Press, 2011

ажилтнууд Баян-Өлгий аймгийн багш, БСУГ-ын мэргэжилтэн нарын саналд үндэслэн боловсруулжээ.

Бодит амьдрал дээр хос хэлт нийгэмд хоёр хэл бие биеэсээ бүрмөсөн тусгаарлагдсан байдаггүй, урьдчилан төлөвлөсөн тодорхой нөхцөлд, жишээлбэл, арга хэмжээ, албан уулзалтын үеэр нэг хэл дангаар хэрэглэгдэхээс бусад өдөр тутмын харилцаанд дийлэнхдээ хоёр хэлийг зэрэгцүүлэн (үүнийг хоёр хэлний хооронд шилжих гэж нэрлэдэг) ашигладаг. Улмаар СХИС арга зүй нь хос хэлний сургалтын танхимд бодит амьдралд ойрхон хос хэлний орчныг бий болгох зорилготой. Эх хэл Х1 болон төрийн албан ёсны хэл Х2-ний нэгж хичээл дээр ашиглагдах хэмжээ нь 4 дүгээр ангийн математикийн хичээл дээр хичээлийн жилийн эхэнд 90:10 хувийн харьцаатай эхэлж, хичээлийн жилийн эцэст 85:15 хувийн харьцаатай болж, анги ахихын хэрээр харьцаа нь өөрчлөгдөн 12 дугаар ангид 60:40 хувийн харьцаатай болж байна. Биеийн тамирын хичээл нь 80:20 хувийн харьцаатай эхэлж, 70:30 хувийн харьцаатай тухайн хичээлийн жилийг өндөрлөх бөгөөд 12 дугаар ангийн түвшинд 50:50 хувийн харьцаатай эхэлж, 40:60 хувийн харьцаатай төгсгөж байна. Энэ нь хатуу тогтоосон хэмжээ биш бөгөөд хичээл бүр дээр хоёр хэлний сургалтад ашиглагдах харьцаа +/- 5-10 хувиар хэлбэлзэх боломжтой гэж туршилтын баг үзэж байна.

Ийнхүү Боловсролын хүрээлэнгээс хос хэлний боловсролын арга зүйг орчин үеийн онол, хандлагад нийцүүлэн шинэчлэх суурь өөрчлөлтийг дэмжсэн судалгаа, туршилтын ажил эхлүүлээд байгаа ажээ. Уг арга зүйг дэлхийн олон улс оронд хос хэлний боловсролд өргөнөөр ашиглан, багагүй туршлага бий болгожээ. Энэхүү аргазүйн давуу тал нь сурагчдын хэлний чадвар сайжрахын зэрэгцээ соёл хоорондын харилцаа, олон соёлын мэдлэг нэмэгддэг бөгөөд судлагдахууны агуулга эзэмшилтэд сөргөөр нөлөөлдөггүй байна. Харин боловсролын төлөвлөлт түвшинд, ялангуяа багшид арга зүйг эзэмшүүлэх, аймгийн БСУГ-ыг түшиглэн арга зүйн дэмжлэгийн тогтолцоог бүрдүүлэх, мөн эцэг эх, олон нийтэд ойлгуулж дэмжлэг

олох тал дээр нэлээд ажиллах шаардлагатай болох юм.⁴⁵ Хоёр хэлийг сургалтад зэрэгцээ болон холимог байдлаар ашиглах арга зүйг сургалтад нэвтрүүлэхийн тулд хос хэлтэй багш бэлтгэх ажлыг яаралтай эхлүүлэх шаардлагатай бөгөөд харин сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн нь нэг хэл дээр байх боломжтой.

45 Mourssi, Anwar., & Mohammed Abdullah Sulaiman Al Kharosi (2014). The benefits and challenges of implementing content and language integrated learning at Higher College of Technology of Oman. International Journal of Language Learning and Applied Linguistics, Volume 7 (4)

БҮЛЭГ 5. САНАЛ БУЮУ ХОС ХЭЛНИЙ ДЭВШИЛТЭТ АРГА ЗҮЙД СУУРИЛСАН ХОС ХЭЛНИЙ БОЛОВСРОЛЫН ХӨТӨЛБӨРИЙН ЗАГВАРЧЛАЛ

Хос хэлний боловсролын асуудлыг гадаад улсуудын сайн туршлага, өөрийн орны эрх зүйн болон бодлогын орчин, түүний хэрэгжилт, үр дүн зэргийг тандан судалсны эцэст хос хэл бол хүний хөгжлийг дэмжих, нийгмийн бүлгүүдийн харилцан ойлголцол, харилцан хүндлэлийн бий болгох, олон соёлт нийгмийн бахархал болгож хөгжүүлэх нөөц, нийгмийн капитал гэж ойлгож хандан, хөгжүүлэх ёстой гэж үзэж байна. Энэ үүднээс дараах саналыг дэвшүүлж байна.

Даяаршлын энэ эрин үед хос буюу олон хэл бол нийгмийн олон талт байдлын илэрхийлэл бөгөөд хос хэлний боловсролын асуудлыг нийтлэг боловсролын үйлчилгээний эрх зүйн орчин, уг үйлчилгээг хүргэх нэгдмэл тогтолцооны хүрээнд нь авч үзэх шаардлагатай. Даяаршиж буй дэлхийн бүх л улс орны нэгэн адилаар, Монгол Улсын хөгжил (Үйлийн орчин), бусад улс оронтой тогтоосон харилцаа хамаарал (харилцан нөхцөлдөхүй гэх) нь харилцаа, түүнийг төлөөлөх Хэлээр дамжигдан үйлдэгдэнэ.⁴⁶ Улс орнуудын (үүнд дотор Монголын) хөгжил, хамтын оршихуйг нөхцөлдүүлэн дамжуулагч хэрэгсэл нь хэл бөгөөд заавал нэг хэл байх хэрэгцээ шаардлага нь колончлолын түүхээр төгсгөл болсон. Хэл бол харилцаа, харилцан ойлголцол, хамтран оршихуйг дамжуулагч хэрэгсэл бөгөөд Монгол Улсын хэмжээнд бид монгол хэлийг төрийн албан ёсны хэлээр сонгон тунхаглаж, нийтийн харилцаандаа ашиглахаар сонгосон. Үүний зэрэгцээ иргэд өөр бусад хэлийг сурах, харилцаандаа ашиглах эрхтэй бөгөөд ялангуяа хэлний цөөнх бол эх хэлээ сурах, судлах, эх хэлээрээ харилцах нь бахархалтай зүйл юм.

Хүн бүр олон төрлийн ижилсэл тээж явдаг. Улмаар төрийн албан ёсны монгол хэлээр яригч Монгол Улсын иргэн гэсэн ижилслийн зэрэгцээ нас, хүйс, нутгийн аялга, сонирхол, хэлний ялгаа зэрэг нь бүгдээрээ нэг хүний мэдэрдэг янз бүрийн ижилсэл юм. Цөөнх иргэд

эх хэлээ сурч, эх хэл, соёлоо хөгжүүлснээр монгол ижилсэл дээрээ нэмж давхар хэл, соёлын ижилсэн бий болгож байгаа бөгөөд энэ нь монгол ижилслээсээ татгалзах, үгүйсгэж буй хэрэг биш юм.

Монгол Улсын хөгжлийг дамжуулах, дэмжих арга хэрэгсэл бол буй монгол хэл, цөөнхийн хэлний харилцан хамаарал, хамтран оршихуйг 4 хувилбараар загварчлан харах боломжтой. Арга, практик талаасаа ахуйн болон соёл, гэр бүлийн орчинд ашиглагдах хэлнүүдийн нэгсэл, мөн бодлого, хандлагын түвшинд төлөвшүүлэх хэлнүүдийн 2 хувилбарт нэгсэл гэсэн загвараар цөөнхийн эх болон албан ёсны хэл, аль нэг нь заавал давамгайлах болон хамтран орших үзэл баримтлалыг авч үзэх юм бол дөрвөн талбар үүснэ (Зураг 6).

ХҮСНЭГТ 16. Хоёр хэлний харилцан хамаарал, хамтран оршихуйн 4 хувилбар

Хасагдах загварын хэлний бодлого (X1+X2-X1=X2)	Хасагдах загварын хэлний бодлого (X1+X2 =X1+X2)
Арга зүй: Цөөнхийн эх хэлийг зөвхөн бичиг үсэн тайлагдахад түшиц болгож ашиглах бөгөөд ахуйн болон нийгмийн харилцааг монгол хэлээр явуулж ижилсэл бий болгох	Арга зүй: Цөөнхийн эх хэлийг ахуйн, гэр бүлийн болон соёлын орчин хөгжүүлэн дэмжиж, сургуульд нэг хичээлээр судлуулах замаар цөөнхийн соёл, хэлний эрхийг хүндэтгэх, нийгмийн харилцааг монгол хэлээр явуулах
Арга зүй: хэвшсэн буруу ойлголт / алдаатай дихотом Үр дагавар, үр нөлөө: Орчин үеийн нийгэмд хэл бол харилцааны хэрэгсэл бөгөөд эх болон албан хэлний аль нэгийг сонгох хэрэгцээ байхгүй. Төрийн албан ёсны хэлээр дамжуулан үндэсний ижилсэл, цөөнхийн эх хэлээр дамжуулан бүлгийн ижилсэл бий болж байна. Албан ёсны болон цөөнхийн хэл нь нэг нэгэндээ саад болохгүй харин ч баяжуулалт болно.	Үнэлгээ: Онолыг алдаа. Хэл бол бие даасан, автономит систем бөгөөд хоёр хэл огтлолцохгүй, тус тусдаа шугаман хамтран оршихуйтай гэж үзэх нь хэлний харилцааг дамжуулагч, харилцан нөлөөлөгч мөн чанарыг үгүйсгэнэ. Үр дагавар, үр нөлөө: Цөөнхийн хэл хязгаарлагдмал хэрэглээ, ач холбогдолтой байх тул яваандаа мартагдах эрсдэлтэй

Рекурсив (X1 X2)	Динамик (X1, X2, X3...)
Арга зүй: Нэг хичээлийн цагийг тэнцвэртэйгээр хоёр хэлд хуваарилах, эсвэл нэг хөтөлбөрийн хүрээнд хичээлүүдийг хоёр өөр хэлд тэнцвэртэйгээр хуваарилах арга зүйгээр дамжуулан олон хэлт нийгмийн загварыг анги танхимд бий болгох Үнэлгээ: хэрэгжүүлэхэд хос хэлтэй багш шаардлагатай бөгөөд Монголд хос хэлний багш бэлдэж эхлээгүй байгаа тул хэрэгжүүлэхэд цаг орно. Үр дагавар, үр нөлөө: Хоёр хэлийг зэрэг ашиглах нь нэг хэл дээр бичиг үсэг тайлагдаж, нөгөө хэлээ судалж эхэлж байгаа хүүхдэд харилцааны илүү органик орчин бий болгож, сурах үйл явцад нь дэмжлэг болно. Яваандаа хоёр хэлний суурь бий болсны дараа хоёр хэл дээр дагнан явах хичээлүүдийг тэнцвэртэй тогтоож өгч болно.	Арга зүй: Албан боловсролын эхний жилүүдэд нэг хичээл, нэг хөтөлбөрийн хүрээнд хоёр хэлийг зэрэг хэрэглэх, хэл хооронд шилжиж харилцахыг зөвшөөрөх Үнэлгээ: Хэл хооронд шилжсэн харилцааг анги танхимд дэмжихийн тулд хос хэлтэй багш, арга зүй шаардлагатай. Мөн “хэл хольж ярих”-ыг сөргөөр хүлээн авдаг, энэ нь монгол хэлний хөгжил, монгол хэлийг төгс эзэмшихэд саад болно гэсэн ойлголтыг даван туулж хүлээн зөвшөөрүүлэх хэрэгтэй болно. Үр дагавар, үр нөлөө: Хоёр хэлийг зэрэг ашиглах нь нэг хэл дээр бичиг үсэг тайлагдаж, нөгөө хэлээ судалж эхэлж байгаа хүүхдэд харилцааны илүү органик орчин бий болгож, сурах үйл явцад нь дэмжлэг болно. Яваандаа хоёр хэлний суурь бий болсны дараа хоёр хэл дээр дагнан явах хичээлүүдийг тэнцвэртэй тогтоож өгч болно.

Дээрх хүснэгтэд нэмж онцлон тайлбарлах шаардлагатай нэг асуудал бол өмнөх онолын хэсэгт дурдсан моногlossик болон гетерогlossик үзэл юм. Монголын нийгэм нэг хэлээр ярьдаг нийгэм байх уу, эсвэл олон хэлийг хүлээн зөвшөөрсөн нийгэм байх уу гэдэг бидний хандлагатай холбоотой энэ асуудал нь үндэсний ижилсэлтэй холбоогүй асуудал юм. Монгол Улсын иргэн гэсэн ижилсэл, монгол хэлээр албан харилцаа, төрийн үйл хэргийг явуулж буй хэлний ижилсэл нь төрөлх хэлээ эзэмшин, гадаад хэл сурснаар арилахгүй, сулрахгүй. Боловсролын орчинд хоёр хэлний хосолмол (рекурсив) болон холимог (динамик) хэрэглээ нь гэр бүлийн орчинд байдаг холимог хэлний хэрэглээтэй төстэй тул танил орчинд албан ёсны сургалтын үйл явц, арга зүй, арга барилд суралцах боломжийг олгодог тул хүүхдийн сурахуйг дэмжсэн эерэг хандлага гэж үздэг. Өөрөөр хэлбэл, эх хэлээрээ унших, бичих, ярих төгс ур чадвар эзэмшсэний

дараа монгол хэл рүү шилжиж төгс эзэмших хандлага нь хос хэлтэн болж төлөвшиж байгаа хүүхдэд нэмэлт ачаалал болох магадлалтай. Тиймээс эх хэлээ эзэмшиж байх явцад нь монгол хэлний үгийн баялаг бүрдүүлэх тусдаа хичээл байхын оронд эх хэл дээрээ бичиг үсэгт суралцаж байх явцад нь монгол хэлний үгийн баялгийг бий болгох рекурсив (хосолмол), эсвэл динамик (холимог) хэрэглээ байвал сурагчдад хялбар байхаас гадна хэлний зүй тогтлын талаарх мета түвшний ойлголтыг эзэмшүүлж, дараа нь гадаад хэл сурахад нь хэрэг болох ур чадвар болж төлөвших юм.

Олон хэлний талаарх хэл шинжлэлийн онолын салбарт гарч байгаа дээрх өөрчлөлтийн зэрэгцээ сургууль, анги танхимын орчинд хос хэлний хэрэглээг баримтжуулсан хэрэглээний судалгаануудад шинэ ажиглалт, дүгнэлтүүд гарч байна. 2010-аад оноос хос хэлтэй сургуулиудад багш, сурагчид өдөр тутмын амьдралдаа хоёр хэлний холимог хэрэглээг хэвшүүлсэн байдаг бөгөөд практик дээр хос хэлтэй хүүхдүүд сурдаг сургууль, хос хэлтэй орон нутагт моноглоссик буюу нэг хэлээр дагнан харилцах онол хэрэгждэггүй, зөвхөн нэш хэлтэй орчинд моноглоссик харилцаа бий болдог байна. Нэгэнт хос хэлт орчинтой сургуулиуд дээр багш, сурагчид гетероглоссик хэлний орчин (хосолмол болон холимог) үүсгээд байгаа нөхцөлд хичээл дээр моноглоссик онол авч хэрэгжүүлэх нь хиймэл, зөвхөн агуулгыг эзэмшээд хэрэглээ болгож чадахгүй нөхцөл үүсэх эрсдэлтэй.

Хоёр хэлний хосолсон болон холимог хэрэглээг сургалтын хэл болгож нэвтрүүлэхэд мэдээж олон асуудал гарах бөгөөд эдгээр нь хэлний хэрэглээнээс бус шинэ онол, шинэ хандлагаар ажиллахад шаардлагатай салбарын мэдлэг, чадавхаа хөгжүүлэх, дэд бүтцээ нийцтэй хөгжүүлэх, нийгмийн сэтгэл зүйг бэлтгэж зөвшилцөл бий болгох зэрэг шинэчлэлийн хүрээний асуудлууд давамгайл байх бол уу. Тогтолцоо талаасаа шийдэх шаардлагатай асуудал нь арга зүйг боловсруулах, багш нар эзэмшүүлэхээс гадна нэг том асуудал нь шалгалтын хэлний асуудал байх болно. Хэрэв хос хэлтэй сургууль хими, тооны хичээлийг хосолсон болон холимог хэлний загвараар хэрэгжүүлсэн бол тухайн судлагдахууны мэдлэг бус нэр томъёог монгол хэл дээр сайн мэдэхгүй байх нь сурагчдын оноонд нөлөөлөхгүй байх зохицуулалт зайлшгүй шаардлагатай. Энэ асуудлыг шийдэж

байгаа олон улсын туршлагаас харахад, ЭЕШ-ийн шалгалтад багтах хичээлийг холимог хэлний загвараар хэрэгжүүлэхгүй, зөвхөн дагнасан эсвэл хосолсон хэлний загвараар анхнаасаа төлөвлөж сургалтын хөтөлбөрт тусгах, эсвэл ЭЕШ-ийн шалгалт хэлний сонголттой болох гэсэн арай сул хувилбар байж болох юм. ЭЕШ-ийн шалгалт хэлний сонголттой байх юм бол дээд боловсролд элсэн орсон хойноо хэлний бэлтгэл хийх сонголтыг цөөнхийн залуучуудад олгох хувилбар нэмэгдэж болох юм.

Энэ судалгааны дүгнэлт болгож хос хэлний боловсролын бодлого, хөтөлбөрийн арга зүйн талаар гурван хувилбарыг дэвшүүлж байна. Үүнд:

	Одоогийн бодлого	Хувилбар 1	Хувилбар 2	Хувилбар 3
Үзэл хандлага	Моногlossик	Моногlossик	Гетерогlossик	Гетерогlossик
Загвар	Хасагдах (тува), нэмэгдэх (казах)	Нэмэгдэх	Рекурсив	Динамик
Арга зүй	Эрт үеийн шилжилт (тува), нэмэгдэн бие даасан хичээлээр судлах (казах)	Тодорхой хичээлүүд дээр дагнан ашиглах хэлийг сонгож, зааглах	Бага ангид нэг хичээл дээр хоёр хэлийг хугацаа зааж тэнцвэртэй ашиглах, анги ахихаар Хувилбар 1 рүү шилжих	Бага ангид нэг хичээл дээр хоёр хэлийг холимог ашиглах, анги ахихаар Хувилбар 1, эсвэл 2 лүү шилжих
Эрх зүйн орчин	БШУЯ-аас батлах ёстой ч аймагт боловсруулан баталж байгаа	Хөтөлбөрийн түвшний зохицуулалт хэрэгтэй	Судалж туршиж, үр дүнг шаардлагатай	Судалж туршиж, үр дүнг шаардлагатай
Боловсролын дэд бүтэц	Хос хэлний багш, хэлний орчин хангалтгүй	Хос хэлтэй багш, хэлний орчин шаардлагатай	Хос хэлтэй багш, хэлний орчин шаардлагатай	Хос хэлтэй багш, хэлний орчин шаардлагатай

Хувилбар 1 ба 2-ыг хэрэгжүүлэх бол нэгж хичээлийн цаг, хичээлүүдийн ачааллыг дундаас дээд ангиудад хоёр хэл тэнцвэртэй буюу 50, 50 хувиар сургалтад ашиглагдаж байх гарцад чиглэсэн

боловсруулалт хийх хэрэгтэй гэж үзэж байна. Хүснэгт 13-д ерөнхий зураглалыг харууллаа.

ХҮСНЭГТ 17. Хос хэлний сургалтын төлөвлөгөөнд хоёр хэлний тэнцвэртэй хэрэглээг хангах цагийн хуваарилалт

Анги	Цөөнхийн эх хэл /X1	Монгол хэл / X2
СӨБ	Сургалтын хэл	
1 дүгээр анги	Сургалтын хэл	
2-3 дугаар анги	Дийлэнх хичээлүүд/ нэг хичээлийн дийлэнх цаг	Зарим хичээл/ нэг хичээлийн зарим хэсэг
4-12 дугаар анги	Нийт хичээлийн 50%	Нийт хичээлийн 50%

Хос хэлний боловсролын бодлогын бүрдүүлбэр болох хос хэлний боловсролын бодлогын бүтцийн эко тогтолцооны цөм нь сургуулийн удирдлага, багш нар юм. Хөгжлийг дэмжигч нь сонирхлын бүлгүүд бөгөөд тэднийг оролцуулснаар хос хэлний боловсролын бодлогын үндэслэл, зарчмууд ойлгомжтой болж, стратеги, стандарт, хэрэгжилтийн болон үр дүнгийн үнэлгээ, мониторингийн хэрэгжилтэд оролцох нийтлэг ойлголт хандлага бий болохоос гадна хөндлөнгийн хяналтыг тавих хараат бус сонирхлын бүлгүүдийн дэмжлэг бий болох юм.

ЗУРАГ 7. Хос хэлний боловсролын бодлогын орчил, оролцогчдын харилцааны зураглал

Төр	Яам, төрийн байгууллага, сургууль	Эцэг эх, сурагч, иргэний нийгмийн байгууллага, олон нийт
Хос хэлний боловсролын талаар төрөөс баримтлах бодлого гаргах	Хос хэлний боловсролын агуулга, стандарт, сургалтын арга зүй, үнэлгээний тогтолцоог бэхжүүлэх	Бодлого, түүний хэрэгжилттэй холбоотой санал, шүүмж гаргаж идэвхтэй оролцох
Хос хэлний боловсролыг хэрэгжүүлэх эрх зүйн орчин, дэд бүтэц хөгжүүлэх	Хос хэлний боловсролыг хэрэгжүүлэх хүний нөөц, мэргэжлийн чадавх, арга зүйг хөгжүүлэх	Хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт мониторинг хийх

Хос хэлний боловсролыг санхүүжилт, нийгмийн дэмжлэгээр хангах	Ойлгомжтой, бодитой, хүрэх боломжтой зорилго, зорилтыг дэвшүүлж бодлогын хэрэгжилтийн явцыг хянах, тайлагнах	Олон нийтэд ойлгуулах, таниулан сурталчлах
Бодлогын хэрэгжилтийг хянах	Салбар доторх болон салбар дамнасан хамтын ажиллагааг хөгжүүлэх, олон нийтэд ойлгуулах, таниулан сурталчлах	Хөндлөнгийн хяналт тавих,

БҮЛЭГ 6. ДҮГНЭЛТ БУЮУ ХОС ХЭЛНИЙ БОЛОВСРОЛЫН ТУЛГАМДСАН АСУУДЛУУДЫН ТОЙМ

Тайланд дурдагдсан хос хэлний боловсролын бодлого, түүний хэрэгжилтийн нөхцөл байдлыг энэ бүлэгт дүгнэн тоймлохыг хичээлээ.

Хос хэл, хос хэлний боловсролын бодлогын орчинтой холбоотой анхаарах асуудал

Монгол Улс нь үндэстний цөөнхийн хэл, соёлын ялгааг хүндэтгэх, өөр хэлтэй гэсэн үндэслэлээр ялгаварлан гадуурхахыг хориглосон эрх зүй орчинтой ардчилсан улс юм. Монгол Улс нь Үндсэн хуульдаа үндэстний цөөнх иргэдийн эрх тэгш байдлыг баталгаажуулан, Хэлний тухай, Соёлын тухай болон Боловсролын тухай хуулиуддаа цөөнхийн эх болон төрийн албан ёсны хэлээр сурч боловсрох, эх хэл, соёлоо өвлөн хөгжүүлэх эрхийг хангах зорилтын хүрээнд хос хэлний боловсролын эрхзүйн орчныг бий болгон хэрэгжүүлж байна.

Төрийн бодлогын түвшинд анхаарах хоёр асуудал байгаа нь зарчмын бус шинжтэй бөгөөд нэг нь салбарын эрх зүйн баримт бичгүүдэд нэр томьёоны тууштай хэрэглээг хангах, нөгөө нь нийгмийн хандлагыг асуудал байна. Эдгээр нь дараах болно:

1. Хуулиудад эх хэл, төрөлх хэл гэсэн нэр томьёог ялгалгүй ашиглаж байна.

Боловсролын тухай, Соёлын тухай, Хэлний тухай зэрэг хуульд эх хэл, төрөлх хэл гэсэн нэр томьёог ялгалгүй, заримдаа монгол хэлийг заасан утгаар ашигласан байна. Хууль эрх зүйн баримт бичгийн түвшинд эх болон цөөнхийн хэл, төрийн албан ёсны хэлний ойлголт зааглагдаагүй, цаашилбал боловсролоос бусад салбарт олонх, цөөнхийн хэл, соёлын ойлголт сайн тодорхойлогдоогүй байх магадлалтай. Гэхдээ энэ асуудлаар судалгаа шинжилгээ хийгдээгүй тул нарийвчлан дүгнэх боломжгүй байна.

2. Монголын нийгэм бол монгол хэлт моноглоссик нийгэм гэсэн ойлголт хүчтэй байна.

Одоогийн байдлаар цөөнхийн хэл, хос хэлний асуудлаар бодлогын түвшинд тууштай ажиллаж байгаа нь боловсролын салбар байна. Хэлний, соёлын, мэдээллийн зохицуулалтуудад цөөнхийн хэлний асуудал дурдагддаг ч бодлогын салшгүй хэсэг гэж хэлж хараахан боломгүй байна. Хос хэл бол зөвхөн боловсролын үйлчилгээний асуудал гэж харах нь Монголын нийгэм нэг хэлт нийгмийн загвартай байгаагийн илрэл, монгол хэлээр дамжуулан үндэсний эх нэгдлийг бэхжүүлэх моногlossик үзэлтэй хэвээр байгаагийн илрэл гэж хэлж болно.

Дэлхийн түүхэнд хэлний бодлогоор дамжуулан улс орны боломж, давуу тал, хөрөнгө нөөцийг зөвхөн тодорхой бүлгийн хүртээл болгох, дарангуйлал, колончлолын нэг зэвсэг болгон ашиглаж байсан үе байсан нь үнэн ч одоо энэ үе нэгэнт түүх болох үлджээ. Өнөөгийн интернэт, хиймэл оюун ухаан, машинд суурилсан орчуулгын технологи зэрэг орчин үеийн харилцаа холбоо, технологийн дэвшил нь хэлний дарангуйлал тогтоох боломжийг бараг үгүй болгожээ. Нөгөө талаас эдийн засгийн интеграцчилал нь олон хэлний мэдлэгийг хүний капитал болгож ашиглах боломжийг нээж байгаа бол глобалчлалын нөлөөгөөр өвөрмөц соёл, хэлийг үнэт зүйл, нийгмийн капитал гэж харах ойлголт хандлагыг бий болгожээ.

Моногlossик нийгмийн загварын нөлөөгөөр монголоор аялгатай ярьсан хүнийг гоочлох, доромжлох, ялгаварлан гадуурхах хандлага гарах эрсдэлтэй. Монголын нийгэм өөрөө олон хэлт нийгэм болохоо хүлээн зөвшөөрч, хуулиараа төрийн албан хэргийг монгол хэл дээр явуулах, харин нийгмийн харилцаа, мэдээлэл,х эвлэн нийтлэлийн орчиндоо гетерогlossик философийг нэвтрүүлэх хэрэгтэй. Гетерогlossик үзэл хандлага нь дотооддоо цөөнхийн эрхийг хамгаалах арга механизм болоод зогсохгүй цөөнхийн хэлээх ярих сонирхлыг өдөөж, дараа дараагийн үед өвлөгдөн хадгалагдах боломжийг өсгөх сайн талтай.

Хос хэлний боловсролын бодлогод бусад салбарын хамтын ажиллагаа, оролцоо чухал бөгөөд салбар дамнасан үзэл хандлагыг бодлогын түвшинд Хэлний зөвлөл зангидаж ажиллах боломжтой харагддаг. Хэл сурахад хэлний орчин чухал үүрэгтэй бөгөөд олон

нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, хэвлэн нийтлэлийн оролцоо чухал юм. Өнөөдрийн байдлаар MN-25 сувгаар казах, тува хэл, буриад аялгаар тус бүр 10 минутын өдрийн мэдээнээс өөр цөөнхийн хэлээр мэдээлэл дамжуулж байгаа үндэсний хэмжээний хэвлэл мэдээллийн хэрэгсэл алга байна. Казах, тува хэл дээр хэвлэн нийтлэл эрхэлж буй төрийн болон төрийн бус хэвлэлийн газар байхгүй тул Казахстан, Оросын Тувагаас зарим нэг хэвлэмэл материал дамжуулж авч байгаа ч үгийг сан зөрөх явдал гардаг байна. Олон нийтийн орчинд, тухайлбал, олон нийтийн хэвлэл мэдээллээр цөөнхийн хэл ашиглагдаж байх нь хэлний цөөнх иргэдэд хэлний орчин, сурахад дэмжлэг болоод зогсохгүй хэлний олонход тухайн хэлийг сонирхох, дэмжих сэдэл төрүүлэх нөлөөтэй байдаг.

Хос хэлний боловсролын хууль эрх зүйн орчны хэрэгжилттэй холбоотой асуудал

Хууль, эрх зүйн орчинд тунхагласан цөөнхийн хүүхдүүдийн эх хэлээрээ боловсрол эзэмших эрхийг хэрэгжүүлэх гол арга механизм бол хос хэлний боловсрол юм. Монголын боловсролын салбар нь хос хэлний үйлчилгээг бий болгож, хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэхэд тууштай анхаарч байгаа нь сайн. Энэ хүрээнд цаатан, мөн казах хүүхдийн боловсролыг дэмжих үндэсний хөтөлбөр хэрэгжүүлж ирсэн туршлагатай бөгөөд Боловсролын хүрээлэн нь үндэстний цөөнх хүүхдүүдийн хос хэлний боловсролын арга зүйг боловсруулах, түгээх чиг үүрэгтэй судалгааны сектор ажиллуулж байна.

Хос хэлний хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэхтэй холбоотой анхаарах асуудлууд байгааг тоймлон жагсаалаа. Үүнд:

1. Хос хэлний боловсролын эрхзүйн орчны хэрэгжилтийг зохион байгуулахдаа нийгмийн бодлого, нийгмийн зорилт талаас бус, тодорхой бүлэг, аймгийн асуудал гэж ойлгон, шийдэх хариуцлагыг орон нутгийн засаг захиргааны нэгжийн түвшинд шилжүүлсэн нь хос хэлний боловсролын далайцтай хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэхэд хүчин мөхсөдөх нөхцөлтэй тулгарч, бодлогын хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байх магадлалтай.

Монголд хос хэлний, ялангуяа хос хэлний боловсролын бодлого нь бүх нийтийн шинжтэй бус зөвхөн цөөнхийн иргэдэд чиглэсэн зорилтот хөтөлбөр хэлбэрээр хэрэгжиж байна. Нийт хүн амын 4 гаруй хувь нь хэлний цөөнх, бусад 95 гаруй хувь нь монгол эх хэлтэн бүрдүүлж буй манай нийгэм хос хэлний бодлогыг үндэсний цөөнхийн эх хэлээ өвлөх, хадгалах, хөгжүүлэх бодлого гэж ойлгож байна. Үүний улмаас хос хэлний боловсролын үйлчилгээ нь зөвхөн Баян-Өлгий аймагт хэрэгжиж, бусад аймаг, хот суурин газарт хэлний цөөнх хүүхдүүд ч эх хэлээ сурах боломжгүй байна.

Цаашилбал, хуулиар хос хэлний боловсролын хөтөлбөрийг БШУ-ны Сайд хариуцан, Боловсролын хүрээлэн зэрэг боловсролын судалгаа шинжилгээний байгууллагын хүчийг ашиглан шинжлэн ухааны үндэслэлтэй хөтөлбөр боловсруулж, батлан, хэрэгжилтийг хянах үүрэгтэй. Гэтэл хос хэлний боловсрол нь зөвхөн Баян-Өлгийд хэрэгжиж байгаа тул салбарын Сайдын уг эрх мэдэл Баян-Өлгийн аймгийн Засаг даргад шилжин хэрэгжиж байна. Гэтэл үндэсний хэмжээний хэлний бодлоготой нягт холбоотой, хоёр хэлний тэнцвэрт харьцааг хангасан сургалтын өвөрмөц арга зүй, хос хэлтэй багш шаардлагатай, сургуулиас гадуур хос хэлний орчноор дэмжин байж үр дүнд хүрэх хос хэлний хөтөлбөрийг бодлогын түвшинд бүрэн хариуцахад аймгийн Засаг даргын хүн хүч, боломж хүрэхгүй байх бүрэн магадлалтай. Тухайлбал, хос хэлний боловсролын хөтөлбөрийг олон хэлний шинэ онолын дагуу боловсруулж багш нарыг хэрэглэх арга зүй болгож боловсруулах Боловсролын хүрээлэн шиг судалгааны хүчин чадал, хос хэлний багш нарын сургах МУБИС шиг тогтолцоо, хос хэлний сургалтын үр дүнг хянах Боловсролын Үнэлгээний Төв шиг механизм аймгийн хэмжээнд бий болгох боломжгүй юм.

Нийт хүн амын дунд цөөнхийн хэлийг цөөнх иргэд хоорондоо харилцахдаа хэрэглэдэг хэмээн ойлгож, нийгмийн харилцаанд ашиглах тухайд сөрөг биш гэхэд эергээр ханддаггүй. Хос хэлний боловсролын асуудал олон нийтийн дунд нэг их хэлэлцэгддэггүй явдал нь тодорхой хэмжээнд Баян-Өлгий аймгийн асуудал гэж ойлгодогтой холбоотой байх магадлалтай хэмээн таамаглаж байна.

2. Хос хэлний боловсрол нь нийгмийн олон талт байдлыг хүндэтгэн үнэлэх хандлага төлөвшүүлэх, ялгаатай байдлыг нийгмийн баялаг гэж ойлгож ханддаг үнэлэмж бий болгох нийгмийн чухал хөтөлбөр тул энэхүү үр нөлөөг бий болгохын тулд нэгэнт хуучирсан нэмэгдэх, хасагдах загварыг халж, орчин үеийн хэлний орчин бий болгох арга зүйд суурилсан рекурсив, динамик загвараар боловсруулах хэрэгцээтэй гэж үзэж байна.

Юуны өмнө, хос хэлний боловсролын олон арван загвар бий. Эдгээрээс сонголт хийхдээ өөрийн орны онцлогийг харгалзах нь зүй ёсны хэрэг болно. Хэтийн зорилт буюу нийгэмд үзүүлэх үр нөлөөг тооцох юм бол хэлний цөөнхийн хүүхэд залуучуудыг эх болон албан ёсны хос хэлтэн болгох зорилгодоо нийцсэн оновчтой загварыг сонгож авах хэрэгтэй ч манайд өнөөдөр энэ хэрэгцээнд хангалттай анхаарахгүй байна.

Харамсалтай нь, өнөөдөр хэрэгжиж байгаа нь хоёр хэлийг бие даасан судлагдахуун болгож судалдаг, мөн чанарын хувьд хуучирсан гэж үзэж болох олон хэлний нэмэгдэх, хасагдах загварт суурилсан хос хэлний боловсролын хөтөлбөр юм.

Тува хүүхдүүд хос хэлний загваруудаас хамгийн үр нөлөө муутайд тооцогддог хасагдах хандлагатай буюу эх хэлээр бичиг үсэгт сургаад, албан ёсны хэл рүү эрчимтэй шилжин, эх хэлээ нэгж хичээлээр судлах ($X1 + X2 - X1 = X2$) хөтөлбөрөөр суралцаж байна. Эх хэлээр сурч эхлээд, албан ёсны хэл рүү шилжих тулгуур болгож ашиглах энэ загвар нь эх хэлийг бүрмөсөн гээхгүй, бие даасан хичээлээр судалсаар байх авч үр дүнд нь эх хэлээ насан туршийн хэрэглээ болгож, дараагийн үедээ өвлүүлэх эсэх нь эргэлзээтэй.

ХҮСНЭГТ 18. Хасагдах хандлагад суурилсан шилжилтийн хос хэлний боловсролын хөтөлбөрийн загвар: монгол, тува хос хэлний боловсролын жишээ

Анги	Эх хэл X1	Хоёрдогч хэл X2/ ихэнхдээ албан ёсны хэл
СӨБ	Сургалтын хэл	
1 дүгээр анги	Сургалтын хэл	Уншиж, бичиж сурах
Эхний хагас жил		
Сүүлийн хагас жил		
2 дугаар анги	Сургалтын хэл	Математик
Эхний хагас жил		
Сүүлийн хагас жил		
3-12 дугаар анги	Бие даасан хичээл	Сургалтын хэл

Хасагдах загварын хос хэлний боловсрол нь бага ангид нэг хэлнээс өөр хэл рүү огцом шилжсэний улмаас сурлагаар хоцрох, сургууль завсардах, цаашилбал, эх болон албан ёсны хэлний аль алийг хангалттай сайн эзэмшиж чадахгүйд хүргэх эрсдэлийг хажуугаар үр нөлөөний хувьд сургуульд эх хэл (X1)-ний ур чадвараа хангалттай хөгжүүлж чадаагүй хүүхдүүд насанд хүрсэн хойноо нийгмийн харилцаанд огт ашиглахгүй зөвхөн ахуй, гэр бүлийн орчинд хэрэглэх, үр хүүхдэдээ дамжуулах өвлүүлэх нь бага, улмаар хэлний цөөнхийн залуучууд эх хэлээ гээх эрсдэл дагуулдаг байна. Сайн тал нь албан ёсны хэлээр харилцах нийгмийн харилцаанд асуудал багатай, нийгэмшиж, ажил хөдөлмөр эрхлэхэд хэлний асуудал үүсэхгүй байх тал бий. Хасагдах загварын боловсролын бодлого хэрэгжүүлэхээс аль болох татгалзахыг судлаачид зөвлөж байгаа ч тува иргэд Баян-Өлгий аймагт цөөнхийн дундах цөөнх болж амьдарч байгаа тул монгол хэлт хэмээх ижилслээ хадгалах үүднээс эрт шилжилттэй хасагдах загварыг бодлогыг дэмжих хандлагатай байдаг. Цаатан хүүхдүүдийн хос хэлний боловсрол мөн л эрт шилжилттэй хасагдах загвартай байна.

Казах хүүхдүүдийн хос хэлний боловсролын бодлого нь үр нөлөөний хувьд хасагдах загвараас хавьгүй илүү нэмэгдэх хандлагаар боловсруулагджээ. Монголд казах хүүхдүүдийн хос хэлний боловсролыг хэрэгжүүлж буй арга практик нь Өвлөгдөх (Дэмжин хөгжүүлэх гэж бас нэрлэдэг) хос хэлний боловсролын арга хандлагатай хамгийн ойр байна:

ХҮСНЭГТ 19: Нэмэгдэх хандлагад суурилсан, дэмжин хөгжүүлэх зорилготой хос хэлний хөтөлбөрийн загвар: монгол, казах хос хэлний хэлний хөтөлбөр

Анги	Эх / казах хэл X1	Албан ёсны/ монгол хэл X2
СӨБ	Сургалтын хэл	
1-3 дугаар анги	Сургалтын хэл	
4-12 дугаар анги	Сургалтын хэл	Сонгосон хичээлүүд

Хос хэлний уг загвар нь үр нөлөөний хувьд эх хэлний хэрэглээг гэр бүлийг хүрээнээс тэлж нийгэм, соёлын орчин, албан ёсны харилцаанд ашиглахыг дэмжихийн зэрэгцээ эх хэлний үнэ цэнийг хадгалж үр хүүхдэдээ өвлүүлэх хүсэл эрмэлзлийг дэмждэг байна. СӨБ, бага ангийн түвшинд сургалт хүүхдийн эх хэл дээр явагдах бөгөөд албан ёсны хэлийг тусдаа хичээлээр зэрэгцүүлэн, боломжтой бол хос хэлний багшаар заалгах нь хамгийн үр дүнтэй. Бага боловсролын сүүлийн ангиудад онолын бус агуулгатай хичээлүүд, цаашдаа дунд боловсролын түвшинд хөтөлбөрийн багагүй хэсгийг албан ёсны хэл дээр заах бөгөөд эх болон албан ёсны хэлээр заагдах хичээлийн тоог, эсвэл нэгж хичээл дээр хэрэглээг нь тэнцвэртэй байлгах нь сурагчдын хувьд илүү үр дүнтэй арга зүй болно. Харамсалтай нь, казах хүүхдүүдийн боловсролын хөтөлбөрт энэхүү тэнцвэр хэр хангагдсан тухай судалгаа үнэлгээ байхгүй, казах болон монгол хэл дээр заагдах хичээлийн харьцаа, шилжилтийн стратеги нь тодорхойлогдоогүй байна. Хос хэлний сургалтын хөтөлбөрийг Боловсролын хүрээлэнгээс судалгаа, шинжилгээнд түшиглэн боловсруулж, БШУ-ны Сайд батлан хэрэгжүүлэх хуультай ч одоогоор аймгийн удирдлагуудад энэ чиг үүргийг шилжүүлсэн бөгөөд судалгаа, арга зүйн дэмжлэгийг хангаж өгөөгүйн улмаас сурагчдын ачааллыг оновчтой болгох

зорилтын хүрээнд монгол хэлний цаг хасагдсан нь хоёр хэлний тэнцвэр алдагдах нөхцөл болж байх магадлалтай.

Гэхдээ нэмэгдэх болон хасагдах загварын аль аль нь орчин үеийн хэл шинжлэл, боловсрол, нийгмийн сэтгэл зүйн шинжлэх ухааны чиг хандлага, хос хэлний боловсролын онолтой нийцэхгүй болтлоо нэгэнт хуучирчээ.

Дэлхийн хэл сурах арга зүй хувьсан өөрчлөгдөж, хос хэлний хөтөлбөрийг шинэ загварууд бий болсоор байна. Хэлний нэмэгдэх болон хасагдах загварын аль аль нь орчин үеийн хэл шинжлэл, боловсрол, нийгмийн сэтгэл зүйн шинжлэх ухааны чиг хандлага, хос хэлний боловсролын онолтой нийцэхгүй болтлоо нэгэнт хуучирсан бөгөөд хэлийг судлагдахуун буюу бие даасан хичээл болгож судлах нь үр дүн муутай, хүүхдийн эх хэлийг төрийн албан ёсны хэлэнд суралцах суурь болгож ашиглах нь цөөнхийн хэлийг үнэгүйдүүлэх сөрөг нөлөөтэй, хэлийг цөөн цагийн хуваарьт хичээлээр судлах нь хэлний хэрэглээг бий болгож чадахгүй тул хэл эзэмшилтийн үр дүн муутай зэрэг дүгнэлт нь хос хэлний боловсролын арга зүйн болон хөтөлбөрийн шинэчлэл хийхэд түлхэж байна. Хэл сурахад зорилтот болон эх хэлний зэрэгцээ хэрэглээг дэмжсэн дэвшилтэт рекурсив, динамик зэрэг загварын арга зүй улам хүчээ авч, хос хэлний боловсролын хөтөлбөрт үр дүнтэй ашиглагдаж байгаа туршлага бий болж байна. Манайд Боловсролын хүрээлэн нь рекурсив загварын нэг арга зүй болох АХИС-ын арга зүйг Баян-Өлгийн хос хэлтэй сургуулиудад туршиж байгаа болно.

3. Хос хэлний боловсролын арга зүй, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн зэрэг дэд бүтцийг төлөвлөн бүрдүүлэх, мэргэжлийн багш бэлтгэх, сургуулиас гадуурх хэлний орчныг бий болгох зэрэг сургалтын үндсэн болон дэмжих орчин нөхцөлийг хөгжүүлэх хэрэгцээ тулгамдаад байна.

Хос хэлний боловсролын чанарт сургалтын орц гэж нэрлэдэг сургалтын хөтөлбөр төлөвлөгөө, сурах бичиг, мэргэжлийн багш, сургалтын хэрэглэгдэхүүн чухал нөлөөтэй. Монгол Улсын хэмжээнд хос хэлний мэргэжлийн багш байхгүй, тува хэлт хүүхдүүдийн хос хэлний боловсролд ашиглах сурах бичиг байхгүй, казах хэл

дээр сурах бичиг хүртээмж муутай, багш нарын мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх сургалтын хөтөлбөр алга байна. Мэргэжлийн багшгүй, сурах бичиггүй, сургалтын хэрэглэгдэхүүнгүй байгаа нь олон шалтгаантай ч хүүхдийн сурч боловсрох эрхийг хангах үүргийг хүрээнд жил бүр төлөвлөн хэрэгжүүлэх замаар дунд хугацаандаа ахиц гарган шийдэх шаардлагатай асуудал юм.

5. Хос хэлний боловсролын хэрэгжилтэд БШУЯ хяналт мониторинг хийж, боловсролын үр дүнг хариуцах үүргээ хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Хос хэлний боловсролын хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн мониторинг, хяналтын мэдээ нь боловсролын салбарын албан ёсны тайлан мэдээнд задаргаатай тусахгүй байгаа байгаа бололтой. Энэ нь хос хэлний боловсролын хөтөлбөрийг баталж, хянах чиг үүрэг Баян-Өлгий аймгийн засаг захиргаанд шилжүүлснээр БШУЯ-ны анхаарал, хяналт суларсантай холбоотой байж болох талтай.

ЗӨВЛӨМЖ

УИХ-ын анхаарах асуудал:

- ▶ Үндэсний цөөнхийн эх хэл, соёлоо хадгалах, эх хэлээрээ сурч боловсрох эрхийг баталгаажуулсан Үндсэн хуулийн үзэл баримтлалыг тууштай хангах үүднээс Төрийн албан ёсны хэлний тухай, Монгол хэлний тухай, Боловсролын тухай, Сургуулийн өмнөх боловсролын тухай багц хууль, Соёлын тухай хуулиудад шинжилгээ хийж, эх хэл, төрөлх хэл гэсэн нэр томъёог цэгцлэх
- ▶ “Төрийн албан ёсны хэлний тухай” хуулийн 5.13 болох “Бүх шатны боловсрол олгох сургалтыг төрийн албан ёсны хэлээр явуулна. Энэ заалт үндсэн ба мэргэжлийн сургалтаа гадаад хэлээр явуулдаг сургалтын байгууллагад үл хамаарна” гэснийг “Бүх шатны боловсрол олгох сургалтыг төрийн албан ёсны хэлээр явуулна. Энэ заалт хос болон олон хэлээр сургалт явуулдаг сургалтын байгууллагад үл хамаарна” гэж өөрчлөн найруулах
- ▶ Хос хэлний боловсролын бодлого, хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавихад сонирхлын бүлэг, олон нийтийн оролцоог хангах, олон нийтийн оролцооны арга механизмуудыг ажиллагаанд оруулах. Жишээлбэл, хос хэлний боловсролын асуудлаар УИХ нээлттэй сонголт хийх, Баян-Өлгий аймгийн ИТХ хэлний цөөнх хүүхдүүдийн боловсролын асуудлаар нээлттэй сонголт хийх, Багшийн хөгжил болон сурах бичгийн бодлогын хэрэгжилтийг хянах ажлын хүрээнд хос хэлний багш, сурах бичгийн асуудлаар хэлэлцүүлэг хийх, Хэлний зөвлөлийн ажил цөөнхийн хэлний асуудлыг тусгах зэрэг болно.
- ▶ Хос хэлийг хөгжүүлэх хэлний орчныг хүүхдийн хөгжлийн онцлог тохирсон шинжлэх ухаанч, танин мэдэхүйн арга зүй, хөтөлбөр, агуулгыг бэлтгэн олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, цахим сан хэлбэрээр хүргэх, хөгжүүлэх, түгээх

- ▶ Казах, тува хэл дээр хэвлэн нийтлэлийн бүтээгдэхүүн гаргахад тодорхой хэмжээгээр төсвийн дэмжлэг үзүүлэх

Засгийн Газрын анхаарах асуудал:

- ▶ Хос хэлний боловсролын хөтөлбөр батлах, хэрэгжилтийн явцыг хянах ажлыг БШУС-д хуулийн дагуу хариуцуулан, юуны өмнө дараах арга хэмжээг цаг алдалгүй гүйцэтгүүлэх:
 - ▶ Үр нөлөөтэй хос хэлний рекурсив, динамик, нэмэгдэх загвар хослуулсан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, арга зүй, санхүүжилтийн механизм, хэлний орчин, сургалтын дэд бүтэц зэргийг богино хугацаанд судлан хэрэгжүүлэх, цаашилбал, хос хэлний боловсролын судалгаа, сургалт, арга зүй, үнэлгээний хүний нөөцийг бүрдүүлэх
 - ▶ Хос хэлний боловсролын хөтөлбөрийн хувилбаруудыг Боловсролын хүрээлэн, их дээд сургууль, иргэний нийгмийн судлаач, цөөнхийн бүлгийн иргэд, сонирхлын бүлгүүдийг оролцуулан боловсруулах, хэлэлцүүлж батлах, хэрэгжилтийг хянах
 - ▶ Хос хэлний боловсролд ашиглах сурах бичгийн бодлогыг гаргаж, чанартай хэрэгжүүлэхэд хяналт тавих
 - ▶ Хос хэлний боловсрол, АХИС арга зүйг турших, үр дүнг тооцох үйл явцын талаар бодлого боловсруулагч, боловсролын салбарын мэргэжилтэн, эцэг эх, иргэний нийгмийнхэн, сурагч, сонирхогч талуудад мэдээлэх, сургалтад нэвтрүүлэх
 - ▶ Монголын хос хэлний боловсролын талаарх гадаад, дотоодын судлаач, олон улсын болон иргэний нийгмийн судалгаа, мэдээллийг нэгтгэх, хэлэлцүүлэх, багш нарт хүргэх ажлыг зохион байгуулах
- ▶ Казах, тува, цаатан хүүхэд, залуучуудын хос хэлний боловсролын хүртээмж, чанарыг хэмжих үзүүлэлтүүд гаргаж, мониторинг үнэлгээний зорилгоор тогтмол ашиглах, олон нийтийн орчинд статистик өгөгдөл болгож гаргаж байх
- ▶ Цөөнх хүн ам төвлөрөн амьдарч буй Баян-Өлгий аймгаас бусад орон нутаг, хот суурин газар хэл, соёлын цөөнх иргэд хос

хэлээр боловсрол, соёлын үйлчилгээ авах боломжийг хангах, олон нийтийн сонирхол, дэмжлэгийг бий болгох

- ▶ Хос хэлний багш бэлтгэх, одоо ажиллаж байгаа багш нарт мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх ажлыг хариуцан зохион байгуулах. Энэ хүрээнд дараах ажил багтах бөгөөд үүнд:
 - ▶ Казах, тува хүүхдүүдийн хос хэлний боловсролын үйлчилгээг хүргэх хос хэлт болон хос хэлний багш бэлтгэх сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх
 - ▶ Оюутан-багш, одоо ажиллаж байгаа багш бүрт хос хэл, олон хэлний талаар онол, арга зүйн мэдлэг, АХИС арга зүйг эзэмшүүлэх
 - ▶ Хос хэлний орчинд ажиллаж байгаа хот, хөдөөгийн багш нарын мэргэжлийг дээшлүүлэх сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах, тогтмолжуулах

НОМ ЗҮЙ

1. Baker, C. (2006). Foundations of Bilingual Education and Bilingualism. Multilingual Matters. Clevedon, UK.
2. Vučo, J. F. (редактор) (2017). Minority Languages in Education өгүүлэл. Learning Challenges and Perspectives амхэтгэл, University of Belgrade Council of Europe (2020). Good practices of multilingual and minority language medium education.
3. Garcia, O. (2008). Biligual Education in the 21st Century: Global Perspective.
4. Hurajova, A. (2015). An overview of models of bilingual education. Mediterranean Journal of Social Sciences.
5. issues, U. N. (2017). Language Rights of Linguistic Minorities. A Practical Guide for Implementation.
6. OSCE. (1996). The Hague Recommendations regarding the Education Rights of National Minorities & Explanatory Note.
7. UNICEF. (2011). The Right of Roma Children to Education. Position Paper.
8. Монгол Улсын Засгийн газар (2020). Алсын Хараа 2050. Улаанбаатар.
9. Д. Бадарч (2021). Дээд боловсролын онол, арга зүй: Парадигмийн шилжилт, багшлахуй, суралцахуй. Улаанбаатар.
10. Боловсролын хүрээлэн (2022). Хөвсгөл аймгийн угсаатны ялгаатай бүлгийн хүүхдийн (тува - цаатан) эх хэл, соёлоо эзэмших нөхцөл байдлын талаар цуглуулсан мэдээллийн нэгтгэл, үр дүн. Улаанбаатар.
11. Выгодский, Л. (1960). Развитие высших психических функций. Москва.
12. Х.Гансүх (2021). Багшийн хөгжил ярилцлага. Улаанбаатар.
13. Ж.Зульмира, Б.Алтангул, Б.Ардак, Г.Чулуун-Эрдэнэ, Б.Бахатгул, Д.Тунгалаг (2021). Хос хэлний боловсролын өнөөгийн нөхцөл байдал. Улаанбаатар.

14. Хүний эрхийн үндэсний комисс (2010). Казах, тува хүүхдүүдийн сурч боловсрох эрх, хөдөлмөр эрхлэлтийн байдал. Улаанбаатар.
15. (огноо байхгүй). Монгол Улсын боловсролын Мастер төлөвлөгөө 2021-2030.
16. Тува ээж ТББ (2022). Тува хүүхдийн хос хэлний боловсролын чанар, хүртээмж. Улаанбаатар.
17. УТуяа (2022). Хос хэлний боловсролын бодлого, чиглэл. Улаанбаатар.
18. Үндэсний Статистикийн Хороо (2010). 1212.mn.
19. ҮСХ. (2020). <https://1212.mn>
20. ГЧулуун- Эрдэнэ (2021). Монгол Улс дах хос хэлний нөхцөл байдлыг нийгэм хэл шинжлэлийн үүднээс судлах нь. Улаанбаатар.
21. ЮНЕСКО (2019). Монголын боловсролын бодлогын тойм шинжилгээ: Насан туршийн суралцахуйн тогтолцоог бүрдүүлэх нь. Улаанбаатар.
22. БСШУСЯ, Боловсролын хүрээлэн, ЮНЕСКО (2019). Монгол Улсын боловсролын суурь мэдээллийн тайлан. Улаанбаатар: Гоо дизайн ХХК

ISBN 991999902-4



9 789919 999025